



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-7
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	8-91
1.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/	8-9
2.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан	9-53
3.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар/	54-76
Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан /үргэлжлэв/	76-91

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
03 дугаар сарын 28-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 68 гишүүн хүрэлцэн ирж, 54.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ч.Анар, М.Бадамсүрэн, Д.Батбаяр, Э.Батшугар, Ж.Баярмаа, Ж.Галбадрах, Л.Гантөмөр, Ц.Даваасүрэн, Г.Дамдинням, Б.Дэлгэрсайхан, Ж.Золжаргал, Н.Наранбаатар, Д.Пүрэвдаваа, Ж.Энхбаяр, Д.Энхтүвшин;

Чөлөөтэй: Б.Найдалаа, Н.Номтойбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан, А.Ганбаатар, М.Сарнай, Л.Энхнасан;

Тасалсан: С.Лүндэг;

Хоцорсон: Н.Алтанхуяг -11 минут, Н.Алтаншагай -39 минут, Б.Батбаатар -14 минут, Х.Баттулга -01 минут, Б.Батцэцэг -08 минут, Ж.Баясгалан -01 минут, Х.Булгантуяа -08 минут, С.Ганбаатар -11 минут, Д.Ганмаа -07 минут, Т.Доржханд -08 минут, Б.Жавхлан -1 цаг 10 минут, Б.Жаргалан -14 минут, П.Мөнхтулга -06 минут, Ц.Мөнхтуяа -3 цаг 14 минут, З.Мэндсайхан -03 минут, М.Нарантуяа-Нара -02 минут, Ч.Номин -07 минут, Э.Одбаяр -04 минут, Б.Пунсалмаа -50 минут, Р.Сэддорж -2 цаг 37 минут, Ц.Туваан -01 минут, Х.Тэмүүжин -12 минут, А.Ундраа -01 минут, Н.Учрал -05 минут, Г.Уянгахишиг -45 минут, Д.Цогтбаатар -1 цаг 13 минут, Б.Чойжилсүрэн -34 минут, Л.Энх-Амгалан -06 минут, С.Эрдэнэбат -13 минут, Р.Эрдэнэбүрэн -1 цаг 36 минут.

Нэг.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг Улсын Их Хурлын гишүүдийн дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлсэн үгээр үргэлжлэв.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа хуулийн төслийг дэмжиж үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 28
Бүгд: 80
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Х.Баярмаа, Б.Сандуйжав, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Эрүүл мэндийн

яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Жавхланбаатар, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, мөн яамны Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын захирал Д.Тэгшжаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ж.Өнөржаргал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Мөнхзул, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ч.Энх-Амгалан, Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтантуяа, мөн газрын зөвлөх Б.Отгонсүрэн, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хороодоос гаргасан хамтарсан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нар тус тус танилцуулав.

Танилцуулга болон аудитын тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, Б.Пүрэвдорж, М.Ганхүлэг, У.Отгонбаяр, С.Цэнгүүн, Г.Лувсанжамц, О.Батнайрамдал, Ц.Идэрбат нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан, Боловсролын сайд П.Наранбаяр, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт үг хэлэв.

Үдийн завсарлагааны цаг болсон тул үдээс өмнөх хуралдаан 2 цаг 52 минут үргэлжилж, 12 цаг 52 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 13 цаг 32 минутад эхлэв.

Гурав.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбар дундын уялдааг зохицуулах хэлтсийн дарга Э.Бат-Идэр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Уртнасан, мөн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Мөнхзул, мөн газрын ахлах шинжээч С.Баярцэцэг, Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Уур амьсгалын өөрчлөлтийн хэлтсийн дарга Н.Цогзолмаа, мөн хэлтсийн шинжээч Ц.Мөнхбат, Усны газрын дарга З.Батбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтантуяа, мөн газрын зөвлөх Б.Отгонсүрэн, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Ч.Онончимэг, мөн газрын ахлах референт Д.Энхмаа нар байлцав.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаарх мэдээллийг хийв.

Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа, Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар нар индрээс үг хэлэв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 122.11-д заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат, Улсын Их Хурал дахь

Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг нарын тавьсан асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Уртнасан, мөн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Мөнхзул, Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаарх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 14 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан /үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын аудитын менежер Х.Баярмаа, Б.Сандуйжав, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Жавхланбаатар, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

Ж.Ганбат, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, мөн яамны Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын захирал Д.Тэгшжаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Ж.Өнөржаргал, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Мөнхзул, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ч.Энх-Амгалан, Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Алтантуяа, мөн газрын зөвлөх Б.Отгонсүрэн, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Танилцуулга болон аудитын тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, О.Цогтгэрэл, М.Мандхай, Д.Үүрийнтуяа нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан сайд нар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд байлцах бөгөөд Засгийн газрын гишүүдийн ирц хангалтгүй байгаа тул хуралдааныг өндөрлүүлэв./15:52/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 12 минут үргэлжилж, 126 гишүүнээс 104 гишүүн хүрэлцэн ирж, 82.5 хувийн ирцтэйгээр 15 цаг 52 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өглөөний амар амгаланг айлтгая. 68 гишүүн бүртгэгдэж, ирц 54 хувь хүрсэн байна. 2025 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 4 асуудал хэлэлцэнэ. 1 дүгээрт Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. 2 дугаарт Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 24 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 24 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэнэ. 3 дугаарт Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын өнөөгийн байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно. 4 дүгээрт баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэв/

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлэхээр байгаа Энхбатын Болормаа гишүүн үг хэлнэ. Энхбатын Болормаа гишүүн байна уу? 1 дүгээр индэр дээр урья, үг хэлнэ.

Э.Болормаа: Эрхэм гишүүддээ энэ өглөөний мэнд хүргэе. Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай буюу амь нас, мал сүргээ хамгаалах зорилгоор чоно агнасан бол энэ хуулийн 25.1 дэх заалт хамаарахгүй гэсэн энэ асуудлыг МАН-ын бүлгийн зүгээс дэмжиж байгаа. Сая чуулганы завсарлагааны үеэр МАН-ын бүлгийн Улсын Их Хурлын гишүүдийн олонх тойрогтоо ажиллаж, хөдөө орон нутгаар болон Улаанбаатар нийслэл хотоор ажилласан. Хөдөө орон нутгаар ажилласан гишүүдийн хувьд чонон асуудал мөн үүнээс гадна ирвэсийн асуудлыг олон иргэд хөндөж ярьсан. Миний зүгээс гэхэд Увс аймагт жишээлбэл Өлгий сумд Авгайн гуай, Увс аймгийн Түргэн сумд Баярмаа, Ховд аймгийн Алтай сумд Баярхүү гуай гэх мэтчилэн олон малчид зөвхөн энэ асуудлыг онцлон хэлэлцэх гэж иргэдийн уулзалтыг хөдөөгөөс зорьж суман дээр зорин хүрэлцэн ирсэн байгаа. Тэгэхээр энэ удаа нэг зүйлийг онцлон хэлэхэд одоогийн байдлаар сүүлийн жилүүдэд Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яам яг энэ асуудлыг шийдэл байдаг. Гэхдээ энэ нь аягүй явцтай, иргэд зөвшөөрөл явж авах ёстой

байдаг. Жилээс жилд байгаль орчны сайдын журмыг хүлээдэг. Тэгж мал сүргийн бүтцийг өөрчлөх зорилгоор чоно агнах зөвшөөрөл авдаг байгаа.

Тэгэхээр парламентын 3 төгөлдөршлийн зорилтын хүрээнд энэ асуудлыг илүү хөнгөвчлөх гэсэн төрийн олон шат дараатай энэ дамжлагыг алгасах гэсэн зориулалтаар хөнгөвчилсэн энэ 25.1 гэсэн энэ заалтыг оруулж ирж, энэ 25.7 гэсэн заалтыг оруулж ирж байгаад талархалтай байна. Тэгээд цаашдаа ч гэсэн олон хуулийн төслүүд яг өдөр тутмын иргэдийн амьдралд эдгээр нөгөө хууль давсан журмууд болон энэ уялдаа хангагдаагүй эсвэл илүү их иргэдэд дарамт учруулдаг энэ зөвшөөрлийн асуудлуудыг хөнгөвчлөхийн нэг жишээг өнөөдөр бид хэлэлцэж байгаад баяртай байна.

Харин цаашид энэхүү заалт иргэд амь насаа болон мал сүргээ хамгаалах зориулалтаар зөвшөөрөл шаардлагагүй гэдэг энэ заалтыг бусад зүйлсээр магадгүй ашиглах чоно агнах зөвхөн зориулалтаар спортоор байна уу бусад зориулалтаар ашиглах энэ зүйлийг хумих талаас Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам мөн орон нутгийн хэмжээнд энэ хуулийг буруу талаас нь ашиглахгүй байх талаас нь онцгойлон хэрэгжилт дээр анхаарч ажиллаасай гэж хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гишүүд үг хэлж дууслаа. Байнгын хорооны саналаар Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн дэмжих эсэх талаар санал хураалтыг явуулна. Санал хураалт. 52 гишүүн буюу 65 хувиар хэлэлцэхийг дэмжлээ. Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

10.05

**Хоёр.Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,
Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны
хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын
хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан**

Дараагийн асуудалд орёе. Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэнэ. Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 24 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн дагуу Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг та бүхэн

тоймлон танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүд та бүхэнд хэвлэмэл байдлаар дэлгэрэнгүй тайлан тараагдаж, ЗГ-ын гишүүд асуултад хариулах тул тайлант хугацааны логик холбоос талаас тайлбарлах нь зүйтэй гэж үзэж байна.

Монголчууд бид шинэ Үндсэн хуулиа баталж ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш 30 жилийн хугацааны амжилт ололт, алдаа оноогоо нэгтгэн дүгнэж шинэ 30 жилийн хөгжлийн бодлогыг сонгуулийн циклийг давж урт хугацаагаар төсөөлөхийн тулд олон улсын нийтлэг жишигт тулгуурлан Алсын хараа 2050 хөгжлийн бодлогыг улс төрийн намууд, холбогдох яам, агентлагийн мэргэжилтнүүд, эрдэм шинжилгээ, мэргэжлийн байгууллагын 1500 гаруй эрдэмтэн судлаачдын төлөөлөлтэйгөөр 1,5 жилийн хугацаанд боловсруулан тухайн үед батлуулж байсан. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогыг батлан хэрэгжүүлж эхэлснээс хойш өнөөдөр 5 жилийн хугацаа өнгөрч, 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 21-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг энэ жил цогц байдлаар үнэлэгдэх хугацаа дөхөж байна. Нэг үгээр хэлбэл 5 сарын 13-нд 5 жилийн тайлан, дүгнэлтийг сонсоно гэсэн үг.

Өнгөрсөн 5 жилийн хугацаанд цар тахал, Оросын Холбооны Улс, Украйны дайн зэрэг олон улсын геополитикийн нөхцөл байдал нэн тогтворгүй байсан ч хөгжлийн бодлогод тусгагдсан суурь асуудлууд шийдвэрлэгдэж, Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн тайлан хяналт шинжилгээний үнэлгээний дүнгээр 67 хувьтай байна гэж дүгнэж байна. Урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг анх удаа шалгуур үзүүлэлттэйгээр боловсруулагдаж, 5 жилийн үнэлгээ гарч байгаа тул төрийн байгууллагуудын тоон мэдээлэл, аргачлал зөрөх зэрэг асуудлууд гарч байгааг үгүйсгэхгүй. Гэвч энэ нь цаашдын зөв үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх суурь болж төлөвшинө гэдэгт итгэлтэй байна. Бодлогын хэрэгжилтийг үр дүнтэй болгох, хяналт, мониторингийн үнэлгээний тогтолцоог олон улсын жишигт хүргэх зорилгоор ЗГ-ын бүтцэд DME буюу design monitoring evolution буюу хяналт үнэлгээ хариуцсан ЗГ-ын гишүүнийг томилон ажиллуулж байна.

Цаашид хяналт үнэлгээний тогтолцоог олон улсын жишигт хүргэх, Улсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг уялдуулан үнэлэх чиглэлээр олон улсын үнэлгээний цогц систем нэвтрүүлэх нь чухал болохыг онцлон тэмдэглэе. Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан үндэсний нэгдмэл үнэт зүйл, хүний хөгжил, амьдралын чанар ба дундаж давхарга, эдийн засаг, засаглал, ногоон хөгжил, амар тайван, аюулгүй нийгэм, бүс, орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн үндсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилтыг дэвшүүлж 243 багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан.

Үндэсний нэгдмэл үнэт зүйл зорилгын хүрээнд Монгол түмний үндэсний бахархал, үнэт зүйлс, төрт ёс, түүхэн уламжлал, ирээдүйн хүсэл тэмүүллийн огтлолцол бол Монголын эзэнт гүрний их түүх, Их эзэн Чингис хааны үйл хэргийг биет болон биет бус хэлбэрээр сурталчлан таниулах гэж тус бодлогын баримт бичигт тусгасан. Мөн Монгол Улсыг дэлхий нийтэд сурталчлан таниулах Чингис хааны музей өөдөө тэмүүлэх Монгол буюу Go Mongolia үндэсний брэндингийн олон улсын сурталчилгаа, нүүдэлчин ахуйг сурталчилсан соёлын арга хэмжээнүүд

тодорхой үр дүнд хүрч, Монгол Улсын талаарх ойлголт 57 хувь, Монгол Улсын талаарх эерэг ойлголт 57 хувиар нэмэгдэж, зөөлөн хүчний бодлогын индекс өнгөрсөн 5 жилийн хугацаанд 14 байраар урагшилсан байна.

Хүний хөгжлийн зорилтын хүрээнд тайлант хугацаанд дэлхий нийтийг хамарсан цар тахлын гамшгийн үе тохиолдсон ч ЗГ хүн амын 90 орчим хувийг вакцинжуулснаар 20-оос 40 мянган хүний амь насыг эрсдэлээс хамгаалж, 1,3 жилийн өмнө хатуу хөл хориог цуцалсан улс орнуудын нэг болж цар тахлыг эрсдэл багатай даван туулсан. Орон даяар зохион байгуулсан эрт илрүүлгийн оношилгоонд 1,5 сая хүн хамрагдсан нь нийт хүн амын 44 хувийг эзэлж, эрүүл мэндийн салбарт 5 жилд өмнөх 10 жилтэй тэнцэхүйц хэмжээний буюу 953,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Энэ нь дийлэнх нь оношилгооны тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Улсын хэмжээнд 2020-оос 2024 онд 197 сургууль, 285 цэцэрлэгийг ашиглалтад оруулсан. Улаанбаатар хотын 27 хорооны 26,8 мянган хүүхдийг цэцэрлэгт хамруулах асуудлыг шийдвэрлэж, цэцэрлэгийн хугацааг сугалааг халж хүсэлт гаргасан хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бүрдүүлсэн. Мөн энэхүү бодлогын баримт бичгийн хүрээнд ирэх жил боловсролтой холбоотой цогц хөрөнгө оруулалтын жил болох нь зүйтэй гэж ЗГ-аас төлөвлөж байгаа юм.

Амьдралын чанар ба дундаж давхарга зорилтын хүрээнд ЗГ-аас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг Улсын Их Хурлаар батлуулан уул уурхайн стратегийн ордуудын 34 хувьд ноогдох ноогдол ашгийг иргэдийн хуримтлалын дансанд олгох хуримтлалын сангийн тогтолцоог бүрдүүлж, мөн хөгжлийн сан иргэдийн амьдралын чанарын асуудал болсон 3 суурь асуудалд зарцуулагдахаар тусгагдсан. Энэ бол эрүүл мэнд, боловсрол, орон сууц. Хууль батлагдсанаас хойш төрийн өмчийн компаниудаас 495,6 тэрбум төгрөгийн хуримтлал иргэдийн хадгаламжид төвлөрсөн байдалтай байна. Энэ эх үүсвэрээр 5 мянга орчим иргэдийн ипотекийн зээлийг санхүүжүүлж, Үндэсний баялгийн сангийн хуримтлалын сангаар дамжуулж иргэдийн орон сууц, боловсрол, эрүүл мэндийг дэмжих бодлогыг гарган Чингис хаан баялгийн сан байгуулагдан ажиллаж байна.

Эдийн засгийн зорилтын хүрээнд Монгол Улсын эдийн засаг өөрөө өөрийгөө тэтгэдэг байх, өрх бүхэнд илүү хүртээмжтэй байх ийм зорилтууд тавигдаж, нэг тулгууртай эдийн засгийн бодлогыг хэрхэн тэлэх вэ гэдэг ийм томоохон зорилтыг дэвшүүлсэн. Монгол Улс эдийн засгаа тэлэх, боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, эдийн засгаа төрөлжүүлэх, аялал жуулчлал, зам тээвэр, тээвэр логистикийн салбарыг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх ийм зорилтууд тавигдсан. Энэ хүрээнд Монгол Улсын ЗГ-аас 2023-аас 25 оныг Монголд зочлох жил болгон зарлаж, 2023 онд 0,6 сая, 2024 онд 0,8 сая жуулчин хүлээн авсан нь дээд амжилт болж, салбарын жилийн орлого 1,5 тэрбум ам.долларт хүрсэн.

Мянганы зам төсөл 21 жилийн дараа амжилттай хэрэгжиж, Монгол Улс бүх аймгаа Улаанбаатар хоттой 7000 гаруй километр үргэлжилсэн хатуу хучилттай авто замаар бүрэн холбосон. Одоо аймгийн төвүүдийг хооронд нь боомттой холбох зорилт хэрэгжиж байна. Чойбалсан, Багануур, Эрдэнэбүрэн, Бөөрөлжүүт, Тосон зэрэг цахилгаан станцын төслүүдийг хэрэгжүүлж эрчим хүчний эх үүсвэр хүчин чадлыг 358мвт-аар нэмэгдүүлсэн. Ковидын үед эдийн засгийн өсөлт -4,6 хувь байсан бол 2023 онд 7,4, 2024 онд 4,9 хувьтай хэрэгжиж байна. Зорилтот түвшин 4-өөс 6 хувьтай тогтмол өсөх ийм зорилтыг урт хугацааны хөгжлийн

бодлогод тусгасан байгаа. Сүүлийн 4 жилд Монгол Улсын экспортын орлого 2 дахин өсөж, ДНБ 37,4 их наядаас өнөөдрийн байдлаар 80 их наяд болж нэмэгдсэн. 1 хүнд ноогдох ДНБ 2020 онд 4121 ам.доллар байсан бол 3 жил дараалан тогтмол өсөж 2023 оны байдлаар 6008 ам.долларт хүрсэн. 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 6890 ам.долларт хүрнэ гэсэн ийм статистик мэдээлэл байна. Фитч зэрэг олон улсын агентлагуудын зэрэглэл тогтоогч агентлагаас 2024 оны зээлжих зэрэглэлийг нэг шат ахиулж, Монгол Улс одоогоор В тогтвортой хэмээх зэрэглэлд шилжсэн. Энэ зэрэглэлийг бид цаашид ахиулах тал дээр ажиллаж байгаа.

Тухайн үед тавигдаж байсан засаглалын зорилтын гол асуудал парламентын ардчиллыг бэхжүүлэх, улс төрийн намууд зөвшилцөж сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэх, мөн жендерийн төлөөллийг хангах зэрэг ийм зорилтууд яригдаж байсан. Ингээд 2023 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орж, парламентын гишүүдийн төлөөлөх чадвар нэмэгдэж, мөн холимог тогтолцоонд шилжсэн. Ийм тогтолцоогоор 2024 оны Улсын Их Хурлын сонгуулиар анх удаа улс төрийн 5 нам, эвсэл парламентад суудалтай болж, эмэгтэйчүүдийн төлөөлөл 25,4 хувьд хүрсэн нь Ази тивийн дундаж үзүүлэлтээс өндөр болсон ийм үзүүлэлтийг урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд тавьсан зорилгоо хэрэгжүүлж чадсан.

Төрийн албаны хүнд суртлыг багасгах, төрийн албаны салангид платформуудыг ИМонгол буюу нэгдсэн системд нэвтрүүлэх зорилт тавигдаж байсан. Энэ бол Эстонийн зорилтыг хэрэгжүүлэх ийм зорилтыг тухайн үед ярьж хийж байсан. ИМонголиа платформ хэрэглээнд нэвтэрснээр тус систем өнөөдрийн байдлаар 1,95 орчим сая хэрэглэгчтэй болж, 1263 үйлчилгээг цахимаар үзүүлж лавлагаа, тодорхойлолт авах дундаж хугацаа 5 секунд болсон гэдэг ийм мэдээлэл байгаа. НҮБ-аас 2 жил тутам шинэчлэн гаргадаг цахим засаглалын хөгжлийн индексээр Монгол Улс 2024 онд 46 дугаар байранд орж өмнөх үзүүлэлтээс 28 байраар урагшилсан бол иргэдийн цахим оролцооны индексээр 2024 онд өмнөх оноос 20 байраар урагшилж, 193 орноос 37 дугаарт эрэмбэлэгдсэн байна. Цаашдаа цахим хөгжлийг хөгжүүлэхийн тулд зөөлөн дэд бүтэцтэй холбоотой хөрөнгө оруулалтыг хийх, мөн мэтгэлцээнтэй байгаа хиймэл дагуулын асуудлаа шийдвэрлэх шаардлагатай байгаа.

Ногоон хөгжлийн зорилтын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч томоохон улс төрийн манлайлал үзүүлэн ажиллаж байна. Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжин хэрэгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилт, хөрсний доройтолтой тэмцэх, усны эх үүсвэр, экологийн тэнцвэрт байдлыг хангах эрх зүйн цогц шинэчлэлийг хийхээр хамтдаа ажиллаж байна. Мөн биологийн төрөл зүйлийг сэргээн хамгаалах экосистемийг хадгалахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг өргөтгөх, байгалийн нөөцийн менежментийг сайжруулах, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар нүүрс хүчлийн хийн ялгарлын багасгах зорилго тавин ажиллаж байна. Мөн мод тарих болон ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хог хаягдлын шинэ менежмент нэвтрүүлэх зэрэг ногоон хөгжил болон хүний хөгжлийг дэмжсэн хөрөнгө оруулалт хийсэн ААН-үүдэд борлуулалтын орлогын нэг хувь хүртэл татварын хөнгөлөлт үзүүлэх хуулийг хэрэгжүүлж, хувийн хэвшлийг идэвхжүүлэх оролцоо дээр анхааран ажиллаж байна. Ногоон хөгжил зөвхөн мод тарих агуулга биш, ногоон хөгжлийн асуудал илүү цөлжилт, мөн эрчим хүч, аж үйлдвэржилт, нүүрс гэхэд дахин боловсруулах зэрэг ийм багц асуудлыг тусгаж

байгаа. Би үдээс хойш ногоон хөгжлийн талаар ялангуяа СОР-н хуралтай холбоотой мэдээллийг өгнө гэж бодож байгаа учраас ингээд товчилъё.

Амар тайван, аюулгүй нийгэм зорилтын хүрээнд Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох, хууль шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхын стратегийг тодорхойлох, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн, амьдралын таатай байдлын үзүүлэлтүүдийг дээшлүүлж, нийгмийн эрсдэлийг бууруулах зорилт дэвшүүлсэн Хүн төвтэй хөгжлийн үзэл баримтлалын томоохон тулгуур илэрхийллийг эрх зүйн баримт бичигт тусгах тал дээр ажилласан. Гэмт хэргийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гудамж талбай, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, камержуулалтын нэгдсэн тогтолцоонд нэвтрүүлэх асуудлыг ялангуяа нийслэл Улаанбаатар хотод хэрэгжүүлэх ажил явж байна. Үүнийг Хотын дарга дэлгэрэнгүй танилцуулаад явчхаж болох учир товчилъё.

Бүс ба орон нутгийн хөгжлийн зорилт бол нийслэл Улаанбаатар хотын хэт төвлөрлийг задлах ийм зорилт байсан. ЗГ-аас 2024 оныг бүсчилсэн хөгжлийг дэмжих жилээр зарлаж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 2000 оноос хойш шинэчлэн боловсруулж Улсын Их Хурлаар батлуул батлуулж, мөн анх удаа Монгол Улсын Их Хурлын сонгууль бүсчлэн томсгосон тойргоор зохион байгуулагдаж байна. Ингээд удахгүй бид бүс бүхэн дээр ажиллаж, бүсүүдийн бүтэц ялангуяа бүсийн иргэдийн Хурал, бүсээс сонгогдсон парламентын гишүүд, ЗГ хэрхэн цаашид илүү боловсронгуй ажиллах вэ, энэ нь цаашдаа Нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль болон Үндсэн хуультай холбоотой ямар өөрчлөлтүүд байж болох вэ, бүсийн хөрөнгө оруулалт болон бүсийн шийдвэр гаргах механизмыг хэрхэн боловсронгуй болгох вэ гэдэг ийм бодлогын баримт бичиг дээр ажиллах шаардлагатай болж байгаа.

Мөн Бүсчилсэн хөгжлийн бүтээн байгуулалтад оролцсон ААН-үүдэд бүтээн байгуулалтын үе шатад импортын барилгын материал, тоног төхөөрөмжийн гаалийн албан татварыг 100 хувь чөлөөлөх, НӨАТ-ыг 4 жилийн дараа төлөх, үйл ажиллагааны үе шатад ирээдүйн 5 жилийн орлогод төлөх ААНОАТ-ыг 90 хувь буцааж олгох зэрэг аль болохоор хот руу хотыг үүнтэй хөдөөг илүү дэмжлэгтэй болгох ийм татварын цогц реформ хийгдэх байдлаар ажиллаж байна. Мөн энэ хаврын чуулганд багтаж ЗГ-аас татвар болон нийгмийн даатгалын цогц реформтой холбоотой мэдээлэл болон танилцуулгыг Улсын Их Хуралд оруулахад бэлэн болсон байгаа гэдгийг хэлье. Мэдээж энэ тарифтай холбоотой олон улсын худалдааны тэнцэлтэй холбоотой асуудлыг харж байгаад бид энэ реформыг хийх нь зүйтэй.

Улаанбаатар хот ба дагуул хот зорилтын хүрээнд ЗГ-аас нийслэл Улаанбаатар хотод тулгамдсан асуудлыг цогцоор шийдвэрлэхийг зорьж, 2020 оноос хойш хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэн 12,5 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийхээр төлөвлөн ажиллаж байна. Мөн 2025 оныг Нийслэлийн дэд бүтцийг дэмжих жил болгон нийслэлийн удирдлагуудтай хамтран ЗГ штабын байдлаар ажиллаж, нийслэл Улаанбаатар хотод тулгамдсан агаарын бохирдол, мөн авто замын түгжрэлтэй холбоотой асуудал, дэд бүтцийн асуудал дээр хөрөнгө оруулалт оруулан ажиллахаар ажиллаж байна. Энэ хүрээнд Улаанбаатар хотын хөгжлийн 24 төслийг үе шаттайгаар эрэмбэлж, Туулын хурдны зам, Багахангай Хөшигийн хөндийн төмөр зам, метро трамвай, дүүжин тээврийн замын ажлуудыг

нийслэл Улаанбаатар хотын хэрэгжүүлэх төслүүдийн эхний 5 төсөл гэж эрэмбэлсэн.

Мөн 20 минутын хот үзэл баримтлал, түүнтэй уялдсан Улаанбаатар хотын 2040 он хүртэлх ерөнхий төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна. Энэ бол өнгөрсөн хугацаанд боловсруулагдсан 3 ерөнхий төлөвлөгөөг нэгтгэж, олон улсын судалгааны багтай ажилласан ийм төсөл. Энэ дээр Улсын Их Хурлын гишүүд та бүхэн анхаарал хандуулж энэ ерөнхий төлөвлөгөөг илүү оролцоон дээр тулгуурлан хэлэлцүүлэгтэйгээр баталж өгөхийг та бүхнээс хичээнгүйлэн хүсье. Энэ зорилтууд хэрэгжиж чадвал 2028 он гэхэд нийслэл Улаанбаатар хотын одоо байгаа автомашины түгжрэл 50 хувиар буурах ийм тооцоолол гарсан байгаа. Энэ дээр хотын дарга болон Зам, тээврийн яам дэлгэрэнгүй мэдээллийг өгөх нь зүйтэй.

Агаар, орчны бохирдлын хувьд Одонтуяа сайд дэлгэрэнгүй мэдээлэл өгөх байх. Газын шилжилт рүү буюу хийн түлш рүү шилжих нь хамгийн зөв арга гэж үзэж байгаа. Мөн хөх түлш буюу одоогийн Тавантолгой түлшийг технологийн өөрчлөлт хийж сайжруулах, нэг үгээр хэлбэл олон улсын үе шатын хувьд түүхий нүүрснээс сайжруулсан түлш, сайжруулсан түлшнээс коксожсон буюу хагас коксожсон түлш, ингээд хийн хэрэглээнд нэвтрэх гэсэн ийм 4 шилжилтийн хүрээнд үе шаттай энэ асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэсэн ийм төлөвлөгөө 2040 он хүртэлх төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжиж байна. Энэ бол 5 жилийн хугацаанд хэрэгжсэн ерөнхий асуудлуудын тайлан.

Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хувьд Монгол Улсын Их Хурлаар 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор батлуулсан. 4 бодлого, 16 чиглэлийн хүрээнд энэ хөтөлбөр хэрэгжиж байна. Хагас жилийн байдлаар урьдчилсан биелэлт 34 хувьтай байна гэж дүгнэгдэж байна.

Хурдтай хөгжлийн төлөөх Зориг хэмээх хамтарсан ЗГ гэрээ байгуулж, хамтарсан ийм хөтөлбөрийг дэвшүүлсэн. Хөтөлбөрийн гол зорилго бол олон жилийн хугацаанд ойлголцож чадаагүй төслүүдээ эрэмбэлж, 14 мега төслийг зарлаж, 14 мега төслөөр дамжуулж одоо байгаа ДНБ-ийг 2 дахин тэлэх ийм зорилтыг тавьсан. Энэ нь бусад хүний хөгжлийн бусад зорилтуудаа урт хугацаанд болон дунд хугацаанд хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг тогтвортой бүрдүүлэх ийм зорилготой байсан. Ингээд энэ тайлант хугацаанд өчигдөр Гашуунсухайт-Ганцмод хил холболтын бүтээн байгуулалтын төсөл батлагдаж чадлаа. Их Хурлын гишүүд та бүхэндээ ЗГ-ын нэрийн өмнөөс талархаж байгаагаа илэрхийлье. Энэ төсөл 1 дүгээрт эрэмбэлэгдсэн ийм төсөл байсан. Мөн Монгол Францын хамтарсан ураны төслийн хөрөнгө оруулалтын гэрээг байгуулж чадлаа. Энэ бол Оюу толгойн гэрээний дараа 2 дугаарт 3 дахь хөршийн хөрөнгө оруулалтын ийм төсөл байсан. 1997 оноос хойш яригдсан ийм төсөл.

Эрдэнэбүрэний УЦС-ын зээлийн гэрээ байгуулагдсан. Энэ хавар бүтээн байгуулалтын ажил эхлэхээр болж байна. Эрдэнэбүрэний УЦС-ын зээлийн гэрээ байгуулагдсан учраас Эгийн голын УЦС-ыг хөдөлгөх ийм судалгааны ажил дээр ЗГ ажиллаж байна гэдгийг хэлье. Эрчим хүчний үнийг хамтдаа чөлөөлж чадсан. Энэ мэдээж улс төрийн томоохон маргаантай 30-аад жил хийж чадаагүй ийм асуудал. Энэ хамтарсан ЗГ-ын үед хийгдэж, нэг үгээр хэлбэл орлого, зарлагын

тэнцэл эдийн засгийн хувьд илүү ашигтай болох ийм боломж гарсан учраас Бөөрөлжүүт, Чойбалсан, Багануур зэрэг эрчим хүчний гацсан байсан төслүүд гацаанаас гарч, дулааны 3 дугаар цахилгаан станцыг өргөтгөх ажлыг эхлүүлэх ийм шийдвэрийг Улсын Их Хурлаар батлуулж чадсан.

Хөгжлийн мега төслүүдээ гацаанаас гаргаж урагшлуулах олон улсын гэрээ хэлэлцээр, төсөл эрх зүйн реформ хэрэгжүүлэх хууль тогтоомжийн төслийг ЗГ-аас Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, чуулганаар нээлттэй хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Энэ дотор ялангуяа Худалдан авалттай холбоотой хууль, Хөрөнгө оруулалтын хууль, Компанийн хуулийг дахин авч үзэх зайлшгүй шаардлага гарч байгаа. Яагаад гэвэл энэ дөнгөж нийгэм шилжиж байх үед зохицуулалт хийж байсан ийм хуулиуд, өнөөдрийн хурдтай өсөж буй эдийн засаг, нийгмийн хэрэглээг даахгүй байгаа зохицуулалт нь тодорхой биш байгаа ийм асуудлууд гарч байгаа.

ЗГ-аас төвлөрч байгаа дараагийн мега төслүүд бол Тавантолгойн цахилгаан станцын төсөл байгаа. Мөн Эгийн голын УЦС-ын төсөл байгаа. Энэ дээр дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох мэргэжилтнүүд өгөх байх. Эгийн голын УЦС гацсан шалтгаан цаг уур болон Байгаль нууртай холбоотой ийм байгалийн сөрөг нөлөөлөл байна гэдэг байдлаар Оросын Холбооны Улсын эрдэмтэд, мөн 3-аас 4 төрийн бус байгууллагууд олон улсын байгууллагууд мэдэгдэл гаргасан. Энэ дээр хамтарсан ажлын хэсэг байгуулаад, эхний дүгнэлт энэ нөлөөлөл тооцож байснаас харьцангуй сөрөг нөлөөлөл багатай байна гэж гарсан байгаа. Тийм учраас энэ дээр Улсын Их Хуралтайгаа хамтран ЗГ ажиллана. БНХАУ-тай ярьж байсан томоохон хэд хэдэн төслүүд зорилтоо хангасан учраас одоо ОХУ, БНХАУ-тай хамтран хэрэгжүүлэх хийн хоолойн төсөл. Хийн хоолойн төсөл хэрэгжсэнээр нийслэл Улаанбаатар хотыг хийн түлшээр хангах ийм зорилго зарчмын хувьд том шийдэл болно.

Мөн бид төмөр замын баруун, зүүн коридорын буюу 3 улсын төмөр замын төслүүдээ хэрэгжүүлэх ийм цаг хугацаа гэж харж байгаа. Тэгээд энэ дээр мэдээж парламент дээр бид нээлттэй өмнө нь гарч байсан ТЭЗҮ-үүд болон мөн шинэчлэгдсэн ТЭЗҮ-үүдийг ярилцаж, хамтдаа энэ төслүүдийг гацаанаас гаргахын төлөө ажиллана. Мэдээж эхэн үед энэ төслүүдийг оруулж ирэхэд томоохон мэтгэлцээнүүд өрнөнө. Тэрийг ойлгож байгаа. Гэхдээ бид дахин, дахин ярилцаж, дахин, дахин тоогоо нягталж, дахин, дахин цаасаа нягталж, дахин, дахин ТЭЗҮ-ээ нягталж чадвал энэ төслүүдийг гацаанаас гаргаж бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлж дуусгах бол боломжтой гэж дүгнэж байгаа.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын гүйцэтгэлийн тайланг хэлэлцүүлэхээр та бүхэнд танилцуулж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.4-д заасан аудитын тайланг Монгол Улсын ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Загджав: Та бүхэндээ энэ өглөөний мэндийг өргөн дэвшүүлье. Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн дагуу Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8.1, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсыг 2021-ээс 2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлд Аудитын дээд байгууллагын олон улсын болон үндэсний стандартын дагуу аудитыг хийж гүйцэтгэн аудитын тайлан дүгнэлтийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн болно.

1.Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл болон Монгол Улсын 2021-ээс 25 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хуульд заасан шаардлагын дагуу боловсруулсан эсэх, жилийн улсын хөгжлийн төлөвлөгөө, Төсвийн тухай хууль нь Үндсэн чиглэл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэх, үндсэн чиглэл хөтөлбөрийн хэрэгжилтийг бодитой үнэлж, гарсан үр нөлөөг тооцож зохих арга хэмжээ авсан эсэхийг тодорхойлоход аудитын зорилго чиглэгдсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Монгол Улсыг хөгжүүлэх 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, 9 бодлого зорилтын хүрээнд, 47 зорилт, 243 арга хэмжээг, 2 дугаар хавсралтаар Монгол Улсын 2021-ээс 25 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан 9 бодлого зорилтын хүрээнд нийт 150 төсөл, арга хэмжээг ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах шаардлагатай 98 төсөл, арга хэмжээг, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай 88 төсөл, арга хэмжээний жагсаалтыг тус тус баталсан байна. Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэл болон хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.1-д Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тавих шаардлагыг тусгасан боловч энэ шаардлагыг бүрэн хангаагүй буюу Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгасан 243 арга хэмжээнээс 108 шалгуур үзүүлэлт суурь болон хүрэх түвшингүй байгаа нь хуулийн шаардлагыг бүрэн хангаагүйг харуулж байгаа юм.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд, Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл 67,7 хувьтай хэрэгжсэн бөгөөд нийт төсөл, арга хэмжээний 14,8 хувь нь үр дүнтэй, 50,2 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 32,5 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай, 2,5 хувь нь үр дүнгүй байна.

2.Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу иж бүрэн судалгаа тооцоотой боловсруулаагүйгээс төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй, гүйцэтгэлийг бодитой үнэлэхэд хүндрэл учруулж, нийгэм, эдийн засаг, байгаль орчин, тогтвортой хөгжилд үзүүлэх үр нөлөөг бууруулсан байна.

3.Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгасан арга хэмжээг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, тухайн жилийн Төсвийн тухай хуульд тусган хэрэгжүүлэх үйл явц болон төлөвлөсөн санхүүжилтийн эх үүсвэрийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь хууль, эрх зүйн

уялдаагүй байдал, зохицуулалт дутагдалтай, оролцогч байгууллагуудын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

4.Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй гүйцэтгээгүйд тооцох хариуцлагын талаар хууль, эрх зүйн зохицуулалт хэт ерөнхий, нарийвчилсан шалгуургүйгээс хэрэгжүүлэгч байгууллагын албан тушаалтнууд хариуцлага хүлээхгүй байх нөхцөл бүрджээ.

5.Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл нь өөрийн зорилтот түвшинд хүрч, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг хэрэгжүүлэгч байгууллагууд, Эдийн засаг, хөгжлийн яам, ЗГХЭГ бодит гүйцэтгэл холбогдох нотлох баримтад үндэслэн бодитой үнэлээгүй, зөвхөн 2024 оны гүйцэтгэлээр тайлагнаж үнэлсэн, хөтөлбөр хэрэгжсэн хугацааны нэгдсэн дүнгээр үнэлээгүй нь 5 жилд тодорхойлсон бодлого, зорилго, зорилтыг хэрхэн хангаж байгаа, цаашлаад урт, дунд хугацааны баримт бичгийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг тодорхойлоогүй, зөвхөн богино хугацааны төлөвлөлтөд анхаардгийг харуулж байгаа юм.

6.Эдийн засгийн хөгжлийн яам, ЗГХЭГ болон хэрэгжүүлэгч байгууллагууд төлөвлөсөн зорилт арга хэмжээг хэдэн хувьтай хэрэгжүүлсэнд ач холбогдол өгч байгаагаас Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тодорхойлсон зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийгэм, эдийн засагт ямар үр нөлөө бий болж байгааг дагалдаж үнэлээгүй нь хууль, эрх зүйн зохицуулалт дутагдалтай, уг үнэлгээг хийх тогтолцоо бүрдээгүйтэй холбоотой байна. Энэ нь шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах боломжийг хязгаарлаж, үр нөлөө багатай арга хэмжээг хэрэгжүүлж, үргүй зардал гаргах нөхцөлийг үүсгэж болзошгүй байдалд хүргэсэн. Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тодорхойлсон зорилго, зорилт, арга хэмжээний хүрээнд 2021-ээс 24 онд 21,7 их наяд төгрөг зарцуулсан ч нийгэм, эдийн засагт ямар эерэг өөрчлөлт бий болсон нь тодорхойлогдохгүй байгаа юм.

Монгол Улсын Их Хуралд дараах асуудлыг толилуулж байна. 1.Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2, 9.2.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон тухайн жилийн төсвийн тухай хуулийн хуулийг батлахдаа тэдгээрийн хоорондын уялдаа, нийцэлд анхаарах.

2.Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд туссан арга хэмжээг хугацаанд нь биелүүлээгүй хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагад хариуцлага тооцох хууль, эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох.

3.Хөгжлийн бодлогын баримт бичигт төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд үндэслээгүй, судалгаа тооцоололгүй арга хэмжээг Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатад нэмж баталдаг асуудлыг цаашид таслан зогсоохыг толилуулж байгаа юм.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг Монгол Улсын ЗГ-т өгч байна. Үүнд, Монгол Улсын ЗГ, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдад. Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт

тусгах төсөл, арга хэмжээнд хууль, журам, аргачлалд заасны дагуу судалгаа, тооцоо, үнэлгээг иж бүрэн хийх.

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга нарт. 1.Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлснээр бий болгох үр нөлөөг тодорхойлж, түүнд чиглэсэн зорилго, зорилт, үйл ажиллагааг тодорхой төлөвлөн, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж, тооцоо судалгаанд үндэслэн бодитой хэмжигдэхүйц хэрэгжүүлэх хугацаа, хариуцах байгууллагыг тодорхойлж боловсруулах. 2.Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогч талуудын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх хуулиар хүлээсэн чиг үүргийг хангуулах. Тухайлбал, Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Сангийн яам. 3.Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд бодит гүйцэтгэл, нотлох баримтад суурилсан цогц хяналт шинжилгээ, үнэлгээ, хөтөлбөр хэрэгжсэн хугацааны нэгдсэн дүнгээр хийж, урт, дунд хугацааны баримт бичгийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг тодорхойлж, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллах. Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэлд нийгэм, эдийн засагт ямар үр нөлөө, эерэг өөрчлөлт бий болсныг үнэлж тооцон Үндэсний статистикийн хорооноос гаргадаг статистикийн өгөгдөлд оруулж, нийтэд ил тод, ойлгомжтой хэлбэрээр байршуулах ажлыг зохион байгуулах.

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд, Сангийн сайд нарт. 1.Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлж, хуульд заасан чиг үүргийн хүрээнд төсөл, арга хэмжээний тоо, санхүүжилтийн зохистой харьцааг бодитой тооцож төлөвлөх. Санхүүжилтийн эх үүсвэр нь бүрэн шийдэгдээгүй асуудалд дүн шинжилгээ хийж, шаардлагатай зохицуулалтын арга хэмжээ авч ажиллах. Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон тухайн жилийн төсвийн тухай хуульд туссан арга хэмжээний нийцэлд хууль тогтоомжийн хүрээнд тусгасан ялгаатай шаардлагад дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авах, шийдвэр гаргах этгээдэд уламжлах.

Бүх шатын төсвийн ерөнхийлөн захирагч нарт Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлснээр бий болгох үр нөлөөг тодорхойлж, түүнд чиглэсэн зорилго, зорилт, үйл ажиллагааг төлөвлөн, хууль тогтоомжид заасан шаардлагыг тооцоо судалгаанд үндэслэн бодитой хамрагдахуйц тодорхойлж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын санал тооцооллыг нэгтгэн боловсруулах. 2.Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд бодит гүйцэтгэл, нотлох баримтад суурилсан цогц хяналт шинжилгээ, үнэлгээг хөтөлбөр хэрэгжсэн хугацааны нэгдсэн дүнгээр хийж, урт, дунд хугацааны баримт бичгийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг тодорхойлж тайлагнах. 3.Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээнд хууль, журам, аргачлалд заасны дагуу судалгаа, тооцоо үнэлгээг иж бүрэн хийж, орон нутгийн иргэдийн саналыг авч, олон нийтээр хэлэлцүүлэх. Улсын Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу бүх шатны төсөв захирагчид аудитын зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаад дүгнэлт хийж, анхаарч ажиллах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэж байна.

Улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөө, Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан улсын хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөөнд 8 тэргүүлэх чиглэл, 24 төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, 53 хөтөлбөрийн үр дүн, 184 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, нийт 13,9 их наяд төгрөгийн хөрөнгө шаардлагатай байхаар баталж, гүйцэтгэлээр нийт 6,4 их наяд төгрөгийг зарцуулсан байна. Монгол Улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөний бодлогын баримт бичгийн төлөвлөлтөд шалгуур үзүүлэлт бүрээр бодлогын хэрэгжилт, үр дүнг тайлагнах, үнэлж дүгнэхээр төлөвлөсөн нь өмнөх онуудын богино хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичгээс тодорхой ахицыг бий болгосон байна.

Аудитаар цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах гол дүгнэлтийг гаргаж байгаа юм. Үүнд, 1.Монгол Улсыг 2024 оны, Монгол Улсын 2024 оны үндэсний хэмжээний зарим статистик тоон үзүүлэлт болон ОУБ-аас гаргадаг холбогдох тайланг гаргах хугацаа болоогүйгээс шалтгаалж, 3 тэргүүлэх чиглэлийн 3 төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн түвшин биелэлтийг дүгнэх боломжгүй байсан.

2.Харин улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 5 тэргүүлэх чиглэлийн үр дүн 74,3 хувь, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 56,9 хувь, хөтөлбөрийн үр дүнгийн дундаж үнэлгээ 56,6 хувь, 194 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 52,1 хувьтай тус тус үнэлэгдсэн байна.

3.Монгол, Засгийн газрын эрх бүхий байгууллагаас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох хууль журамд заасан 15 хоногийн хугацаанд дунд шатны болон эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд цаг хугацаа, боловсон хүчний чадамж, зохион байгуулалт хангалтгүйгээс хуульд заасан зарчим, шаардлага, чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй, цогц хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй.

4.Богино хугацааны бодлогын баримт бичигт тусгасан зарим төсөл, арга хэмжээнд шаардлагатай хөрөнгө эх үүсвэрийг оновчтой тодорхойлоогүй. Улсын төсвөөр санхүүжүүлэх хөрөнгийг тухайн жилийн төсвийн тухай хуульд бүрэн тусгаагүй. Мөн хуульд заасан улсын хөгжлийн төлөвлөгөөнд суурилсан байх шаардлага, Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд заасан төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчмыг хангаагүй, зарцуулсан хөрөнгийг үнэн зөв, бодитой тайлагнаагүйгээс нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, хөрөнгийн үнэ цэнийг бүрэн бий болгож чадаагүй.

5.ҮСХ-ноос улсын хэмжээний жилийн статистик тоон мэдээллийг харилцан адилгүй хугацааны давтамжтай тархааж байгаа нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан цаглаварт хугацаанд бодлогын хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлэх, үр нөлөөг зөв тооцох, үнэлэх боломжгүйд хүргэж байна.

6.Богино хугацааны бодлогын баримт бичгийг төлөвлөж, боловсруулах үүрэгтэй төсвийн ерөнхийлөн захирагч Эдийн засгийн хөгжлийн яаманд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан бүх талын оролцоог

хангах зарчмыг баримтлаагүй, зарим төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөвгүй, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг оновчтой тодорхойлоогүй, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцоогүй зөрчлүүд давтагдан гарч байгаагаас бодлогын хэрэгжилт зорилтот үр дүнд хүрээгүй.

7.Бодлогыг хэрэгжүүлэх явцад үүсэж болзошгүй эрсдэлийг удирдах бодлогын хувилбарыг урьдчилан төлөвлөж чадаагүй, салбарын онцлогт нийцсэн үзүүлэлт индекс гүйцэтгэлийн чанарын стандарттай нийцсэн хяналт шинжилгээ, үнэлгээний аргачлалгүй нь тухайн салбарын бодлогын үр дүнг бодитой үнэлэх, үр нөлөөг тооцож чадахгүй байх эрсдэлтэй байгаа юм.

Мөн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Засгийн газарт 4, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдад 4, Сангийн сайд 1, Төсвийн ерөнхийлөн захирагч нарт 3, нийт 12 зөвлөмжийг өгч ажиллаж байна. Үүнд Монгол Улсын ЗГ-т Монгол Улсын ЗГ болон ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газарт. 1.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг төлөвлөх, тайлагнах хяналт шинжилгээ, үнэлгээ хийхээр баталсан холбогдох хууль, журмын цаглаварт хугацаанд судалгаа, дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд хуульд өөрчлөлт оруулах санал гаргах. 2.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийг төлөвлөхдөө хэрэгжилт үр дүнг хангахад чиглэсэн санхүүжилтийн эх үүсвэр, шаардлагатай хөрөнгийг бүрэн тооцоолж, үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийг хийхэд чиглүүлэх. 3.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналын үр дүнгийн тоон мэдээлэл нь цаг үеэ олсон байхад чиглэсэн мэдээлэл цуглуулах, мэдээллийн эх сурвалжийг оновчтой тодорхойлж, ОУБ-аас тооцоолдог үзүүлэлтүүдийг дотооддоо тооцох аргачлал бүхий шалгуур үзүүлэлттэй болгох. 4.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн богино хугацааны бодлогын хэрэгжилт, үр дүнг үнэн зөв тайлагнах, үр нөлөөг бодитой тооцоолоход чиглүүлж, үүсэж болох эрсдэлийг урьдчилсан төлөвлөсөн хувилбар бүхий төлөвлөгөөг батлах.

Монгол Улсын ЗГ-ын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайдад. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хэрэгжилт, үр дүнг хангахад чиглэсэн санхүүжилтийн эх үүсвэрт шаардлагатай хөрөнгийг бүрэн тооцоолсон, үр дүнд суурилсан төсөвлөлт, төлөвлөлтийн зарчмыг хангаж төлөвлөх. 2.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналын үр дүнгийн тоон мэдээлэл нь цаг үеэ олсон байхад чиглэсэн мэдээлэл цуглуулах, мэдээллийн эх сурвалжийг оновчтой тодорхойлж, ОУБ-аас тооцоолдог үзүүлэлтийг дотооддоо тооцох аргачлал бүхий шалгуур үзүүлэлтийг боловсруулах. 3.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийн бодлогын хэрэгжилт, үр дүнг үнэн зөв тайлагнах, үр нөлөөг бодитой тооцоолоход чиглүүлэн төлөвлөж, үүсэж болох эрсдэлийг урьдчилан төлөвлөсөн хувилбар бүхий төлөвлөгөөг гаргаж, бүх талын оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх. ЗГ-ын түвшинд хэрэгжүүлж буй их өгөгдлийн big data сан мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөлтэй уялдсан улсын хэмжээний мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, мэдээллийн санг бүрдүүлэх, шинэчлэх, мэдээллийг эргэлтэд оруулах, эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж буй олон улсын үнэлгээний цогц систем бүхий жишигт нийцсэн мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх.

Сангийн сайд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн богино хугацааны баримт бичигт тусгасан бодлого, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд шаардлагатай улсын төсвөөр санхүүжүүлэх хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасан улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх шаардлагад нийцүүлэн тухайн жилийн төсвийг боловсруулах.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт. 1.Улсын хөгжлийн богино хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулахдаа шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээг тусган хүргүүлж байх. 2.Улсын хөгжлийн богино хугацааны бодлогын хөтөлбөр, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, эх үүсвэрийг оновчтой тодорхойлж, улсын төсвөөр санхүүжүүлэх хөрөнгийг тухайн жилийн Төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын төсвийн төсөлд хүргүүлэх саналд тусгаж байх. 3.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн богино хугацааны бодлогын баримт бичгийг бодлогын хэрэгжилт, үр дүнг үнэн зөв тайлагнах, үр нөлөөг бодитой тооцоолоход чиглэсэн бүх талын оролцоог ханган боловсруулж, үүсэж болох эрсдэлийг урьдчилан төлөвлөсөн хувилбар бүхий төлөвлөгөөг гарган хүргүүлж ажиллах шаардлагатай байна. Анхаарал тавьсанд баярлалаа. Танилцуулж дууслаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төрийн байгуулалтын байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хорооны хамтарсан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мэндбаярын Мандхай танилцуулна. Индэрт урьж байна.

М.Мандхай: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2025 оны 2 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилт, Монгол Улсыг 2021-ээс 2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2024 оны гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117 дугаар зүйлд заасны дагуу Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 3 дугаар сарын 18, 25-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хамтарсан хуралдааны үед Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга Цогтгэрэл ажлын 3 хоногийн завсарлага авсан болно. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилт болон Монгол Улсыг 2021-ээс 2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2024 оны гүйцэтгэлийн тайланд ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ирүүлснийг та бүхэнд хүргүүлсэн.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд бодлогын тэргүүлэх 8 чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 24 үр дүн, хөтөлбөрийн 53 үр дүн, 194 төсөл, арга хэмжээ, 205 шалгуур үзүүлэлт тусгагдсан ба төлөвлөгөөний биелэлтийг ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газраас дунджаар 57,2 хувь, Үндэсний аудитын газар 52,1 хувь, Улсын Их Хурлын Тамгын газар 45,1 хувийн биелэлттэй гэж үнэлжээ. ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газраас төлөвлөгөөнд тусгагдсан нийт 194 төсөл, арга хэмжээний үр дүнтэй буюу 19,1 хувийн хэрэгжилттэй 37 төсөл, арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн 30,9 хувийн хэрэгжилттэй 60 төсөл, арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай 35,1 хувийн хэрэгжилттэй 68 төсөл, арга хэмжээ үр дүнгүй 14,9 хувийн хэрэгжилттэй 29 төсөл арга хэмжээг үнэлсэн байна.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд заасан бодлого тус бүрийн хэрэгжилтийг ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газраас дараах байдлаар үнэлжээ. Үүнд, 1.Экспортыг нэмэгдүүлнэ тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 4 үр дүн, хөтөлбөрийн 6 үр дүн, 23 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 36,5 хувь.

2.Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 5 үр дүн, хөтөлбөрийн 11 үр дүн, 52 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар дунджаар 50,2 хувь.

3.Хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулна тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн тус бүрээр хэрэгжилтийг авч үзэхэд боловсролын салбарын чанар хүртээмжийг сайжруулна хүрээнд 12 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дунджаар 78,3 хувь.

4.Аялал жуулчлалыг хөгжүүлэн тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн тус бүрээр биелэлтийг авч үзэхэд жуулчдад зориулсан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ хүрээнд 5 төсөл, арга хэмжээний биелэлт дунджаар 52 хувь.

5.Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн нэг үр дүнгийн хүрээнд төлөвлөсөн нэг хөтөлбөрийн үр дүнгийн биелэлтийн дундаж 78 хувь.

Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулна тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 2 үр дүн, хөтөлбөрийн 7 үр дүн, 23 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар дунджаар 59,9 хувь.

7.Засаглалын үзүүлэлтийг сайжруулна тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 5 үр дүнгийн хүрээнд төлөвлөсөн 10 хөтөлбөрийн үр дүнгийн биелэлтийн дундаж 81,8 хувь.

8.Ногоон хөгжлийг дэмжинэ тэргүүлэх чиглэлийн хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн нэг үр дүн, хөтөлбөрийн 4 үр дүн, 8 төсөл арга хэмжээг төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар дунджаар 86,3 хувь байна.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан 194 төсөл, арга хэмжээний 50 хувь буюу 97 арга хэмжээ үр дүнгүй эрчимжүүлэх шаардлагатай гэж

үнэлэгдсэн нь төлөвлөгөөг судалгаа тооцоололд тулгуурлан, үндэслэлтэй боловсруулаагүй, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, санхүүжилт батлагдаагүй, бэлтгэл, урьдчилсан шатын ажлын явц удаашралтай байгаа зэргээс шалтгаалж байгаагийн зэрэгцээ арга хэмжээний биелэлтийг бүрэн тодорхой тайлагнаагүй байна.

Улсын Их Хурлын Тамгын газраас 194 төсөл, арга хэмжээг хэрэгжилтийн хувь тус бүрээр авч үзвэл үр дүнтэй буюу 100 хувийн хэрэгжилттэй 24 төсөл, арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-аас 99 хувийн хэрэгжилттэй 53 төсөл, арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай буюу 30-аас 69 хувийн хэрэгжилттэй 52 төсөл, арга хэмжээ үр дүнгүй буюу 0-ээс 29 хувийн хэрэгжилттэй 65 төсөл, арга хэмжээ тус тус байна. Монгол Улсыг 2021-ээс 2025 онд хэрэгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд үндэсний нэгдмэл үнэт зүйл, хүний хөгжил, амьдралын чанар ба дундаж давхарга, эдийн засаг, засаглал, ногоон хөгжил, амар тайван, аюулгүй нийгэм, бүс, орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн үндсэн 9 зорилгын хүрээнд 47 зорилт дэвшүүлж, 243 арга хэмжээг төлөвлөсөн.

Монгол Улсыг 2021-ээс 2025 онд хөгжүүлэх 5 жилийн зорилтод хамаарах 243 арга хэмжээний хэрэгжилт 2024 оны байдлаар 3Г-ын хяналт хэрэгжүүлэх газраас 65 хувийн хэрэгжилттэйгээр тусгасан бөгөөд Үндэсний аудитын газар 67,7 хувь, Улсын Их Хурлын Тамгын газар 52,6 хувь гэж үнэлсэн байна. Монгол Улсын 3Г-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан үндсэн 4 бодлогын хүрээнд 16 чиглэл, 620 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжүүлэх хугацаа болоогүй 30,5 хувь буюу 189 зорилт байсан тул хугацаа болоогүй зорилтыг хасаж, нийт 431 зорилтын хэрэгжилтийн явцад дүн шинжилгээ хийж, хэрэгжилт 34 хувь ба Улсын Их Хурлын Тамгын газраас тус хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг дунджаар 25,3 хувь буюу хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнгүй гэж үнэлсэн байна.

Түүнчлэн Монгол Улсын 3Г-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн нийт 431 зорилтоос 22,2 хувь буюу 138 зорилтын хэрэгжилт хангалтгүй байсан тул үнэлгээг бууруулан үнэлсэн бөгөөд бодлого тус бүрээр нь авч үзвэл Бүсчилсэн хөгжлийн бодлогын 92 зорилтын 7 зорилт буюу 7,6 хувь, Хүний хөгжлийн бодлогын 152 зорилтын 34 зорилт буюу 22,4 хувь, Эдийн засгийн бодлогын 222 зорилтын 48 зорилт буюу 21,6 хувь, Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын 154 зорилтын 49 зорилт буюу 31,8 хувийг тус тус эзэлж байна.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хэрэгжилт хамгийн өндөр буюу 40 хувь гэж дүгнэсэн ч бодит байдал дээр хэрэгжилт хангалтгүй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг тайланг үнэлэх аргачлал өөр, өөр, үйл ажиллагааны биелэлт, үнэлгээ хоорондоо хол зөрөөтэй байгаа шалтгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Лувсанжамц гүйцэтгэлийн тайланд хийсэн үнэлгээнүүд хоорондоо зөрөөтэй, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд хангалтгүй, 3Г-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмаар үнэлэх аргачлалаа баримталж үнэлгээ хийсэн эсэх, засаглалын үзүүлэлтийг сайжруулах зорилтыг үнэлэх Дэлхийн банкны үнэлгээ гараагүй байгаа шалтгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг Авлигын үзүүлэлт буурсан эсэх, Авлигатай тэмцэх

үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт ямар индексээр тооцож, ахиц дэвшил гарсан гэж үнэлсэн талаар, Улсын Их Хурлын гишүүн Мандхай Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийг үнэлэх, дүгнэх боломжгүй байгаа шалтгаан, үнэлэх аргачлалыг баталсан эсэх, хэмжих нэгж байхгүй байгаа шалтгаан, цаашид хэрхэн үнэлэх талаар, Эмээлтийн үйлдвэр, технологийн паркийн бүтээн байгуулалтын үйл явц аль байгууллага хариуцан хэрэгжүүлж байгаа, дэд бүтэц, хөрөнгө оруулалтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах зорилт биелэгдээгүйг Монгол Улсын хөгжлийн биелэгдээгүйг анхаарч уг зорилтыг үнэлэх аргачлалыг сайжруулах, шинэчлэх, энэ чиглэлээр чанарын судалгаа хийдэг эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Батчимэг Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах тэргүүлэх чиглэлийн биелэлт хангалтгүй байгаа шалтгаан, Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллагын үнэлгээний дүн зөрөөтэй байгаа үндэслэл эдгээрийн уялдаа холбоог хэрхэн хангаж ажилласан талаар, Улсын Их Хурлын гишүүн Цэнгүүн эрчим хүчний шинэчлэлийн талаар Эрчим хүчний яамнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох зорилгоор үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн зохицуулалт, тэдгээрт ямар бодлогын дэмжлэг үзүүлэх, ТӨК-удын хариуцлагагүй байдал, ашиггүй ажиллаж байгааг хэрхэн шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, ногоон хөгжлийг дэмжих тэргүүлэх чиглэлийн үр дүн, хэрэгжүүлж буй арга хэмжээ, эрчим хүч, ногоон эдийн засгийг дэмжих хууль, эрх зүйн орчныг бий болгох хуулийн төслүүдийг ЗГ-аас Улсын Их Хуралд хэзээ өргөн мэдүүлэх, хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулах бодлого, төрийн хэмнэлтийн бодлогын хэрэгжилт, нийслэлийн дагуул хотын төлөвлөлтийн талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг намууд ЗГ-т хамтарч ажиллаж байгаагаа анхаарч алдаа оноогоо тодорхой ярилцах, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын нийтлэг эрх ашиг, хөгжилд хүрэх эрэмбийг тодорхойлж, ажлыг дэс дараалалтай эрчимжүүлэх. Үүнд, хүний хөгжил, дэд бүтэц, дагуул хот, эрчим хүч, уул уурхайн салбарын асуудал, ашигт малтмал, уул уурхайн салбарын хууль, эрх зүйн орчныг тодорхойлж шинэчлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Батбаатар төлөвлөгөөний үр дүнгийн биелэлт хангалтгүй, эрчимжүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн төсөл арга хэмжээнүүдийг хариуцсан албан тушаалтанд хариуцлага тооцох эсэх, энэ чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ бий эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Болормaa дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрүүдийг гаргах бөгөөд хүний хөгжлийн, нийгмийн хөгжлийн, байгаль орчны, засаглалын, бүсийн хөгжлийн, үндэсний өрсөлдөх чадварын, шинжлэх ухаан, технологийн зорилтот хөтөлбөрүүдийг уялдаа холбоо, дэс дараатай боловсруулж өргөн мэдүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Батболд төлөвлөгөө дунджаар 67,7 хувьтай хэрэгжсэн байгаа хариуцлагыг хэн хүлээх, 5 жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэлийн тайланг дүгнэхдээ сонгуулийн жилийн өмнөх, өмнө хийх үнэлгээний аргачлалыг боловсронгуй болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл үнэлгээнд чанарын судалгаа хийх аргачлалыг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг хэмжигдэхүйц, хүрэлцэхүйц үзүүлэлттэй байх зорилтот түвшинтэй уялдах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүдийг анхаарах, зарцуулалтыг сайжруулах, хариуцлагыг тодорхой байлгах талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир холбогдох эрх бүхий байгууллагуудын

үнэлгээ хийх аргачлалыг боловсронгуй болгох, зорилго, зорилтуудын эцсийн дүнд иргэдийн амьдралын чанар сайжирсан байх ёстой атал үнэлгээ, бодит байдал 2 зөрөөтэй байгааг ЗГ анхаарч ажиллах, Үндэсний аудитын газраас гаргасан дүгнэлт, зөвлөмжид хэрэгжилт хангалтгүй, төсөл, арга хэмжээнд төсвийн асуудлыг баталж өгдөггүйгээс санхүүжилт хангалтгүй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Шижир үнэлгээ зөрөөтэй байгаа шалтгааны талаар, хүрэх үр дүнг зөв тооцоогүй, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хоорондын зөрчлийг арилгахад анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Мандхай үнэлгээг ойлгомжтой болгох, Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлийн хүрээнд бодлогын яамны хувьд аргачлалыг тодорхой тусгах талаар, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж Засаглалын үзүүлэлтийг сайжруулах, ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүнийг оновчтой тогтоох талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ тайланг хэлэлцэх ажлыг ажлын хэсгийг оновчтой тогтоох, асуудал эрхэлсэн сайд, асуудал хариуцсан гол албан тушаалтныг оролцуулах, үнэлгээ хийх аргачлалыг тодорхой болгох, үнэлэх аргачлалыг нэгтгэх, ойлгомжтой байх, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар саналаа илэрхийлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилт болон Монгол Улсыг 2021-ээс 2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 2024 оны гүйцэтгэлийн тайланг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Монгол Улсын Ерөнхий сайд, Тогмидын Доржханд Монгол Улсын Шадар сайд, Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Эрдэнэбилэгийн Одбаяр Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга, Буяагийн Тулга Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, Равжихын Эрдэнэбүрэн Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга, Батмөнхийн Батцэцэг Гадаад харилцааны сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Оюунсайханы Алтангэрэл Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цэвэгдоржийн Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Сандагийн Бямбацогт Батлан хамгаалахын сайд, Салдангийн Одонтуяа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Пүрэвсүрэнгийн Наранбаяр Боловсролын сайд, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээврийн сайд, Чинбатын Номин Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Жамбын Батсуурь Хот байгуулалт, барилга, хот, орон сууцжуулалтын сайд, Жадамбын Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Цэндийн Баатархүү Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Тогтмолын Мөнхсайхан Эрүүл мэндийн сайд.

Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД, Лханаажавын Мөнхтүшиг ГХЯ-ны ТНБД, Нэргүйн Мягмар ХЗДХЯ-ны ТНБД, Дагвадоржийн Ганхуяг БХЯ-ны ТНБД, Ханджавын Батжаргал Боловсролын яамны ТНБД,

Лхагвасүрэнгийн Мөнхзул ГБХНХЯ-ны ТНБД, Сандагдоржийн Батболд ЗТЯ-ны ТНБД, Нансалын Тавинбэх ЭХЯ-ны ТНБД, Дагвадоржийн Очирбат ЭМЯ-ны ТНБД, Сэрээтэрийн Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Пушаагийн Алтан-Од Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын ерөнхий газрын дарга, Чадраабалын Өнөрбаяр ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газрын дарга, Шаравын Мөнхцэрэн ЗГХЭГ-ын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга, Дэмчигийн Тэгшжаргал ГХЯ-ны Хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын захирал, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Харнүдэнгийн Мөнхзул Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Чойдогдэмэдийн Энх-Амгалан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Цэвээндоржийн Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Жигжидсүрэнгийн Өнөржаргал Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга.

Дэлэгийн Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Ядамын Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Хоржавын Баярмаа Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Батчулууны Сандуйжав Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер.

Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 24 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, аудитын тайлантай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Асуулт, үг хамтдаа явна. Кнопоо ахиад дар, 2 дараад гарчихдаг юм байна лээ буцаад. Хурууныхаа хээг уншуулж, бүртгүүлсэн юм уу? Бүртгүүлээгүй хүн орохгүй л байгаад байх шиг байна даа. Бүртгүүл. Нийт 35 гишүүнээр тасаллаа. Юу яая даа нэрээ хүчингүй болгочихъё, ахиад нэр аваадахъя даа.

Асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгье. Булгантуяа гишүүнийг оруулаад, нийт 37 гишүүнээр тасаллаа. Мөнхсоёл гишүүн нэмэгдэх юм уу? Түвшин, Ганмаа гишүүн, ингээд 40 гишүүнээр тасаллаа. Бейсен гишүүн нэмэгдэх юм уу, кнопоо дар даа та, хаагдчихаад байгаа байх л даа. Энэ чинь нөгөө хугацаатай учраас хаагдчихаад. 4 гишүүн нэмэгдье. Бейсен гишүүн, Мөнхсоёл, Цогтгэрэл, Түвшин, Ганмаа, Булгантуяа гэсэн 5 гишүүн нэмэгдэх юм байна тийм ээ. 41 гишүүнээр нэр тасаллаа. Ирсэн ирцийн дарааллын дагуу Дуламын Бум-Очир гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Бум-Очир: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Аудитын тайлан дээр олон ноцтой зүйлс байгаад байна. Тэрний нэгийг нь онцолж та бүхнийг анхаарлаа хандуулна уу гэж хүсмээр байна. Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн эцэслэгдсэн төслийг олон нийтээр хэлэлцүүлээгүй байна гээд энэ 10 дугаар хуудсанд заачихжээ. 24 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга

хэмжээний тухай асуудал дээр мөн ялгаагүй тайлан дээр бүх талын оролцоог хангасан байх ёстой гэдэг ийм хуулийн зарчим байгаа. Оролцоог ханган боловсруулах гэдэг. Энэ хөгжлийн төлөвлөгөөнүүд дээрээ олон нийтийн оролцоог хангах талын асуудлыг энэ дээр нэг тайлбар энэ тэр байвал хийгээч. Энэ бол харахад зүгээр ингээд аудитын тайлан юм шиг боловчиг нөгөө талдаа нэлээд ноцтой асуудлуудыг дагуулаад байгаа болов уу гэж би бодож байна. Энэ Varieties of democracy гэдэг Шведийн Gothenburg их сургуулийн V-Dem гэдэг хүрээлэнгээс гаргадаг сэтгүүл. Та бүхэн мэдэх байх. Дэлхийн бүх улс орнуудын ардчиллыг хэмждэг.

Монгол Улс 21 оноос хойш ухраад байна. 24 онд 84, 25 онд дахиад 84 дүгээр байран дээр, тэгээд тэр ард нь сум заадаг тэр нэг улаан сум нь дахиад доошоо харсан сум энэ чинь уруудаад байна гэсэн үг. Тэгээд энэ тайланг та бүхэн үзнэ биз. Энэ тайлангийн 10, 14, 21, 42 дугаар нүүрэн дээр Монголын тухай бичсэн байгаа. Дэлхий дээр байгаа улс орнуудаас 2 улс орныг бид ардчиллаас алдлаа гээд биччихсэн байж байгаа. Нэг нь Энэтхэгийг хэлсэн байна. Нэг нь Монголыг хэлсэн байна. Тэгээд бид 90 оноос хойш олж авсан хамгийн чухал үнэт зүйлсийн нэг нь ардчилал гэж би ойлгодог. Энийг Монголын бүх ард түмэн мэдэж байгаа, зөвшөөрч байгаа гэж бодож байна. Гэтэл энэ олон улсын судалгааны хүрээлэн байгууллагаас гаргаж байгаа тайлан дээр бид автократ гэдэг ангилал руу албан ёсоор орчихсон байгаа. Монголыг магадгүй 24, 25 оноос ардчилсан биш автократ улс гэх гээд байна шүү дээ. Энэ бид 1990-ээд оноос хойш олж авсан хамгийн чухал үнэт зүйлсээ хамгаалах тухай асуудал. Энэ дээр тусгайлан ажлын хэсэг гаргаад юм уу эсхүл тусгайлан судлаад ажиллаач. Бид 21 оноос хойш энэ дээр олигтой ахиц дэвшил гаргасангүй шүү дээ. Тэгээд бид ингээд тэгээд энэ дээр яг бичсэн байна л даа.

Парламентын ардчилалтай сонгуультай мөртөө автократ дэглэмтэй гэдэг ийм хувилбар луу ороод байна. Энэ бидний өнөөдрийн Монголын нөгөө identity буюу ижилслийн нэг чухал элемент нь байхгүй юу. Ардчилсан Монголчууд, ардчилсан Монгол Улс гэж биднийг 90 оноос хойш нэрлэж байгаа. Бид өөрсдөө тэгж итгэж үнэмшиж байгаа шүү дээ. Тэгэхээр ямар, ямар асуудлууд нь болохгүй болчихоод байгаа юм энийгээ нарийвчлан судлаач. Дараагийнхаа төлөвлөгөөнд энэ 84-д байгаа байраа яаж урагшлуулах юм, тусгай төлөвлөгөө бодлого гаргаж ажиллаач. Тэгэхгүй ингээд хойшлоод байх юм уу 24, 5 онд ингээд 84 дүгээр байрт байна гэж байна, 26 болохоороо яах юм бэ, энэ хэвээрээ удаан байвал бид тэгээд яах юм? Автократ гэж хэлээд сууж байх юм уу эсхүл ардчилал гэдгээсээ бид ухрах гээд байгаа юм уу, ямар учиртай юм болоод байгаа юм бэ? Энийг анхаарч үзээсэй гэж хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав хариулт өгье. Ажлын хэсгийн хэддүгээр микрофон бэ, хэн хариулах гэж байгаа юм? Ажлын хэсгийн 8 дугаар микрофон.

Д.Энхболд: Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Энхболд. Манай аудитын тайланд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн зарчмуудыг хангасан уу, төлөвлөгөөг боловсруулахдаа үндсэн чиглэлийг боловсруулахдаа гэдэг байдлаар зарчмын үүднээс авч үзээд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3-д нь энэ бичиг баримтыг боловсруулахдаа олон нийтийн оролцоог хангасан байх, эрдэм шинжилгээний

байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн судалгаа шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудаас саналыг авч, төлөвлөгөөг эцэслэнэ гэдэг энэ шаардлагыг хангаагүй байна гэсэн дүгнэлтийг өгсөн байгаа. Тэгэхээр энэ дээр төлөвлөлтийг боловсруулж байгаа бодлого хариуцаж байгаа хүмүүс нь яагаад энэ шаардлагыг хангаагүй гэдэг дээр саналаа хэлэх байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Энэ аудитын байгууллагын ажилладаг арга барилтай холбоотой л бодлогын асуудлыг Бум-Очир гишүүн асуусан шүү дээ. Тэгээд аудитын байгууллага ажиллах арга барил дээрээ, бодлого дээрээ ямархуу өөрчлөлт оруулах юм бэ? Гүйцэтгэлийн аудитын түвшинд асуудал яваад байх юм уу, үгүй юм уу гэдэгтэй холбоотой асуудал хөндөгдөөд байх шиг байх юм. Загджав дарга энэ дээр өөрөө хариулна. Улсын Их Хурлын өмнө ажлаа хариуцаж байгаа албан тушаалтнууд асуултад өөрсдөө хариулдаг болно. Төлөөний хүн хариулдаг энэ тогтолцоо цаашдаа байхгүй. Салбарын сайд, Их Хурлаас томилогдсон албан тушаалтнууд өөрсдөө ажлаа хариуцна. Загджав дарга хариулъя. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон, дугаар байна уу? 9 дүгээр микрофон.

Д.Загджав: Гишүүний асуултад хариулъя. Сая гишүүн тухайлсан асуултыг ардчиллын индекстэй холбогдуулаад асууж байна лээ. Тэгэхээр манайхаас асуугаагүй гэж ойлгож байгаа. Ерөнхийдөө дэлхий дээр энэ аудитын ийм 3 тогтолцоо байгаа аудит хийж байгаа. Ерөнхий аудитын тогтолцоо, аудитын шүүх, аудитын зөвлөл гээд. Тэгээд энэ 3 тогтолцооны ерөнхий аудитын тогтолцоо нь манай дээр байдаг. Энэ хүрээндээ бид аудитын зөвлөх үйлчилгээ, дүн дүгнэлтийг гаргаж, зөвлөмж шаардлага, акт багтааж тавьж ингэж ажиллаж байгаа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмж хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Мэдээж индексээр, индексүүдийн хувьд зарим индекс урагшилсан, зарим индекс ухарсан ийм асуудлууд байгаа. Бидний хувьд нээлттэй ярих, ярихгүй олон асуудлууд дээр парламентын гишүүд хамтдаа дүгнэлт хийх асуудлууд ч байна. Нягтлаад, задаргаатай холбоотой олон улсын байгууллагуудтай ч юм уу уулзахад манай хэд хэдэн индекс яг энэ геополитикийн нөхцөл байдалтай холбоотой асуудлууд дагуулсан. Манай улсын хувьд сая ОХУ Украины энэ нөхцөл байдал дээр түдгэлзсэн ийм саналыг өгсөн. Яг тухайн цаг үед Энэтхэг ч тэр, манайх ч тэр яг ийм байр суурьтай байх нь л зүйтэй л гэж Үндэсний аюулгүй байдал, Аюулгүй байдлын байнгын хороо болон бусад зүйлүүд дээр 3-аас 4 удаа ч ярилцаж байсан. Яах вэ Батцэцэг сайд энийг тайлбарлах нь зүйтэй байх.

Монгол Улсын гадаад бодлого бол олон тулгууртай, энхийг эрхэмлэсэн ийм л гадаад бодлого. Гэхдээ манай улсын газар зүйн байршлын онцлог 2 дэлхийн том гүрний дунд оршин тогтнодог, парламентын засаглалтай ийм улс. Сая сүүлийн 2-оос 3 жил аавыгаа сонгох уу, ээжийгээ сонгох уу гэдэг шиг л ийм төвөгтэй нөхцөл байдлууд үүссэн. Энийг бид дотроо илэн далангүй ярих л ёстой. Гэхдээ Монгол Улс өөрийнхөөрөө л бодлогоо тодорхойлж, парламентаараа ярилцаж ингэж явахгүй бол энэ нь өөрөө манай аюулгүй байдалтай холбоотой эрсдэлтэй ийм олон асуудлууд, саналууд гардаг. Тийм учраас үүнтэй холбоотой ийм асуудлууд тодорхой хэмжээнд үүссэн. Мэдээж биднээс өөрсдөөс нь хамаарах энэ дээр алдаа оноонууд гарсан. Тайлбарлагдаад урагшилсан ийм индексүүд ч байгаа. Тийм учраас ер нь энэ индексүүдийг бид цогц байдлаар ямар аргачлалаар үнэлэх вэ,

индексүүдийн талаарх ойлголтоо бид хэрхэн цэгцлэх вэ гэдэг туйлын чухал ийм зүйл байгаа. Тэгээд дэлхийн бидний дэлхий дээр байгаа геополитикийн энэ нөхцөл байдал та бүхэн ч гэсэн ажиглаж байгаа байх. Нэлээдгүй л хэмжээнд бид ийм өөр дэлхийд амьдарч байна. Маш их нухацтай дүгнэлттэй, маш их олон талаас нь ярилцаж ийм дүгнэлтээ бидний хувьд дотооддоо нэг болгох ийм зайлшгүй шаардлагууд байгаа гэж бодож байгаа. Тэгээд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дуламын Бум-Очир гишүүн тодруулж асууя.

Д.Бум-Очир: Яг аудитаас ч асуусан асуулт энэ биш л дээ. Бид Монголыг олон нийтэд гадаадад тодорхойлж байгаа олон зүйлс бий. Тэрний нэг нь энэ индексүүд. Бид өөрсдийгөө дотроо ч гэсэн тодорхойлж байгаа. Гэтэл өнөөдрийн бид нарын хамгийн их ярьдаг, бахархдаг ололт амжилт гэж үздэг ардчилал маань атократ гэж олон улсад тодорхойлогдоод байх надад таалагдахгүй байна. Энийг бид бодмоор байгаа юм. Өчигдөр ч гэсэн тэр бие дааж нэр дэвшигчид 801 хүний санал гэсэн Их Хурлын гишүүд ихэнх нь дэмжээгүй. Би маш их харамсаж байна. Баасанжаргал гишүүн энэ тэр хэлсэн шүү дээ. Англи яадаг вэ гэхээр 10 хүний гарын үсгээр, энэ дээр ингээд байна. Герман 200 хүний гарын үсгээр, Канад 100 хүний гарын үсгээр, Франц 500 хүний гарын үсгээр бие дааж нэр дэвшдэг байхгүй юу. Энэ бүхэн чинь бид нарыг ардчиллаасаа ухарч байгаа юм шиг харагдуулаад байна шүү дээ. Энэ хөгжлийн төлөвлөгөө энэ тэрээ олон нийтээрээ хэлэлцүүлж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулъя. Өчигдөр чинь Байнгын хороон дээр энэ Цэцийн дүгнэлтээ хүлээгээд авчихсан шүү дээ Бум-Очир гишүүн. Тийм, Цэцийн гаргасан дүгнэлтээ хүлээгээд авчихсан, одоо хуульд өөрчлөлт оруулж босго тогтоохтой холбоотой асуудал эхэлнэ. Учрал сайд.

Н.Учрал: Энэ индексүүд өөрөө тус бүрийн индикаторуудтай. Тэгэхээр бид өөрөө энэ хяналт шалгалтыг хийхдээ нэг дизайнтай, нэг мониторингтой, нэг үнэлгээтэй болохгүй бол яг олон улсын индексүүдээр барьдаг тэр индикаторуудыг хэрэгжүүлж чадахгүйгээс болоод өнөөдрийг хүрсэн. Тийм учраас засаг дээр энэ хяналт шинжилгээ, үнэлгээг нэгтгэх ажлууд хийгдэж байна. 2-т тэр ардчиллын индексээр, авлигын төсөөллийн индекс дээр илүү урагшилъя гэвэл манайд 2 шаардлага тавьсан. Тэр бол төрийн өмчийн компанийн засаглал, бие даасан засаглалын хуулийг гарга. 2-т нээлттэй ил тод, байдал, олборлох салбарын ил тод байдлын санаачилгыг дэмж гэсэн. Энэ 2 хуулийг хаврын чуулганаар өргөн мэдүүлнэ. Ингэснээр индексэд бол эерэг нөлөө үзүүлнэ. Үүнийг бид яг OECD зарчмаар энэ хуулиудыг барьж байгаа. Тэгэхээр энэ өөрөө өөрчлөлтийг өгнө. Тэгэхээр энэ саналуудыг би хүлээж авч байна гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууя, үг хэлье.

Б.Пүрэвдорж: Өнгөрсөн онд Шадар сайд Доржханд, Эрчим хүчний сайд Чойжилсүрэн нар манай бүлэг дээр орж ирж үнэ чөлөөлөх тухай асуудлыг ярьсан байгаа. Тэгээд энэ дээр би нэг зүйлийг хэлсэн. Өөрөөр хэлбэл таны наадах дагуулж явж байгаа хүнд суртлын бий болгодог албан тушаалтнуудаа солиогүй цагт, тэр төрийн өмчийн компани дээр байгаа тонон дээрэмдэлтийг байхгүй болгоогүй цагт үнийг чөлөөлж болохгүй л гэж би хэлсэн. Та маш яаралтай тэр дотоод аудитынхаа даргыг сольж байгаад, тэр дотор байгаа өөрсдийнхөө Эрчим

хүчний яамны тэр авлигажсан түшмэлүүд, тэр төрийн өмчийн компаниудын тонон дээрэмддэг тэр нөхдийг бүгдийг нь маш хурдтай тэр дотоод аудитаараа шалгуулж сольж байж, үнийн өөрчлөлтийг хийгээрэй гэж зөвлөсөн.

Гэвч харамсалтай нь хийгээгүй. Өнөөдөр эрчим хүчний салбарт дэндүү их луйвар байгаа. Жишээ нь Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээний баруун бүсийн захирал болгоод өгөөч 300 сая төгрөг өгье гээд явж байдаг юм байна лээ шүү дээ. Төрийн өмчийн компани дээр бараа бүтээгдэхүүн шахдаг, тоног, төхөөрөмж шахдаг бүхэл бүтэн сүлжээ бий болчихсон. 1 тэрбум төгрөгийн бараа өндөр үнэтэйгээр шахчхаад, жоохон байж байгаад 200 сая төгрөгийн барааг нь дотроос нь хэрэглэсэн гэж хулгайлаад, түүнийгээ буцаагаад шахдаг юм байна лээ шүү дээ. Бүүр аргаа, би энэ бүүр нэлээн аргаа барж байж 9,5 тэрбум төгрөгийг Ховд аймгийн дулааны станцыг өргөтгөх, Ховдынхон дулаан амьдрах тэр боломжийг хангах тэр мөнгийг улсын төсөв дээр тавьсан чинь Тавинбэх сайдын үед тэдний албан тушаалтнууд 3 цүнхний компанид өгөөд, өнөөдөр тэнд Ховдын ард түмэн хохироод байж байна шүү дээ. Ийм байдлаар ер нь бол яг үнэ эрчим хүчний салбарт байгаа тэр мөсөн уул авлигажсан луйварчин тэр түшмэлүүд, дээрээс нь тэр төрийн өмчийн компаниудад байгаа тэр маш өндөр үнээр бараа, бүтээгдэхүүн шахдаг тендерийн луйварчид энэ бүхнээсээ салаагүй цагт эрчим хүчний үнэ чинь буухгүй шүү дээ.

Тэр авлигажсан нөхдүүдийн хулгайн дээр өссөн цахилгааны үнэ дээр энэ Монголын ард түмэн нус нулимсандаа гоожин, тэр зовлон зүдгүүр бүх шаналал дээрээ та нарын тэр авлигажсан төлбөрийг төлж байгаа шүү дээ. 200 мянган төгрөг төлдөг байсан тэр жирийн иргэд 800 мянга, 900 мянга төлдөг болсон шүү дээ. Энэ цахилгааны төлбөрийг төлөхийн тулд залуучууд нь хэд хэдэн аппликэйшн дамжуулан зээл дахин, дахин авдаг, ахмадууд нь тэтгэврийнхээ мөнгөөр бүгдийг нь төлдөг ийм зүйл бий болж байгаа. Тийм учраас Чойжилсүрэн сайдаа тэр дотоод аудитаа хурдан соль, тэгээд тэр дотор байгаа тэр луйварчдаас сал. Тэгж байж л энэ цахилгааны үнийг бууруулах, энэ ард түмэндээ боломжийн үнээр өгөх тэр ажлуудыг хийнэ мэдсэн биз дээ. Тэгээд өнөөдөр тэр Тавинбэх сайд чинь тэгж байна лээ шүү дээ. Одоо энэ сэргээгдэх эрчим хүчний бүх зөвшөөрөл өгөөд дуусчихсан. Тэгээд 7, 8 компани ажлаа хийгээгүй. 2008 оноос хойш 1 ширхэг ч хадаас хадаагүй компани зөвшөөрөл авчхаад 17, 8 жил болж байхад тэрийг цуцлах эрх нь Тавинбэх сайдад, Төрийн нарийн бичгийн 2 жилийн хугацаанд, дээрээс нь ТНБД-аар ажиллаж байсан 3 жилийн хугацаанд, нийтдээ 5 жилийн хугацаанд тэр Эрчим хүчний зохицуулах хороог.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баттогтохын Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Пүрэвдорж гишүүнээ янз бүрийн ийм хардлага, шүүмжлэл байхыг үгүйсгэхгүй. Хүлээж авна. Гэхдээ хардсан юм бол тодорхой яг ийм, ийм мэдээлэл байна, энийг шалгаад нэг талд нь гарга гэдэг ийм санал байвал бид хамтарч ажиллахад 1 дүгээрт бэлэн байна нэг. 2 дугаарт дотоод аудитыг улирал болгон бид байнга хийгээд явж байгаа. Дээрээс нь нэмээд бид Одбаяр сайд ЗГ-ын Хэрэг эрхлэх энэ хяналт шинжилгээ, үнэлгээний юуг бид урилгаар оруулах гэж байгаа манай энэ яаман дээр. Энэ хүмүүсийн энэ хэл амтай ийм үнийг жоохон өөрчлөх гэж оролдсон. Энэ бол нэмсэн зүйл биш, өртөгт нь ойртуулах гэсэн ийм л алхам байсан. Шүүмжлэл

дагуулж байгаа нь үнэн. Тэгэхээр бид тодорхой танд санал байвал тодорхой хариулаад явна.

Таны, тантай нэг санал зүйл, санал дээр нэгдэж байгаа юм. Энэ гарцаа байхгүй энэ олон нийт энэ нэмэгдүүлсэн үнэ байгаа юм бол нэмэгдүүлж байгаа юм бол чанар сайжрах ёстой, ил тод байх ёстой, авлига буурах ёстой гэдэг ийм зарчмыг эрчим хүчний салбараас сүүлийн 2, 3 жил бид тодорхой баримталж ажиллаж байгаа. Жишээлбэл тэр эрчим хүчний үнийн өөрчлөлтөөс тодорхой хэмжээний 560-аад тэр тэрбум төгрөг орж ирж байгаа бол өнгөрсөн долоо хоногт бид Эрчим хүчний зохицуулах хороон дээр нь б... нь бодож явсан. Энэ бүгдийг бүгдийг нь олон нийтэд ил тод тайлагна ойрын хугацаанд. Ийм, ийм зүйлүүд дээр зарцуулагдаад ийм зүйл болж байна, ийм хүндрэлтэй асуудлыг шийдэж чадаж байна, энийг нь чадахгүй байна гэдгээ л олон нийтэд ил тод хэлнэ. Ийм байр суурьтай байгаа.

Жишээлбэл бид өнгөрсөн юу бид дулааны үнийг нэмэгдүүлж чадахгүй байна, инфляц өндөр явж байгаа гэдэг ийм шалтгаан байгаа учраас хүлээн зөвшөөрөхөөс ондоо аргагүй. Энэ эрчим хүчний реформын маань хурдац жоохон сүүлийн үед саарч байгаа нь үнэн. Гэхдээ энийг 2028 оны төгсгөл гэхэд ЗГ-ын бүрэн эрхийн хугацаа дуусахад энэ ЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт суусан энэ арга хэмжээнүүдийг бүрэн хийж дуусгахаас ондоо арга байхгүй. Яагаад гэвэл Улсын Их Хурал батлаад өгчихсөн, Улсын Их Хурлын шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй ЗГ. Түүний дотор эрчим хүчний салбар энэ тал дээр манлайлан ажиллана гэдгийг хэлье.

Янз бүрийн хүндрэлтэй, яг бодит мэдээлэл байгаа бол хүлээж авахад бэлэн. ТЭЦ 4 жишээлбэл янз бүрийн асуудал ярьдаг, авлига уудаг юу юм ярьж байгаа юм. Гэхдээ 1квт цаг эрчим хүчийг бид 90 төгрөгөөр л нийлүүлж байгаа шүү дээ 2,3-хан центээр. Тэр хардагдаад байгаа ТЭЦ 4 маань ийм л үнэтэй байгаа юм. Тэгэхээр энэ Улсын Их Хурал дээр бүрэн эрх юу байгаа шүү дээ хяналт хийж болно, та бүхнийг урьж байна, яг ийм асуудал дээр ийм ААН дээр ийм хүндрэл байгаа бол хамтраад шалгахад бэлэн байна.

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн тодруулж асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр сэргээгдэх эрчим хүчний 7 ААН байгаа. Тэрнийх нь зөвшөөрөл өгчихсөн, цаашаа өгөх боломжгүй гэж байгаа юм. Тэгсэн мөртөө тэр компаниуд нь 10 хэдэн жил ерөөсөө хадаас чадаагүй гэж өөрөө Тавинбэх сайд хэлсэн байгаа. Тэд нарыг яагаад ингээд зөвшөөрлийг нь хаахгүй байгаа юм бэ? Дараа дараагийнх нь ажил хийе гэж байгаа тэр компаниудад нь яагаад өгөхгүй байгаа юм. Дээрээс нь хэзээ ч жишээ нь хөдөөгийн тэр Ховдын хүн хэзээ ч тэр сэргээгдэх эрчим хүчний хэрэглэж үзээгүй. Тэгсэн мөртөө тэрний төлбөрийг төлдөг. Тэгсэн тэрний харин эзэд нь Швейцарт дээшээ хараад ард түмний ингээд нуруун дээр жаргаад ингээд байж байдаг ийм тогтолцооноосоо хэзээ болих юм бэ гэдэг ийм асуудал хэлсэн.

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд тодруулж хариулт өгье. Нэмэлт хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Пүрэвдорж гишүүний асуултад нэмээд хариулъя. Пүрэвдорж гишүүнээ 2006 онд анх Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль батлагдсан юм байна лээ. Тэр үеэс хойш 1квт цаг эрчим хүчийг наран дээр 15-аас 19 центээр, салхин дээр 9,5 центээр нийлүүлээд явж байсан. Нийтдээ энэ өнгөрсөн цаг хугацаанд 2019 оныг хүртэл 38 тусгай зөвшөөрөл сэргээгдэх эрчим хүчний нар, салхин дээр олгогдсон байдаг. Энэнээс яг одоо төвийн эрчим хүчний сүлжээнд залгаатай байгаа 6 нарны станц, 3 салхины станц байгаа. Үүнээс гадна тухайн үед энэ 2019 оны Сэргээгдэх эрчим хүчний хуулийн өөрчлөлтөөс өмнө авчихсан байсан энэ 38 зөвшөөрлөөс яг намайг Эрчим хүчний сайд 2022 оны 8 сард очиход 8 ширхэг нарны станц, 3 ширхэг салхин станц нийтдээ 11 тусгай зөвшөөрлүүд хүчин төгөлдөр байсан. Эдгээр юу би танд дахин давтан хэлье. 1квт цаг эрчим хүчийг 15 центээс 19 центээр гэрээнд нийлүүлэхээр ийм гэрээнүүд хийгдчихсэн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж минут өгье.

Б.Чойжилсүрэн: Нийтдээ манай эрчим хүчний салбарын 9 хувийг эрчим хүчний нийлүүлчхээд төлбөрийнх нь 27 хувийг авч байгаа. Сэргээгдэх эрчим хүчний салбарын ашиг манай эрчим хүчний салбарын алдагдалтай тэнцэж байгаа ийм нөхцөл байдал байгаа нь үнэн. Тэгэхээр эдгээр ААН-үүдийг цаг хугацаандаа ажлаа эхлээгүй болохоор нь Эрчим хүчний, Эрчим хүчний зохицуулах хорооноос тусгай зөвшөөрлийг нь цуцлуулах арга хэмжээг тасралтгүй авч ирсэн. Гэсэн хэдий боловч шүүхээр энэ асуудлыг дахин сэргээ гэдэг ийм ганц нэг шийдвэрүүд сүүлийн үед гарч байгаа ийм төвөгтэй асуудал байгаа нь үнэн. 15 цент гэдэг чинь 600 гаруй төгрөгөөр л 1квт цаг эрчим хүчийг нийлүүлнэ гээд ийм л хүндрэлтэй яваад байгаа учраас янз бүрийн байдлаар энэ сэргээгдэх эрчим хүчний тусгай зөвшөөрөл авчихсан байсан улсууд маань ил, далд янз бүрийн явуулга явуулдаг нь үнэн. Над дээр, энэ манай салбар дээр тодорхой хэмжээний дарамт сошиал болон хэвлэлийн ийм дарамтууд байгаа.

Д.Амарбаясгалан: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууж, үг хэлье.

М.Ганхүлэг: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 28 оны гол үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлтэй холбогдолтой асуудлыг ярьж байна. Гараа бол сайн бариа сайн гэж бид бүхэн ярьдаг. Асуудлаа тодорхой эрэмбэлээд, томоохон төслүүдээ хөдөлгөж байгаа ЗГ-ын ажилд талархалтай байгаа. Хурдтай хөгжье гэдэг ийм зорилгыг дэвшүүлж байгаа хүрээнд ганц нэгэн анхаарах ийм саналуудыг тодруулж асууя. Монгол Улсын ЗГ-аас 2024 оныг Бүсчилсэн хөгжлийн жил болгон зарласан. Үүнтэй холбогдолтойгоор тэргүүлэх гол анхаарлаа хандуулах 4 чиглэлийн нэг чиглэл нь бүсчилсэн хөгжлийн ийм дэмжих жил ийм чиглэл байгаа. Жил болгон зарлаад, тодорхой ажлууд хийгдээд, ингээд тэргүүлэх чиглэлүүдээ зарлаад ингээд явсан ажлын үр дүнгүүд нэлээн удаашралтай ийм байдлууд харагдаж байна. Үндсэн ажиллах чиглэлийн 4 чиглэлийн хамгийн бага үзүүлэлттэй нь бүсчилсэн хөгжлийн асуудал байгаа.

Тэгэхээр яамнууд маань энэ тодорхой гүйцэтгэл дээрээ анхаарах, үүнтэй холбогдолтой ажлууд дээрээ нэлээн тодорхой мэдээллүүдийг аймаг, орон нутгийн түвшинд өгөхгүй бол болохгүй ийм байдлууд байна гэж ингэж бодоод байгаа юм. Тэгэхээр түүхэн аялал жуулчлалын бүс нутаг болно гэдэг зорилтыг зүүн бүс нутаг гаргасан. Энэ хүрээнд ТЭЗҮ боловсруулах ажлууд аль түвшинд явж байна вэ?

Үүнтэй холбогдолтой тодорхой ажлууд нь бэлэн болоод 2025, 2026 оны улсын төсвүүд дээр ажлууд нь эхлэх ийм хүлээлтүүд байгаа. Гэтэл өнөөдрийн түвшинд ТЭЗҮ шалгаруулалт энэ ажлууд нэлээн удаашралтай ийм байдалтай харагдаж байна.

Гол дэд, хөгжлийн хүрээнд эрчимжсэн МАА-г дэмжих энэ чиглэлийн зорилтыг тавьсан. Гэтэл яамнууд маань үндсэндээ манлайлал үзүүлэх энэ байдлууд нь арай өөрөөр явагдаад байна. Тухайн яг өөрийн бүсийн ХАА-н асуудал руугаа чиглэсэн ийм яам болж сүүл рүүгээ хувирч байна. Тэгэхээр яг зүүн бүс нутгийн хувьд эрчимжсэн бүс болохтой холбогдолтой ХАА-н бүтээгдэхүүний экспортыг бүс орон нутгаасаа хийх асуудал аль түвшинд явах вэ? Энийг яаж дүгнэж байна вэ, өнгөрсөн хагас жилийн хугацаанд ямар байдлаар ажиллаж байгаа вэ гэдэг ийм асуултуудыг яримаар байна.

Хурдацтай хөгжлийн тухай бид ярьж байгаа учраас яг энэ гүйцэтгэлийн төсөв хөрөнгө, энэ зохион байгуулалтын ажлууд үндсэндээ нэг их шаардлагагүй энэ ажлуудаа ингээд хийгээд, дараа дараагийн төсвөөр хийгдэх дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлуудаа эрчимжүүлээд явах зайлшгүй ийм шаардлагууд байгаа учраас энийг хурдлуулах ийм саналтай байна. Аль түвшинд явж байгааг тодруулж байгаа юм.

Цаашдаа бүсчилсэн хөгжлийн энэ чиглэл ямар түвшинд явах вэ гэдэг энэ чиглэл дээр тодорхой мэдээллийг өгч, ерөнхий байр сууриа илэрхийлэхгүй бол яг энийг буруу зөрүү ойлгож байгаа, салбар болгон дээр өөр байдалтай харагдаж байгаа. Аль нэг бүсүүд дээр илүү давуу байдал бий болж байгаа байдлууд бий болохоор байна. Тэгээд энэ дээр анхаарах нь зөв болов уу гэж бодож байна. Орон нутгийн түвшинд ажилласан. 25, 6 хоног малчидтай уулзаад ингээд ажилласан. Тэгээд нэг өглөө босоход махны үнээ хэдүүлээ ингээд квот тогтоочихдог, хязгаарлчихдаг ийм байдлыг халах хэрэгтэй байна. Тэгээд энэ байгалийн эрс тэс нөхцөл байдалд ажиллаж байгаа малчдын маань гол орлого байгаад байдаг. Хүнсний хувьсгалын том хөтөлбөр явуулаад олон компаниуд шинээр нээгдээд байдаг. Тэгэнгүүт ингээд манай ЗГ-аас ингээд махыг хязгаарласан гэдэг ийм байдлууд удаа дараа гарвал энэ салбарын хувьд их нэлээн хүндрэх ийм байдлууд бий болж байна. Тэгээд Жавхлан сайд боломжтой бол энэ Шинэ хоршоо хөдөлгөөн дээр хамгийн их эрэлттэй байсан үржлийн мал худалдаж авах төрлийг ингээд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүнд 1 минут нэмж өгье.

М.Ганхүлэг: Шинэ хоршоо хөдөлгөөний үйл ажиллагаа орон нутагт нэлээн эрчимтэй үргэлжлээд явж байгаа. Тэгээд зүүн бүс нутгийн хувьд нэлээн онцлог ийм байдалтай байгааг бид харгалзан үзэх хэрэгтэй байна. Мал сүргийнхээ дийлэнх хэсгийг ингээд алдчихсан. Нэг жилийн дотор босож өндийж ирэх бүрэн бололцоо нэлээн байхгүй. Бүгдээрээ зээлтэй. Энэ зээлээ төлөхийн тулд амьжиргаагаа сайжруулах, нэмж мал худалдаж авах, нөгөө Шинэ хоршоо хөдөлгөөний үйл ажиллагаанд эрчимтэй хамрагдах үндсэн суурь бааз бэхжүүлэх үндсэн төрөл болсон үржлийн мал худалдаж авах гэсэн энэ заалтыг 8 сарын 01-ийг хүртэлх хугацаанд зогсоосон асуудал зүүн бүсийн хувьд үнэхээр хүндрэлтэй нөхцөл байдал үүсэж байна. Тэгэхээр энэ дээр тодорхой бүсчлэл зохион байгуулдаг юм уу, энэ асуудлыг яам ямар үндэслэлээр шийдсэн бэ гэдэг дээр нэг

тайлбар өгч ингэхгүй бол малчид иргэдийн хувьд төр энэ явуулж байгаа бодлогоо тогтвортой байлгаад өгөөч, махныхаа үнийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Номин сайд эхлээд хариулт өгөх үү? Түүхэн аялал жуулчлалын бүс нутаг ТЭЗҮ боловсруулах үйл ажиллагаатай холбоотой асуудал яригдлаа. Дараа нь бүсчилсэн хөгжлөөр хэн хариулт өгөх юм бэ? Ерөнхий сайд эхлээд хариулт өгчихье. Бүсчилсэн хөгжлийн асуудлаар.

Л.Оюун-Эрдэнэ: Бүсчилсэн тойргоор бид сонгууль явуулчихсан байгаа. Тийм учраас Улсын Их Хурлын гишүүдээ ойлгож байгаа. Түрүү жилийн хувьд бид илүү нийслэл дээр хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй гээд, тэгээд төсвийн хэлэлцүүлгийн үеэр яригдаж байгаад ингээд шийдсэн байгаа. Тэгэхээр энэ чуулгантай бид уялдуулаад ирэх жилийн улсын төсвөөс хэлэлцэгдэхээс өмнө бүсийн Их Хурлын гишүүдтэйгээ ЗГ-ын гишүүд бүс бүхэн дээр ажиллах ийм хуваарь гарч байгаа. Тэгээд очоод бүсээс сонгогдсон иргэдийн Хурлын Төлөөлөгчид, бүсээс сонгогдсон парламентын гишүүдтэйгээ хамт ийм хэлэлцүүлэг хийгээд, түүн дээр ЗГ-ын гишүүд яг гаргаж ирж байгаа саналыг нь эрэмбэлээд, тэгээд бүс өөрөө эдийн засгийн хувьд, дэд бүтцийн хувьд яаж хөгжих вэ гэдэг одоо та бүхний гаргаж байгаа төлөвлөгөөг ЗГ газар дээр нь сонсох нь зүйтэй юм гэж үзэж байгаа юм.

Тэгээд хэдүүлээ хамтдаа л эрэмбэлэх нь зүйтэй. Тэгээд Их Хурлын гишүүд та бүхэн маань нэг зүйлийг анхаараарай. Яг үйл ажиллагааны төлөвлөгөө ороод ирэхээр ийм зүйлийг хийх нь зүйтэй гээд ингээд парламент дээр нэмчихдэг. Төсөв ороод ирэхээр хасчихдаг. Тэгэхээр энэ чинь ингээд бодитой биш болж хувирчхаж байгаа байхгүй юу ер нь бол. Бид багц арга хэмжээг санхүүгээр л хийнэ, санхүү өөрөө улсын төсөв байна эсвэл бид зээл авч хийнэ. Тэгэхээр тойргуудын асуудлыг ч юм уу бид тийм том хэмжээний зээл авч хийх боломжгүй шүү дээ. Тийм учраас бид үйл ажиллагааны хөтөлбөр Засгийн газраас орж ирсэн дээр нэмсэн нь санхүүгээр л баталгаажиж хэрэгжинэ гэдэг дээрээ Их Хурлын гишүүд маань, Сангийн сайд, Хэрэг эрхлэхийн сайд ч гэсэн энэ дээр их тийм сайн ярилцаж явахгүй бол хөтөлбөр дээр батлагдлаа л бол хэрэгжинэ гээд ойлгодог. Дараа нь төсвийг хязгаарлачихлаар наадах чинь тэгээд хэрэгжих боломжгүй л болно шүү дээ. Хаанаасаа мөнгө гаргаж хийх вэ.

Тийм учраас төсвийн бодлого, наад үйл ажиллагааны хөтөлбөр 2 бол нэг л цонхоор харж явахгүй бол ийм зүйл урьд нь ч гэсэн урьдын парламентууд дээгүүр гарч байсан. Их Хурал дээр ингээд нэмчихдэг ийм асуудлуудаа одоо хэдүүлээ улсын төсөв хэлэлцэхээс өмнө хамтдаа ярилцах нь зүйтэй. Тэгээд бүсийнхээ парламентын гишүүдтэй ЗГ-ын гишүүд, ялангуяа ялангуяа Сангийн сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд хамтдаа яг улсын төсөв боохоос өмнө энэ асуудлуудаа нарийвчилж ярихгүй бол төсөв хэлэлцээд эхэлчихсэний дараа хөрөнгө оруулалт дундуур нь тавигдана гэдэг бол худлаа зүйл болдог шүү гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Номин сайд нэмж хариулт өгье.

Ч.Номин: Ерөнхий сайд яг барагцаалаад ер нь хэлчихлээ. Зүүн бүсийн хувьд аялал жуулчлалын тэргүүлэх чиглэл гэж тодорхойлогдсон байгаа. Ингээд бид бүсчилсэн хөгжлийн хүрээнд орон нутагт ажил хийхдээ тухайн бүсэд хийгдэх гэж байгаа ажлынхаа талаар дэлгэрэнгүй тайлан хийхээр төлөвлөгдөж байгаа.

Зүүн бүсийн хувьд бид аялал жуулчлалын тэргүүлэх чиглэлийнхээ хүрээнд ер нь Монгол Улсын хэмжээнд бид аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээндээ нийт соёлын болон байгалийн дэд бүтцийнхээ нөөцүүдийг судлаад 7 бүстэй, 66 аялал жуулчлалын орон зайг тодорхойлсон байгаа. Энэ хүрээнд зүүн бүс дээр мөн энэхүү орон зайнууд тодорхойлогдоод явж байгаа. Үүгээрээ дамжуулан бид Буйр нуурыг жишээ нь аялал жуулчлалын тусгай бүс болгон хөгжүүлнэ. Зүүн бүсийг түүхэн аялал жуулчлалын бүс болгож хөгжүүлнэ гэдэг бодлого тодорхойлогдоод үүнийхээ хүрээнд стратеги нь хийгдээд явж байгаа. Үүнээс гадна Азийн хөгжлийн банктай хамтарсан төслүүд хэрэгжээд явж байгаа. Нөгөө талдаа шинэ төсөл, арга хэмжээнүүд энэ жил ямар нэгэн байдлаар нэмэгдэж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ухнаагийн Отгонбаяр гишүүн асуулт асууж, үг хэлье.

У.Отгонбаяр: Энэ өдрийн мэндийг хүргэе та бүгддээ. Зүүн бүсээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд намрын чуулганы завсарлагаагаар тойрогтоо нэлээдгүй ажиллалаа. Тэгээд орон нутагт ард иргэд, малчидтай нэлээдгүй уулзалтуудыг хийж явлаа. Тэгээд 3 асуулт байна. Маш тодорхой хариулт холбогдох яамнууд өгөөрэй гэж хүсмээр байна. Малчны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна гэдэг асуудал ер нь уулзалт болгон дээр л гарч байна. Тэр дундаа нэг малчин өрхийн хүүхэд үнэ төлбөргүй их, дээд сургуульд сурах боломжтой зүйл энэ хуульд тусгагдсан. Энэний хэрэгжилт ер нь ямар шатандаа явна вэ гэдэг 1 дүгээр асуудал.

2 дахь асуудал орон нутагт тэр дундаа малчны хотонд энэ старлинк тоног, төхөөрөмж нэлээдгүй хэрэглээнд орсон байна. Тэгээд энийг дагасан ямар бодлогын асуудал явж байна вэ? Хэрэглээ нэлээн өндөр болсон байна. Малчид старлинк тоног, төхөөрөмжөө ашиглаж малаа дагаж нүүдэг хэлбэр лүүгээ орсон. Урьд нь сүлжээ муутайгаас болж малчид маань тэр дундаа залуу малчид сүлжээ дагаж, малаа дагаж биш, сүлжээ дагаж нүүдэг байсан. Одоо бол энэ төхөөрөмжийн тусламжтайгаар сүлжээнд байнгын холбогдох боломж бүрдэж, малаа дагаж нүүдэг энэ хэлбэр лүүгээ орсон нь нэг талаараа сайшаалтай байна. Тэгээд энэний татварын орчин ер нь ямар байна вэ? Тэр суурин станц байгуулагдах асуудал ямар түвшинд явна вэ? Татвар хураамж яг старленкийн тоног, төхөөрөмж болон хураамжаас төвлөрүүлж чадаж байна уу, үгүй юу гэдэг дээр нэг тодорхой хариулт өгөөч гэж бодож байгаа юм.

3 дахь асуудал ард иргэд, тэр дундаа зүүн бүсийн малчдаас энэ импортын адууны асуудлыг нэлээдгүй хөндөж тавьж байна. Сүүлийн үндсэндээ 5, 6 жил нэг жилдээ 500 орчим импортын адуу Монгол Улсын хилээр орж ирдэг. Цаашдаа энэ импортын адууг ер нь тодорхой хугацаанд хориглож болдоггүй юм уу гэдэг асуудлыг маш ихээр тавьж байна. Цаашдаа энэ импортын адуу жилдээ 500 орж ирээд, тэгээд үржилд ороод нөгөө 500 нь хэд болж үрждэг юм үүгээр тодорхой тоо баримт байна уу? Тодорхой хугацаанд энэ импортын адууг ер нь зогсоож болох уу, болохгүй юу? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Малчны хүүхэд Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Отгонбаяр гишүүний асуултад хариулъя. Малчны тухай хуулийн 4.2.5-д 10 жилээс дээш хугацаанд доошгүй жил тасралтгүй малчнаар ажилласан хүүхдийн төлбөрийг их, дээд сургуульд суралцсан нэг хүүхдийнх нь

төлбөрийг нь төрөөс даана гэсэн ийм заалттай. Хуулийг бид хэрэгжүүлэх ёстой. Тийм учраас Боловсролын зээлийн сангийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа. Энэ орсноороо 2025 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлээд малчны хүүхдийг яг энэ хуульд заасны дагуу хичээлийн жилээс эхлэн үнэ төлбөргүй сурах ийм боломжтой болно. Тийм учраас бид хэд бэлтгэл ажлыг нь хангаж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баатархүү сайд.

Ц.Баатархүү: Отгонбаяр гишүүний асуултад хариулъя. Харилцаа холбооны бодлогын шинжтэй чухал асуудлыг хөндөж байна. Ер нь алслагдсан бүс нутаг, багуудад, тэр дундаа манай энэ өргөн уудам нутагтай орон нутагт харилцаа холбооны дэд бүтцийг хэрхэн сайжруулах юм бэ гэдэг бодлогын асуудлыг хөндөж байна. Старлинк нам орбитод хиймэл дагуулыг хөөргөөд Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулдаг. Дэлхий даяар 6700 орчим сатлет буюу хиймэл дагуулыг хөөргөж, Монголд албан ёсны компани нь орж ирж үйл ажиллагаагаа явуулж байна.

2024 оны бидэнд ирсэн мэдээллээр Старлинк компани гаалийн татвар, нэмэгдсэн өртгийн татвар, ААН-ийн орлогын татвар нь нийлээд 1,6 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна. Энд ямар асуудал анхаарал татаж байгаа вэ гэхээр ер нь энэ харилцаа холбооны бие даасан байдал Монгол Улсын кибер аюулгүй байдал.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт минут өгье.

Ц.Баатархүү: Үндэсний аюулгүй байдалтай холбоотой ер нь улс орнууд бол энэ нам болон өндөр орбитын хиймэл дагуулаас харилцаа холбооны сүлжээ авахын тулд газрын станцыг тухайн орон нутагтаа зайлшгүй байгуулах ийм бодлогыг барьж байна. Тийм учраас Старлинк компанитай бид энэ газрын станцыг Монгол Улсад байгуулах ийм бодлогын чиглэлийг өгч хамтран ажиллаж байгаа гэдгээ илэрхийлье.

2 дугаарт Отгонбаяр гишүүн ер нь энэ үндэстэн дамнасан технологийн компанийн татварын орчин ер нь ямар байгаа юм бэ гэдэг асуудлыг хөндөж байна. Энэ иргэдээс авч байгаа сар болгон авч байгаа үйлчилгээний энэ орлого Монголд албан ёсоор бүртгэгдэж байна уу гэдэг асуудал дээр дижитал үйлчилгээний татвар гэдэг шинэ татварын орчныг дэлхий даяар ярьж байна. Facebook компани, twitter гэх юм уу, google гэх юм уу үндэстэн дамнасан технологийн компаниуд шууд өөрийнхөө тухайн улсын бүртгэлтэй данс руу хэрэглэгчээс үйлчилгээний орлогыг авч байгаа нь тухайн улсын татварын бодлоготой зарим талаараа нийцэхгүй байна гэж үзэж, энэ асуудал дээр харилцан ойлголцохоор маш олон улс орны засгийн газрууд ажиллаж байна. Тийм учраас энд 2 дугаар сар гэхэд зөвхөн зар сурталчилгааны зардалд үндэстэн дамнасан компаниуд руу 2,7 сая доллар гарсан байна гэдэг ийм мэдээлэл байгаа. Тийм учраас цаашдаа энэ технологийн компаниудын цахим үйлчилгээний татварын орчин гэдэг цоо шинэ бодлогыг энэ Улсын Их Хурал, энэ ЗГ хамтарч гаргах шаардлага үүсэж байна гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Импортын адуу Жавхлан сайд хариулт өгөх үү? Хөдөө аж ахуйн сайд байхгүй байна. Та 2 Дарханаас сонгогдсон юм чинь яадаг юм төлөөлөөд хариулчихвал. Жавхлан сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Туваан сайд моринд арай ойрхон байх намайг бодвол. Манайх татвараас хүн байна уу, татвараас? Би ямар ч байсан түрүүн Старлинктэй холбоотой татварын мэдээ хэлчихье. Старлинк компани татвар төлөлгүй яах вэ. Жишээ нь 24 онд оноос эхлээд тайлангаа гаргаж татварын байгууллагад хүргүүлж эхэлсэн байна. Ингээд борлуулалт өнгөрсөн жил 9,4 тэрбум, үүнд ноогдох татвараа төлсөн байна. 25 оны 1, 2 сард тайлангаа гаргаад ингээд эхний улирлын тайлангаараа татвараа төлөөд явах юм байна. Тэгэхээр компани хэвийн татварын орчинд эрсдэлгүй ингээд явж байгаа гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд түрүүний нөгөө Ганхүлэг гишүүн гараад явчихсан байна, орж ирэхээр нь хариултыг нь өгүүлье. Би хариулт өгүүлэлгүй дутуу орхиод явчихсан байна. Хоршоотой холбоотой зээлийн асуудлууд яриад байсан, орж ирэхээр нь хариулт авъя. Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууя.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд. 2024 онд эрчим хүчний реформ эхэлсэн. 3 намын хамтрал болоод олон жил гацсан энэ реформыг хийхийн тулд Шадар сайд, Эрчим хүчний сайд, тэгээд 3 намаас 2, 2 гишүүн оролцсон ийм Эрчим хүчний үндэсний хороогоо эхлүүлээд явсан. 2024 ондоо бид бодлогоо тодорхойлоод, энэ салбарын хууль, эрх зүйн орчныг цогцоор шинэчлэх, зах зээлийн зарчимд нь шилжүүлж либералчлах бодлогоор дамжуулж гаднын хөрөнгө оруулалтуудыг татах, үнийн бодлогыг шинэчлэх, эрчим хүчний компаниудын алдагдлыг бууруулж, менежмент сайжруулаад, цаашдаа энэ компаниудыг олон нийтэд нээлттэй компани болгоно гээд бодлогоо гаргаад явсан. Гэтэл одоо 6 сар өнгөрч байна. Энэнээс хойш үнэ тарифт өртөгт нийцүүлэхээс өөрөөр ямар нэгэн дорвитой өөрчлөлт гараагүй гэдгийг олон нийтээс ч маш их хэлж байгаа юм.

Тэгээд энэний үндсэн шалтгаан нь бодлого дээрээ бид нэгдэж чадахгүй байгаа юм болов уу гэж би хараад байгаа юм. Үндсэндээ урт хугацааны тогтвортой гэрээ байгуулаад төр, хувийн хэвшлээр хамтралаар чадлын том станцууд барих тактик яригдаад байгаа юм. Баянгийн 600мвт-ын станц жишээ нь. Үндсэн асуудал нь юу вэ гэхээр манай Монгол орон чинь өөрөө өргөн уудам тал нутагтай, хүн ам нь тархай бутархай суурьшдаг. Эндээс харахаар жижиг сууринуудад тархмал эх үүсвэрүүдийг тавиад микро грийт ийм сүлжээнүүдийг бий болгох нь бид нарын хувьд санхүүгийн хувьд ч өртөг зардал багатай. Дээрээс нь нэг 600мвт-ын станц байснаас 50мвт-ын жижиг станцууд байх юм бол олон тоглогч нарыг оруулж ирээд, жинхэнээсээ бодитоороо энэ маань өөрөө өрсөлдөөн бий болох ийм боломжтой байгаа юм. Тэгэхээр энэ асуудлуудаа ярилцаад, дээрээс нь үнийн бодлогоо бид яаж либералчлах юм, үнэ чөлөөлөлт бол сая явагдаагүй. Энэ бол өртөгт нийцүүлнэ гээд үнэ тарифыг нэмсэн асуудал явж байгаа юм.

Тэгэхээр бодлого маань өөрөө ерөөсөө нэгдэж өгч чадахгүй байгаа юм. Улсын Их Хурал дээр Энхцэцэг гишүүнээр ахлуулсан хууль, эрх зүйн орчныг шинэчлэн найруулах ажлын хэсэг гээд тусдаа гарсан. Эрчим хүчний яам дээр нэг төсөл яваад байгаа гэж би сонссон. Эрчим хүчний реформын үндэсний хороон дээр болохоор гаднын хөрөнгө оруулалт, томоохон төслүүдтэй холбоотой ажлууд

нь явж байгаа юм байна гэж ойлгож байгаа юм. Тэгэхээр Ерөнхий сайдаас асуумаар байна. Энэ хаанаа ер нь эрчим хүчний реформын бодлого нь зангидаад явж байгаа юм бэ? Мэдээллүүд нь хаанаа нэгтгэгдэх ёстой юм бэ? Дээрээс нь шийдвэр гаргалтууд нь яг хаанаа гарах юм бэ? Та энийг тодорхой болгож өгөхгүй бол энэ реформын үндсэн асуудлууд чинь шийдэгдэхгүй ингээд удаан байдалтай байгаад байна.

Дараа нь 2 дахь асуулт Эрчим хүчний сайдаас асууя. Эрчим хүчний салбарын ажилчид надтай нэлээн их холбогдож ярьж байгаа. Үнэ тариф өөрчлөгдсөний дараагаар цалингийн тухай асуудлыг эрчим хүчний салбарынхан маш ихээр хэлж байгаа. Бидний цалинд ямар нэгэн өөрчлөлт ороогүй гээд. Би гишүүний хувиар Эрчим хүчний зохицуулах хорооноос асуусан. Эрчим хүчний зохицуулах хорооноос хэлэхдээ сүүлийн 2 жил 10 орчим хувиар нэмэгдүүлээд яваад байсан. Гэхдээ тухайн үед бол уг мөнгө нь байгаагүй учраас өр төлбөр хэлбэрээр явуулж байсан. Сая 2024 онд энэ өр төлбөрийг барагдуулсан юм гэсэн. Тэгэхээр энэ салбарын ажилчид асуугаад байгаа учраас энийг тодруулж хэлмээр байгаа юм. Дээрээс нь инженер, техникийн ажилчдын цалин, захиргааны ажилчдын цалин ямар ялгаатай байгаа вэ? Энэ салбарын дундаж цалин хэдэн төгрөг байгаа вэ гэдгийг асууя.

Д.Амарбаясгалан: Эхлээд Чойжилсүрэн сайд хариулт өгөөдөхье.

С.Цэнгүүн: Ерөнхий сайдаас асуусан.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Эрчим хүчний реформ хийж байгаа хүмүүс маань хоорондоо асуулт тавиад тэгээд би хариулах болж байх шиг байна. Би нэг зүйл дээр яг энэ реформыг дэмжиж байгаа парламентын гишүүд, ЗГ-ын гишүүд үнэн бодитой ийм нөхцөл байдлаас та бүхэн маань битгий ухраасай гэж зүгээр би уриалж байна. Мэдээж одоогийн цаг хугацаанд өвдөлт өгнө, өвдөлт өгчхөж байна. Гэхдээ үйлдвэрлэлийн өртгөөсөө нийлүүлж байгаа өртөг нь хэд дахин хямд. Тэгээд бид яаж орон сууцжуулах юм бэ, яаж үйлдвэрлэл баригдах юм бэ? Яг энэ үнэнээс бид 34 жил зугтаасан, одоо тэгээд хаачих юм бэ? Харин ч энэ асуудлыг гаргаж тавьж, бодитой тоонуудаа гаргаад энэ зүйл рүү ингээд явахыг хүсээд мөс зүсэж байгаа ЗГ-ын сайд, мөн парламентын гишүүд та бүхэндээ Ерөнхий сайдын хувьд талархаж байгаа шүү. Худлаа улс төр хийх амархан. Үгүй ээ тэгээд хаачих юм шийдэл байхгүй энэ чинь. Хэдэн жилийн дараа энэнээсээ илүү хүнд өвдөлттэй л тулгарна. Тийм учраас бид суурь асуудлуудаа тэгээд зориг гаргаад шийдэх л ёстой.

Баруун талаар нь ч яваад, зүүн талаар нь ч яваад тулгарах зүйлийг бид одоо байгаа 1, 2 хүний улс төр хийсэн арчаагүй байдлаас болж ухарч болохгүй. Тийм учраас эрчим хүчний үнийг чөлөөлөх зөв байсан. Энийг хамтарснаараа хийж чадсан. Энийг бүсчилсэн томсгосон тойргоос пропорциональ тогтолцоогоор орж ирсэн гишүүд л ярьж чадаж байгаа. Мэдээж дулаан дээр ч гэсэн энэ асуудлыг шийдэх ёстой. Гэхдээ харамсалтай нь инфляцад тулчхаж байгаа учраас энийг хойшлуулахаас өөр сонголтгүй л болчихсон. Харин энэ асуудал яг үйлдвэрлэлийн өртөг тоон утгаараа ямар байгаа юм энэ бүх зүйлүүдээ та бүхэн маань илүү л сайн таниулах ёстой. Олон нийтийн хувьд би үүнийг эсэргүүцээд байгаа гэж бодохгүй

байна. Нөхцөл байдлыг ойлгож байгаа. Харин тайлбар дутаж байгаа байх. Улс төржилт нь бодитой тайлбараасаа дутаж байж магадгүй. Энэ цаг үед таалагдах гэсэн арчаагүй улс төрчид нь бодитой байдлыг ярьж байгаагаас илүү байж магадгүй. Гэхдээ ирээдүйд Монгол улс орон сууцжиж, аж үйлдвэржиж бид энэ шийдвэрийг гаргаснаараа дараа дараагийн хүмүүс энийг зөв гэдгийг ойлгох цаг ирнэ. Үүнээс битгий эргэлзээрэй, битгий ухраарай.

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Цэнгүүн гишүүний асуултад хариулъя. Цэнгүүн гишүүндээ талархаж байгаа. Эрчим хүчний энэ үнэ тариф өртөгт нь ойртуулах ажилд санаачилга гаргаад, дэмжээд явж байгаа танд эрчим хүчний салбарынханд их тааламжтай танд талархаж байгаа гэдгийг хэлье нэг. Бодлого дээр нэгдэж чадахгүй юм байхгүй байгаа. Бидний бодлого бодит байдал дээрээ биелүүлж чаддаг бодлогоо л гаргая гэдэг байр суурийг яамнаас гаргаад байгаа юм. Энэ талаар ч гэсэн юу анх байгуулагдаж байсан нь үеийгээ бодоход манай эрчим хүчний реформын хороо, гишүүд, яамны байр суурь ер нь нэг зүйл рүү их ойртож ирж байгаа сүүлийн үед. Энэ дээр би их бэлгэшээж байгаа.

Манайх чинь жижиг орон. Манай суурь эрсдэл маань өндөр байдаг, рейтинг багатай, дөнгөж В зэрэглэл банкны зээлжих зэрэглэлээр. Ийм л бизнесийн орчин байгаа учраас манайх руу шууд мөнгөө барьж орж ирээд ашиг орлого олно гээд ингэдэг энэ асуудал хүнд байна. Санхүүгийн зардал өндөр байна. Ийм асуудлууд руу бид нэг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайдад нэмэлт 1 минут өгье.

Б.Чойжилсүрэн: Шууд өргөс авсан юм шиг өнөөдөр яриад маргааш нь шийдэж чадахгүй. Энд тодорхой хэмжээний 2, 3 сар, магадгүй жил, 2 жил, 3 жил шаардагдана. Энэ дээр тэвчээртэй энэ эхэлсэн ажлаа дуусгая гэдэг зүйлийг танд уриалж байгаа юм. Ер нь тариф нэмэгдсэнээр ажилчдын цалинг энэ 4 сарын 1-нээс энэ төрийн өмчит компаниудын тухай ярьж байна шүү, Эрчим хүчний сайдаар зорилтот түвшнээ батлуулдаг 27 ТӨК-ийн цалинг 4 сарын 1-нээс 10 хувиар нэмэгдүүлэх ийм шийдвэрийг гаргаж байгаа. Салбарын инженер, техникийн ажилчдын цалин өнөөдрийн байдлаар 3,6 сая төгрөг байна. Үүнээсээ хүн амын орлогын албан татвар, НДШ-ийг төлөхөөр гар дээр нь хэд очих нь ойлгомжтой ийм л бодит байдалтай байгаа юм. Энэ салбар маань яг эрчим хүчний салбарт байгаа энэ залуучууд маань бусад уул уурхай болон бусад салбарууд, гадаадынхантай нь яах юм бол хүссэн хэмжээндээ нэмэгдүүлж чадахгүй байгаа нь үнэн. Гэхдээ энийг бодит байдлаар салбар салбарын компаниуд бүгдэд нь бид таниулж ойлгуулж байгаа, ондоо арга байхгүй.

Д.Амарбаясгалан: Саруулсайханы Цэнгүүн гишүүн тодруулж асууя.

С.Цэнгүүн: Одоо бид ерөнхий асуудал ярих шаардлагагүй. Энэ танхим дотор сууж байгаа хүн болгон эрчим хүч ямар чухал вэ, эрчим хүчний либералчлал хийгдэх ёстой гэдэгтэй санал нэгдэж байгаа. Тийм учраас 103 гишүүн гарын үсэг зурсан байгаа юм. Тэгэхээр бид одоо деталь ажил руугаа орох ёстой. Тэгэхээр зах зээлийн загварчлал, үнийн бодлого, хууль, эрх зүйн орчноо яаж тодорхойлж гаргаж ирэх юм гэдэг маань өөрөө бид нарын ирээдүйг тодорхойлж гаргана.

Тэгэхээр энэ шийдвэрүүдээ бид хийж чадахгүй байгаа шүү дээ. Бид бодит үнэнээ хэлэх ёстой. Энэ шийдвэр дээрээ хаанаа мөсөө хагалж явах юм бэ гэдгийг л би асуугаад байна. ЗГ энэ дээр яаж ажиллаж байгаа юм бэ?

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд нэмж хариулъя.

Б.Чойжилсүрэн: Цэнгүүн гишүүн салбарын мэргэжилтэн талын хүн биш учраас бухимдаж байгааг үгүйсгэхгүй. Бид ямар ч байсан энэ 2025 оны 2, 3 дугаар улиралдаа багтаагаад Эрчим хүчний тухай хуулийг бүхлээр нь шинэчилсэн найруулах юм уу эсвэл нэмэлт, өөрчлөлтөөр явах юм уу гэдгээ Энхцэцэг гишүүн тэргүүтэй бусад гишүүдтэй бид тодорхой болгоно. Энэнээс өмнө гал алдчихалгүйгээр эхний асуудал нь энэ нэг санхүүгийн тогтвортой байдлыг үүсгээд дампуурчихгүй байх асуудал тулгамдчихаад байгаа учраас энэ тал дээр илүү түлхүү анхаарснаа хэлье. Танд тайлбарлаж ойлгуулж чадаагүй байсан бол уучлалт гуйж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Доржханд сайд нэмж хариулъя.

Т.Доржханд: Баярлалаа. Цэнгүүн гишүүний тавьж байгаа шаардлага бодитой, бодитой. Тэгээд нөгөө иргэд болохоор үнэ нэмчихсэн гэдэг ойлголттой. Тэгээд юу хийгээд байгаа юм бэ гэдэг талаар нөгөө мэдээлэл нь очихгүй байна гэдэг дээр хүлээн зөвшөөрч байгаа. Гэхдээ маш том өөрчлөлт гарчихсан байгаа. Юу вэ гэхээр том хэмжээний хөрөнгө оруулалтууд наашаагаар орж ирэхээр, экспортыг чиглэсэн бүтээн байгуулалтууд явахаар ингээд судалгааны ажил руугаа орчихсон байгаа нэг.

2 дугаарт хууль, эрх зүйн чиглэлээр манайх Эрчим хүчний үндэсний хороон дээр ажлын хэсэг гараад, Энхцэцэг гишүүнээр ахлуулаад ингээд явж байгаа. Энэ бол ингээд тусдаа ажил биш. Энэ ингээд ЗГ-аас өргөн баригдана. Энэнийхээ хүрээнд удахгүй ингээд хаврын чуулганаар энэ орж ирнэ. Яг үүгээрээ зах зээлийнхээ загварчлалыг хийгээд явах нь зүйтэй. Одоо бид бүтцийн өөрчлөлтийнхөө төлөвлөгөөг өчигдөр батлаад явсан. Ямар байдлаар бид хувийн сектор луу шилжүүлэх юм бэ, үр ашгийг нь сайжруулах юм бэ гээд. Яг энэ чиглэлээр манай нөгөө.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут өгье.

Н.Учрал: Төрийн өмчийн компанийн үр ашгийг сайжруулах хууль манай Учрал сайд ингээд оруулж ирээд, бид энэнийхээ хүрээнд энэ арга хэмжээгээ аваад явна. Тэгээд нэг жоохон буруу ойлголт яваад байх шиг байна лээ. Энэ нөгөө Эрчист Монгол гэдэг компани ингээд байгуулчихлаа. Тэр маань яах билээ гээд. Энэ чинь бол уул уурхайн компаниас бусад бүх сүлжээ компаниудыг нэгтгээд, балансыг нь нэгтгээд, цэвэрлээд, хөрөнгө оруулалт татах тэр боломжийг нь бий болгож байгаа ийм бүтэц байхгүй юу. Тэгээд энэнийхээ хүрээнд бид энэ бүтцийн өөрчлөлтийг үе шаттайгаар хийгээд явна. Гол нь энийг зах зээлийн систем рүү нь яаж оруулж ирэх вэ, IPO-оо урт хугацаандаа яаж хийх вэ, үр ашиг нь яаж сайжруулах вэ, мөнгөө яаж татах вэ, тэгээд цаашаа өөрсдийнхөө хөрөнгөөр хөрөнгө оруулалтаа хийдэг, технологийнхоо асуудлыг шийдэж чаддаг ийм бүтцийг оруулж ирэх нь хамгийн чухал байгаа байхгүй юу. Тэгээд энэ ажлууд маань бүгдээрээ ингээд үе шаттай хийгдээд явж байгаа. Тэгээд мэдээллүүдээ бид өгөөд

явна. Эрчим хүчний реформын үр дүн бол сайн гарч байгаа, ажил сайн явж байгаа шүү. Энэ бол бид хэлээд байгаа 2, 3 жилийн дотор бид.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хөдөө аж ахуйн яамнаас хэн байна вэ? Отгонбаяр гишүүний импортын адуутай холбоотой асуудлаар хариулт өгөх хүн алга байна тийм ээ? Ганхүлэг гишүүн асуусан. Тэр нөгөө түрүүн Шинэ хоршоо гээд асуусан, би хариултыг нь өгүүлэлгүй өнгөрөөд явчихсан байна. Жавхлан сайд гүйцээгээд хариулт өгөөдөхье.

Б.Жавхлан: Уг нь яамнаас нь хүмүүс хариулбал зүгээр юм. Би өмнөөс нь буруу зөрүү юм яриад нөгөө яамыг нь хэрэгт оруулчих вий дээ. Ер нь бид төсвөө мэдэж байна. Тэгээд гишүүний асуусан асуулт маань тэр яг зээлдэгч нар дээр очих зээлийн төрөл, эдийн засгийн ангилал дээрээ хасагдчихсан юм байна. Тэгээд тэр нь яг яамны бодлогоор хасагдсан уу эсвэл өөр ямар, ямар ч байсан төсөв талаас тэрэнд оролцоогүй. Бид аль болох зээлийг хүртээмжтэй байлгах, нэг зээлдэгчид очих хязгаарыг нь хэтрүүлэхгүй байх, гүйцэтгэл дээр нь яг ингээд санхүүжилтээр нь хянаад ингээд явж байгаа. Яг төрөл дээр нь би ёстой хариулж мэдэхгүй байна. Яамнаас нь хүн байж хариулахгүй бол.

Д.Амарбаясгалан: Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууя.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Иргэдийн төлсөн татварын төгрөг бүр үр дүнтэй зарцуулагдах ёстой. Гэтэл ЗГ-ын 5 жилийн чиглэлийн хүрээнд өнгөрсөн 4 жилийн хугацаанд 21,7 их наяд төгрөгийг энд зарцуулсан боловч нийгэм, эдийн засагт үзүүлсэн нөлөө тодорхойлогдохгүй байна. Аудитын тайлан дээр байна л даа. Үүний шалтгаан нь үр дүнгээ хэмжих KPI буюу шалгуур үзүүлэлт нь буруу, хэмжих боломжгүй, оновчгүй, зорилго, зорилттойгоо нийцэхгүй байгаад байгаа юм. Намрын чуулганаар энийг маш олон удаа хэлсэн.

Гэтэл тайлангууд яг бахь байдгаараа л ороод ирж байна. Зөвхөн арга хэмжээний хэрэгжилтийгээ гаргачхаад, бодлогын хэрэгжилт нь 60, 70 хувьтай, зарим нь бүүр 100 хувийн биелэлттэй гэж буруу тайлагнаад байна л даа. Хэмжиж чадахгүй бол удирдаж чадахгүй. Алсын хараа 20 50, тэрний 3 дугаар хавсралт 73 KPI-тай. 5 жилийн чиглэл 95, 4 жилийн хөтөлбөр 152, жилийн төлөвлөгөө 205, төсвийн 1 дүгээр хавсралт энэнээс ч олон шалгуур үзүүлэлттэй. Энэ шалгуур үзүүлэлтүүд хоорондоо нийцэхгүй, алдаатай байгаад байна. Энэ бол маш том ноцтой тогтолцооны асуудал. Энгийнээр хэлбэл бид шугам барьчхаад жингээ хэмжих гээд яваад байгаа байхгүй юу.

Эдийн засаг, хөгжлийн яамнаас асууя. Ирэх сард 2026 оны хөгжлийн төлөвлөгөөгөө өргөн барина байх. Үүн дээр KPI буюу шалгуур үзүүлэлтээ оновчлох, зөв үнэлгээ хийдэг болох тогтолцооны өөрчлөлт, төлөвлөгөөний алдааг арилгах, сайжруулах, жилийн төлөвлөгөө болон улсын төсөв хоорондын нийцлийг хангах ямар ажил хийж байгаа вэ? Ямар ахицтай байгаа вэ? Хэзээ дуусах вэ?

Байнгын хорооны хурал дээр Эрчим хүчний асуугаад хариулт авч чадаагүй. Дахиад асууя. 2024 оны жилийн төлөвлөгөөний хавсралт 2. 2.3.1.эрчим хүчний салбарыг эдийн засгийн үр ашигтай болгоно гэсэн зорилттой. Мөн төлөвлөгөөний хавсралт 5. 2.3.1.эрчим хүчний компаниудын санхүүгийн алдагдал гэсэн шалгуур үзүүлэлттэй. Энэ тоо 5,7 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан нь 76 тэрбум

төгрөгийн алдагдалтай болж өссөн байхад яаж зорилтоо 100 хувь биелээд байгаа гэж үнэлээд байгаа юм бэ?

Үр дүнд хүрсэн зорилтууд байна л даа. Жишээ нь жилийн төлөвлөгөөний хавсралт 1.1.экспортыг нэмэгдүүлэх зорилт 15 хувиар даван биелсэн. Үндэсний цахимжилтын индекс 0,8 оноогоор 193 улсаас 46 дугаар байранд байгаа. Эд нар бол бүгдээрээ сайн үр дүн, зөв хэмжиж чадаж байна. Үүнийг хариуцаж ажилласан яам, тамгын газар, төрийн албан хаагчдадаа баярлалаа гэж хэлмээр байна. Цаашдаа улам сайн үр дүнд хүрэхийг хүсэж байна.

Эцэст нь давтаад хэлье. Хэмжиж чадахгүй бол удирдаж чадахгүй. ЗГ төлөвлөгөөгөө зөв боловсруулаад, зөв шалгуур үзүүлэлттэй болгох ажлыг нэн яаралтай хийх хэрэгтэй байна. Ингэж байж бид иргэдийн төлсөн татварын төгрөг бүрийг үр дүнтэй зүйлд зарцуулах боломж бүрдээд, түүнийгээ хэмжиж чаддаг болно. Үүн дээр ажлын хэсэг байгуулаад, манлайлж ажиллахаар төлөвлөж байгаа. Гишүүдийгээ хамтарч ажиллана гэж найдаж байна.

Д.Амарбаясгалан: Эдийн засгийн хөгжлийн яамны ТНБД Идэшийн Батхүү, 5 дугаар микрофон, ажлын хэсэг.

И.Батхүү: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хариуцан боловсруулж байгаа. Яг одоо бол 2026 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулаад, хуулийн хугацаанд буюу энэ оны 5 сарын 1-нээс өмнө ЗГ-аас Улсын Их Хуралд өргөн барихаар ажиллаж байгаа. Таны өнгөрсөн намрын чуулганы үеэр хэлсэн зөвлөмж, санал, дүгнэлттэй бид санал нэгтэй байгаа, энд анхаарч ажиллаж байгаа. Өнгөрсөн хугацаанд яг энэ арга хэмжээнүүдэд улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгах төсөл, арга хэмжээнүүдийг эргэж тайлагнах үүрэгтэй яамнууд, агентлагууд, холбогдох байгууллагуудтай нэг бүрчлэн уулзаж, энэ талаар анхаарч, зөвлөж ажиллаж байгаа. Мөн эрдэмтэд, судлаачдын тусламжийг аваад энийг сайжруулах талаар ажиллаж байгаа. Дээр нь нэмээд Үндэсний статистикийн хороо гээд байгууллагатайгаа мэргэжлийн байгууллагатайгаа яг энийг сайжруулах цаг хугацааны хувьд, цаглаврын хувьд аль шалгуур үзүүлэлтүүд нь хугацаандаа гарч, дүгнэгдэх боломжтой юм бэ гэдэг тал дээр зөвшилцөж ажиллаж байгаа. Олон улсын ашиглаж болох, шууд ашиглаж болох индикаторуудыг оруулж ашиглая гэсэн талаас ажиллаж байгаа.

Тэгээд улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жилийн төсөв 2-ын уялдааг сайжруулах тал дээр өнгөрсөн хугацаанд бид Сангийн яамтайгаа нэлээн их хамтарч ажилласан. Тухайлбал 2023 оны байдлаар нийцэл нь 47 хувьтай байсан бол 2024 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жилийн төсвийн нийцэл 71 хувьтай болсон. Одоо боловсруулаад ирэх энэ онд хэрэгжиж эхэлж байгаа 25 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө 92 хувийн нийцэлтэй байгаа гэж үзэж байгаа. 26 оны хувьд ч гэсэн бид Сангийн яам, холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллаад энэ үзүүлэлтийг сайжруулахаар ажиллана.

Мөн энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулахтай холбоотой олон нийтийн оролцоог хангах асуудлаар зарим гишүүд түрүүн асуулт асууж байсан. Манай Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс энэ улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулахтай холбоотой санал авах албан бичгийг бүх төсвийн

ерөнхийлөн захирагч, яам, агентлагууд, орон нутгийн захиргааны байгууллагууд руу хүргүүлэхдээ тухайн саналыг боловсруулахад зөвхөн улсын болон орон нутгийн төсөв биш, хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын саналыг оруулаад, хууль тогтоомжид заасанд нийцүүлж ирүүлэх тухай удирдамждаа хүргүүлж байгаа. Үүнтэй олон удаагийн яг ганцаарчилсан уулзалтуудыг яамд, агентлагуудтай хийхдээ ч гэсэн энэ талаар анхааруулж ажиллаж байгаа. Яг одоо процесс үргэлжилж байгаа учраас таны өгсөн санал, зөвлөмжүүд, бас бусад гишүүдийн өгсөн анхааруулсан зүйлсийг 2026 оны улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахдаа гүйцэтгэж ажиллана.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмж хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Зөв асуудлыг хөндөж байна. Гэхдээ гишүүний хувьд нэг зүйл дээр илүү тийм нөгөө өнгөрсөн 2, 3 жилийг харчхаарай гэж бодож байна. 2019 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэдэг ийм Үндсэн хуулийн заалт орсон. Бямбацогт сайд энд сууж байна. Тэрнээс өмнө ингэж ерөөсөө ярьдаггүй байсан. 5 жилээр, ингээд урт хугацаагаар гэж ингэж сонгуулийн цикл алгасаж ярьдаг ийм соёл манайд тогтоогүй. Хуучин байсан нөгөө нэг төлөвлөгөөний комиссоо болохгүй байна гээд татан буулгаад, ингээд ерөөсөө л 4, 4 жилийн ийм сонгуулийн үйл ажиллагааны хөтөлбөрөөр л манай улс дүгнэгдэж ингэж явдаг байсан. Үүний дараа Үндэсний хөгжлийн газрыг Эдийн засгийн хөгжлийн яам болгох нь зүйтэй юм. Яамнуудын дээр бодлого төлөвлөлтийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт минут өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Бодлого, төлөвлөлтийн Үндэсний хөгжлийн газрыг Эдийн засгийн хөгжлийн яам болоод ингээд Тэргүүн шадар сайд ахлахаар болоод ийм үйл ажиллагааны хөтөлбөр ингээд 2, 3 дахь жилдээ л дүгнэгдэж байгаа. Энэ жилийн хувьд 5 жилийн төлөвлөгөөг бид анх удаа хэлэлцэж байгаа. Тийм учраас би түрүүн хэлдэг нь Улсын Их Хурал нэг өөр янзаар үнэлж байгаа. ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэгч агентлаг болон Одбаяр сайдын газар бас нэг өөр аргачлалаар, аудит үүнийг өөрийнхөө аргачлалаар, статистик өөр аргачлалаар гээд ингээд ийм үнэлгээнүүд зөрөөд байгаа юм нөгөө аргачлалынхаа хувьд. Дээрээс нь анх удаа манайх цаасан дээр смарт буюу нөгөө олон улсын байгууллагуудад ашигладаг индикаторын шалгуур үзүүлэлтийг гаргасан анхны баримт бичиг өөрөө энэ 20 50. Тийм учраас бид энэ жилийн хувьд их чухал нь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд нэмж хариулт өгнө.

Б.Чойжилсүрэн: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Тэр 2024 оны хөгжүүлэх жилийн төлөвлөгөө дээр эдийн засгийн үр ашигтай болгоно гэдэг маань ямар ч байсан энэ салбар эхний ээлжид алдагдалгүй болоод авах ёстой. Борлуулж байгаа үнэ маань өөрийнхөө өртөгт хүргэх ийм алхмыг хэрэгжүүлж эхлэх гэж оролдсон юм. Үндсэндээ бол үнэндээ энэ зорилтыг хэрэгжүүлж амжсангүй, үнэнээ хэлэх хэрэгтэй байх. 2024 оны дундуур ЗГ байгуулагдсан. Хамтарсан ЗГ байгуулагдсан гол шалтгаануудын нэг нь энэ эрчим хүчний реформыг эрчимжүүлэх гэдэг ийм гол нөхцөлүүдийн нэг байсан гэдгийг та бид санаж байгаа. Энэний дагуу бид 2024 оны 12 сарын 15-ны өдрөөс цахилгаан эрчим хүчний үнийг өртөгт нь ойртуулах эхний алхмыг хэрэгжүүлж эхэлсэн. Иймэрхүү л

байдалтай байгаа юм. Харамсалтай нь манай эдийн засаг тогоо томроогүй байгаагаас шалтгаалаад одоо дулааны үнийг бид 5 сарын 16-наас нэмэгдүүлэх ёстой байсан боловч нэмэгдүүлж чадахгүй байгаа. 10 төгрөгөөр үйлдвэрлэлчээд 4 төгрөг 20 мөнгөөр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут.

Б.Чойжилсүрэн: 10 төгрөгөөр үйлдвэрлэлчээд 4 төгрөг 20 мөнгөөр зараад байхаар энэ алдагдал чинь олон жил хуримтлагдаад хүндрэл болоод энэ салбар маань хөгжих тухай биш, яаж амь тэсэж үлдэх вэ гэдэг ийм зорилттой сүүлийн жилүүдэд яваад байгаа юм. Олон жил хуримтлагдсан хур хүндрэл. Энийг 1, 2 жилийн дотор шууд шийдэхэд хүнд байж магадгүй. Манай зарим залуу гишүүд яараад байх шиг байна. Энэ олон хашилтууд байгаа. Эдийн засгийн бидний хүсэлт, боломж 2 хоорондоо уялдах ёстой учраас энэ ажлыг энэ мөрийн хөтөлбөрийг 24 онд биелүүлж чадаагүй хэдий боловч магадгүй энэ ЗГ-ын бүрэн эрхийн хугацааны төгсгөл гэхэд биелүүлэхийн төлөө Эрчим хүчний яам, Засгийн газар бүх хүчээ шавхаж ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Лувсанжамц гишүүн тодруулж асууя.

Г.Лувсанжамц: Дэлгэрэнгүй хариулсанд баярлалаа. Ажлууд идэвхтэй хийгдэж байгаа юм байна. Эдийн засаг, хөгжлийн яамнаас та бүхний боловсруулж байгаа шинэ шалгуур үзүүлэлтийг би draft хэлбэрээр, төсөл хэлбэрээр нь авмаар байна гэсэн санал байна.

Ерөнхий сайдад баярлалаа. Яах аргагүй манайх ийм дунд, урт хугацааныхаа бодлоготой. Гол нь энэ шалгуур үзүүлэлт буюу үр дүнд суурилсан нэгдсэн төлөвлөлт, төсөвлөлт, хяналт, үнэлгээ гэсэн энэ тогтолцоо руу шилжих ёстой байгаад байгаа. Жишээ болгож нэг улсыг дурдъя. Солонгос жишээ нь 200 KPI-г үндэстнээрээ зорилго болгоод тавьчихсан байгаа. Тэр зорилгодоо нийцсэн, тэр шалгуур үзүүлэлтдээ нийцсэн төсөл, арга хэмжээг л хэрэгжүүлдэг. Тэгэхээр төсвийн зарцуулалт нь үр дүнтэй яваад нийгэм, эдийн засаг сайжраад, иргэдийн орлого дээшилдэг. Тэгэхээр энэ тогтолцоонд шилжих ажлыг яаралтай энэ жилдээ багтаад хийчих юм бол энэ Их Хурал, энэ Засгийн газрын том өв болж үлдэх юм болов уу гэж бодож байгаа юм. Тийм саналтай байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмэлт хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Энэ шалгуур үзүүлэлтээр үнэлж эхлээд бид анх удаа энэ 5 жилийн тайлан яригдаж байгаа учраас бид 5 сарын 13-нд батлагдаж байсан 2020 оны. Тэгэхээр одоо бид урт хугацааны ийм хөгжлийн бодлого 2019 оны хууль Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль хэрэгжиж эхлээд үнэлэх ер нь хугацаа нь одоо. Тийм учраас бид энэ 5 сарын асуудал дээрээ юу хийх вэ гэдгээсээ илүү энэ хийж байгаа зүйлүүдээ яаж бид үр дүнтэй байж хэмжих вэ, үйл ажиллагааны аудит гэж яг юу байх юм, яаж төлөвлөх юм, түүнийгээ ямар дата өгөгдөл дээр тулгуурлахыг аль индикатор дээр үнэлэх юм бэ гэдгээ бид нэлээн сайн ярьчихвал ийм хэлэлцүүлэг харьцангуй бага, тэгээд үйл ажиллагаанууд илүү их үр дүнтэй болно. Тийм учраас парламентад маань олон эрдэмтэн, судлаачид, салбар салбарын төлөөлөл ороод ирчихсэн байгаа. Тэгээд 5 сарын 10-аар энэ дүгнэлтээ хийгээд, яаж дүгнэх вэ гэдэг аргачлал дээрээ тодотгож авах нь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууж, үг хэлье.

О.Батнайрамдал: Баярлалаа. Монгол Улсын 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн тайлангаа бид хэлэлцэж байна. Тэгэхээр Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдсанаас хойш нэг ёсондоо 5 жилээр бид сонгуулийн циклээ сөрж, үндсэн чиглэлээ 5 жилээр анх удаагаа гүйцэтгэлийн тайлангаа хэлэлцэж байгаа жишиг л дээ. Урьд нь үндсэн чиглэл бол нэг л жил байсан. Тэгэхээр энэ урт хугацааны бодлогын ерөөсөө гол үндэс нь бид чинээлэг дундаж давхаргаа яаж хүн амынхаа дийлэнх 80 хувиас дээш байлгах вэ, энэ дээр яг 2 асуулт байгаа юм.

Эхнийх нь нэгэнтээ хэт байгалийн баялгаас хамааралтай оронд энэ баялгийн зөв, шударга хуваарилалтыг бид хэрхэн хийх вэ? Энэ бол Үндсэн хуульд туссан концепц л доо. Үндсэн хуульдаа бид Үндэсний баялгийн сангаар дамжуулж шударга, тэгш, шударга хуваарилалтыг хийнэ гээд энэ Үндсэн хуулийн үг шүү. Тэр дундаа энэ Үндэсний баялгийн сангийн хуулиа ч баталчихлаа. Олон жил ярьж, олон жил маргаж баталсан. Энэ хуулийн хэрэгжилт яг одоо хаана яваа юм бэ? Үндэсний баялгийн сангийн хууль тэр дундаа Хуримтлалын санд бид стратегийн ордын ноогдол ашгийн 34 хувийг хуримтлуулж, хүний хөгжил рүүгээ хөрөнгө оруулалт хийсэн. Тэгэхээр энэ стратегийн ордуудтай хийж байгаа хэлцэлд ажлын хэсэг гарсан гэж дуулсан. Энэ яг хаана яваа юм бэ? Энэ хэлцлээ бид хийж чадах уу, үгүй юү? Энэ үндэсний баялгийн сангийн тухай хуулиа бид амилуулж чадах уу, үгүй юү? Энэ өөрөө Үндсэн хуулиар олгогдсон бидний эрх.

2 дугаарт буцаад хүний хөгжилтэй холбоотой ер нь бид нарын тулгамдаж байгаа асуудлуудын 90 хувийн шийдэл нь дандаа боловсролтой холбоотой. Ерөөсөө боловсрол. Боловсрол руу хийх хөрөнгө оруулалт буцаад 10 дахин арвиждаг. Тэр дундаа татвар төлөгчдийн мөнгөөр боловсрол руу хөрөнгө оруулалт хийж байгаа сан өөрөө Боловсролын зээлийн сан. 2025 оны төсөв дээр 158,4 тэрбум буюу түүхэндээ хамгийн том дүнтэй батлагдсан. Гэхдээ эндээс маш олон оюутан, суралцагчдаас, тэдний аав, ээжээс байгаа маш том хүлээлт байгаа юм. Энэ 158,4 тэрбум төгрөг хэрхэн зөв, шударга, ашиг сонирхлоос ангид эзэндээ очих вэ? Яг энэ долоо хоногт хоёрхон хоногийн өмнө Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос бид Боловсролын зээлийн сангийн шинэчлэлтэй холбоотой Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгсөн тогтоол батлуулсан.

Өнөөдөр энэ 158,4 тэрбум төгрөгөөр олгогдож байгаа энэ буцалтгүй тусламж, зээл, тэтгэлэг 30 жилийн хугацаанд 28 удаа нэмэлт, өөрчлөлт орсоор байгаад хүн ойлгохын аргагүй болчихсон ганцхан журмаар зохицуулагдаж ирсэн. Өнөөдөр энэ журмаар, энэ нэмэлт, өөрчлөлт орсоор байгаад хүн уншаад ойлгохын аргагүй болчихсон энэ журмаар яваад байхаар асуудал нь нугалаа үүсээд, дуусахгүй байгаа юм л даа. Гадаад, дотоод зээлийн эргэн төлөлтүүд байна. Өнөөдөр хэт ялгавартай байдал гарчихсан байгаа юм л даа. Та нар бод доо, гадаад зээл авсан оюутнуудын зээлийн эргэн төлөлт 98 хувь байгаа юм, 98 хувь шүү. Яагаад гэвэл тэд Монголбанкны зээлийн мэдээллийн санд ордог. Гэтэл гадаад зээл авсан оюутнууд эргэн төлөлт нь ердөө 4-хөн хувь. Асуудал болгож гаргаж ирснээс хойш 4 хувь л болж байгаа юм. Тэгэхээр энэ нь өөрөө цаанаа тэр

оюутан, суралцагчдын эрхийг зөрчсөн асуудал болоод байгаа юм л даа. Энэ хэт ялгавартай байдлыг хэзээ бид зогсоох вэ?

Тэр Монголбанкны жагсаалтад яагаад тэр гадаад, дотоодын оюутныг ялгаваргүйгээр өгч болдоггүй юм бэ? Яриад 2 жил болж байгаа. Энэ тэгвэл хэрхэн ажил хэрэг болох вэ? Тэгэхээр энэ дээр сайдаас ойлгомжтой.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Үндэсний баялгийн сан урт хугацааны хөгжлийн бодлого дээр тусгагдсан. Тэгээд яг дэс дарааллынхаа дагуу явж байгаа зорилго. Тэрнээс гэнэт шинээр гаргаж ирээд, гэнэт шинэ юм бодож олчихоод ингээд байгаад байгаа зүйл биш. Үндэсний баялгийн сан энэ 5 жилийн зорилтын 4.6 дээр байгаа. Үндэсний баялгийн сан байгуулна, энэ асуудлыг 3 үе шаттай хэрэгжүүлнэ гээд. 4.6.1 дээр Үндэсний баялгийн сангийн эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэсэн. Бид хуулиа баталчихсан. 4.6.2 дээр Баялгийн санг засаглалын хувьд олон улсын зохистой зарчмуудыг тодорхойлж, 3 сан болон холбогдох дүрмүүдийг батлуулна гэсэн. Үүнийгээ бид хийчихсэн. 4.6.3 дээр Баялгийн сангийн хуульд заасны дагуу орлогын эх үүсвэрүүдийг санд төвлөрүүлж, нэгдсэн менежментийг зохион байгуулна гэсэн. Энэ хэсэг дээрээ явж байгаа л гэж ойлгож болно.

Одоо бид хэлцэл хийж байгаа. Баялгийн санд бол сангууд бүрдэж байгаа. Эрдэнэт болон бусад Оюу толгой, бусад стратегийн ордуудын 34 хувь бол өнөөдөр иргэдийн Хуримтлалын данс болсон гэсэн үг. Энэ асуудлыг бид арвижуулахын төлөө хэлцлүүд хийгээд явж байгаа. Энэ дээр бид парламентын баталж өгсөн хуулийг л хэрэгжүүлж байгаа. Нөгөө талаараа Баялгийн сангийн эрх зүйн орчинд Ораногийн гэрээ хийгдсэн. Энэ хамаагүй давуу талтай гэрээ болсон өмнөх гэрээнүүдээс. Тийм учраас бид Үндэсний баялгийн сангийн хууль, тэгээд цаашлаад яаж хэрэгжих вэ гэдэг зүйл дээрээ илүү төвлөрөөд явахад Баялгийн сангийн бүрдэлд энэ жил, ирэх жил гэхэд илүү тодорхой болчих ийм боломжтой байгаа гэдгийг хариулъя.

Боловсролын хувьд чухал. Боловсролын хувьд боловсролын салбарыг бид энэ бол зүгээр ингээд нэг салбар гэж харж болохгүй. Наранбаяр сайд сууж байна. Боловсрол өөрөө хөдөлмөрийн зах зээлийг бүрдүүлэх ирээдүйн манай хүний нөөцийн асуудал. Боловсролын салбар Монгол Улсыг авч явах ирээдүйн иргэд юунд итгэж, найдах вэ гэдэг төлөвшил авах тухай асуудал. Боловсролын салбар өөрөө гэр бүлийн асуудал, боловсролын салбар өөрөө эдийн засгийн асуудал, боловсролын салбар өөрөө инновацын асуудал. Тийм учраас боловсролтой холбоотой олон реформуудыг манай Энх-Амгалан сайд өнгөрсөн хугацаанд эрх зүйн хувьд нь бүрдүүлсэн. Боловсролын салбар өөрөө түгжрэлийн асуудал. Тийм учраас бид ирэх жилийг Засгийн газраас Боловсролын багц асуудлыг дэмжих жил болгох нь зүйтэй гэж Засгийн газар дээр яригдаж байгаа юм. Би парламентын гишүүддээ уриалж байна. Бид яагаад ингээд жил болгоод зарлаад байна вэ гэхээр санхүүгээ илүү тодорхой нэг салбар луу үр дүнтэй зарцуулахын тулд тэгээд байгаа юм. Тийм учраас бид.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд нэмж хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Үнэхээрийн Ерөнхий сайдын хэлж байгаачлан, хэлсэнчлэн бид боловсролыг энэ улс орны ирээдүй, энэ боловсролыг тэгш боломжийн ийм талбар гэж харж байгаа. Бидний барьж байгаа бодлого бол Энх-Амгалан сайдын үед хийгдсэн сайн энэ ололтуудыг үргэлжлүүлэх, эрх зүйн орчин шинэчлэгдсэн, энийг амьдралд хэрэгжүүлж явах ийм макро бодлогыг хэрэгжүүлж яваа.

Боловсролын зээлийн сангийн тухайд хэлбэл энэ нийтдээ 3728 хүн өнөөдрийг хүртэл яг энэ гадаадад суралцах зээлийг аваад үүнээс 1040 иргэнийг чөлөөлсөн ийм шийдвэр явж байгаа. Тэгэхээр энэ шийдвэрийн дагуу бид зарим нэгэн буцаж төлөгдөхгүй байгаа асуудлыг судалж байна. Тэгээд нийтдээ өнөөдрийн байдлаар энэ ингээд харахад энэ 1040 иргэний 30,4 сая ийм америк долларын зээл.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут өгье.

П.Наранбаяр: Ингээд зээлийн хүү чөлөөлөгдсөн байгаа. Тэгэхээр зэрэг дотоодод суралцчихсан хүмүүсийн бараг 98 хувь нь буцаагаад төлчихсөн байгаа юм. Дээр нь нэмээд тэдгээр хүмүүсийн мэдээлэл угаасаа Төв банк дээр бүртгэлтэй байж байгаа. Яг энэ зарчмыг бид гадаадад сурсан дээр хэрэгжүүлнэ л гэж байгаа юм. Энийг хэрэгжүүлээд явахад ямар ч асуудалгүй. Энийг ойрын хугацаанд бид хийнэ, бүх мэдээллийг өгнө. Харин нэг зүйлийг хэлэхэд Боловсролын зээлийн сангаар гадаадад суралцаад, төгсөөд ирээд эх орондоо хувь нэмрээ оруулаад ажиллаж, амьдраад ингээд явж байгаа маш сайн ийм ололттой талууд байгаа шүү. Энийг энд би хариуцлагатайгаар мэдэгдье. Энэ Улсын Их Хурлын чуулганы танхимд сууж байгаа хүмүүс дотор ч гэсэн яг энэ зарчмаар яваад, эргэж ирээд эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулж байгаа маш олон хүмүүс бий. Тэгэхээр эдгээр хүмүүсийн энэ гэрээгээрээ хүлээсэн үүргээ биелүүлсэн тохиолдолд хэрхэн чөлөөлөх вэ гэдэг энэ бол хуулийн хүрээнд шийдэгдээд явна. Энд ямар нэгэн улс төржилт байхгүй. Бид харин ийм байдлаар шударга хандана гэдгээ илэрхийлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батнайрамдал гишүүн тодруулж асууя.

О.Батнайрамдал: Наранбаяр сайд яг наадах чинь яригдаад 2 жил болж байгаа юм л даа. Тэгэхээр нөгөө яг шударгаар явсан, арын хаалгаар явсан 2 хүүхэд нэг сагсан дотор байгаад байгаад л асуудал байгаа юм. Энийг цэгцлэх хэрэгтэй байна. Монголбанкны зээлийн мэдээллийн санд гадаад нь, дотоод нь ордоггүй, гадаад нь ордоггүй 2 жил яригдаж байгаа шүү дээ. Тэгээд ингээд яриад байхгүй яг ажил хэрэг болгомоор байна. Энэ дээр маш олон эцэг, эх нарын гомдлууд ирээд байгаа байхгүй юу. Хүүхдүүдийн гомдол.

Тэгээд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтээр ч гэсэн. Ер нь энэ стратегийн ордуудын талаар бид Үндсэн хуулиар олгосон мэдэх эрхтэй шүү дээ. Өнөөдөр энэ сүүлийн бараг 20 жил явагдсан аудитын дүгнэлт авна гэсэн бүгд баахан нууцтай байдаг юм байна. Юуг нь ч нуудаг юм, яагаад нээлттэй болгож болдоггүй юм бэ? Тэгэхээр энэ мэдэх эрхийг бид энэ 3,5 сая иргэнд хангах ёстой. Энэ өөрөө Үндсэн хуулиар олгогдсон зарчим. Тэр нууцад байгаа тайлангуудыг нь авч амжаагүй.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тэр стратегийн ордуудын холбогдолтой мэдээллийг сонсож болно. Туваан сайд, түрүүн Учрал сайд нэмэлт хариулт өгье.

Н.Учрал: Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар энэ Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулаад ажиллаж байгаа. 2007 онд Их Хурлаас гарсан тогтоол дээр 1 дүгээр хавсралтаар нь тэр 16, 15 стратегийн ордыг тодорхойлсон. Жилийн дараа 1-ийг нэмсэн. Энэ тогтоолын 2 дээр 39 стратегийн ордыг жагсааж бичээд, энэ стратегийн ордод хамааруулах нь зөв үү, буруу юу эсэх асуудлыг Их Хурлаар шийд гэснээс хойш даруй 18 жил болж байна. Яагаад энэ цаг хугацаанаас хойш энэ ажлыг хийгээгүй вэ гэдэг дээр анхаарах хэрэгтэй. Засгийн газрын энэ авлигатай тэмцэж байгаа нээлттэй, ил тод байдлыг хангуулах асуудал дээр шилэн ажиллагаа явагдсан. Үүний хүрээнд 815 мянган unit гэж байгаа юм мэдээлэл ил болсон. Үүний тусламжтайгаар өнөөдөр төсөвлөлт ч бай, төлөвлөлт.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Н.Учрал: Төсөвлөлт ч бай, төлөвлөлт ч бай, хяналт ч бай нэг тогтолцоо руу шилжсэний үр дүнд Засгийн газар өнөөдөр шийдвэр гаргалтад их өгөгдлийг ашиглах бололцоо бүрдсэн. Бүх мэдээллийг real time-р харж байна. Хэрвээ нууцад хамааруулчихсан байгаа ийм асуудал байх юм бол зайлшгүй эргэж харах ёстой. Тэгээд энэ утгаараа бид энэ ордуудыг нээлттэй болгох, энэ мэдээллийг олон нийтэд мэдэх эрхийг нь хангуулах чиглэлээр цаашдаа бодитой ажлуудыг хийгээд явна. Боловсролын зээлийн сангийн мэдээлэл ч гэсэн бүгдээрээ ил тод болсон. Тэгэхээр боловсролын салбар ч гэсэн өнөөдөр энэ нээлттэй мэдээлэл дээр дүн шинжилгээ хийгээд, шийдвэр гаргуулах бололцоо бүрэн дүүрэн байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Энэ чиглэлээр Улсын Их Хурал дээр нээлттэй мэдээлэл хийх үүргийг өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж өгөх нь зүйтэй байх гэж бодож байна. Тэгээд мэдээж Засгийн газар бэлтгэл хангаад хэзээ, яаж өргөн барьж мэдээлэл хийх вэ гэдгээ шийдэх ёстой болов уу гэж бодож байна.

Энэ Наранбаяр сайд Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал, Мөнгөнцогийн Ганхүлэг тэргүүтэй гишүүд Боловсролын зээлийн сангийн асуудлыг сүүлийн үед маш их хөндөж ярьж байгаа. Ярьж байгаа үндсэн шалтгаан илүү нарийвчилж, хуулийг нь илүү тодорхой болгож өгөх шаардлага байна гэдэг талаас нь үзээд байна. Аль нь зээл байх юм, аль нь тэтгэлэг байх юм. Тэгээд тэрийгээ эргээд төлсөн, төлөөгүйтэй холбоотой асуудал нь гадаад, дотоод гэж ялгахгүйгээр асуудлыг ижил зарчмаар хандмаар байна гэдэг асуудал байнга хөндөгдөж байгаа. Тэгэхээр ер нь ойрын үед энэ Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгтэй хамтраад энэ хуулиа боловсруулж, илүү нарийвчилж орж ирэх нь зүйтэй. Түрүүн яригдаж байна. Малчны хүүхдийг 1 хүүхдийг үнэ төлбөргүй сургахтай холбоотой асуудал хуулиар заагдсан мөртөө хэрэгждэггүй гэдэг нэг асуудал байна. Сая Улсын Их Хурлын гишүүд чуулганы завсарлагаагаар орон нутагт очиж ажиллахад хууль батлагдчихаад хуулиас давсан журмын хэрэгжилт нь өөрөө хуулийг зөрчөөд байгаа зүйл гарч байна л гэж байгаа юм.

Жишээлбэл орон нутагт ажиллаж байгаа багш 15-аас дээш жил ажилласан тохиолдолд 1 хүүхдийг нь төрөөс үнэ төлбөргүй сургана гэдэг хуулийн заалт байгаа мөртөө яг 15-аас дээш жил ажилласан багш хүүхдээ сургах гэхээр Боловсролын яамнаас тодорхой журам гаргаад чиглэл заачхаж байгаа юм. Тэгэхээр нөгөө багшийн хүүхэд заавал Боловсролын яамнаас заасан тэр чиглэлийг нь сурах ёстой гэдэг ийм шаардлага тавигдаад ирэхээр хууль нэг өөр байгаад байдаг, хуулиас давсан эрх хэрэгжүүлж байгаа журам өөрөө эрх зөрчиж байна гэдэг асуудал давхар хөндөгдөөд байгаа юм. Тэгэхээр энэ бүгдийг нэг цогцоор нь авч, асуудлыг шийдвэрлэх тал дээр санаачилгатай ажиллах нь зүйтэй. Батнайрамдал гишүүнтэй санал нэг байна. 2, 3 жил энэ асуудал олон нийтийг бухимдуулсан сэдэв байсаар л байгаад байна. Тэгээд энийгээ шийдэхгүй. Тэгэхээр энэ дээрээ анхаарах нь зүйтэй гэж үзэж байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя, үг хэлье.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. 3 асуулт, 2 санал байна. 1 дүгээрт энэ танилцуулга дээр энэ түүхий эдийн үйлдвэр боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ батлагдсан гэж байна. Би 3 жилийн өмнө асуухад Монгол Улс 20 арьс жилдээ гаргадаг, 50 хувийг нь боловсруулдаг, 50 хувийг нь хаяж байгаа гэдэг ийм зүйл байсан. Тэгэхээр энэ ТЭЗҮ-ээр энэ Эмээлтийн цогцолбор маань хэзээ орох юм бэ, 20 сая арьс нь яах юм гээд би асуумаар байгаа юм. Нөгөө талдаа малчдын хувьд энэ чинь хуучин ноос ноолуур, арьс шир, мах гээд орлого байсан бол өнөөдөр малаас ердөө гулууз махыг нь ашиглаад л, бусдыг нь хаяж байгаа ийм нөхцөл байдал олон жил болж байна. Тэгэхээр энэнтэй холбогдуулаад энэ малчид маш их ярьдаг, сум болгон дээр очих болгонд, баг болгон дээр ярьж байгаа учраас асууж байгаа юм.

Дараагийнх нь манай энэ зүүн бүстэй холбоотой асуудлууд ер байгаа юм ер нь Монгол Улсын 10 аймагтай холбоотой энэ дулааны станц. Ялангуяа манай Хэнтий, Сүхбаатарт энэ дулааны станцын барилгууд баригдаад зарим нь 30 хэдэн хувьтай, 30-аад хувьтай явж байгаа. Энэ ер нь цаашдаа яах юм бэ гэсэн ийм үндсэндээ 2 асуулт байгаа юм.

Сая Их Хурлын даргын асуултад гарлаа. Хууль нь гарсан малчдын нийгмийн даатгалын тэр асуудлыг ер нь яг яах юм бэ гэдэг дээр малчид маш их хүлээлттэй байгаад байна. Тэгэхээр ер нь нэг тодорхой хариулт юм нь байх нь зүйтэй болов уу гэж ингэж бодож байна. Энэ бол ингээд асуулт.

Асуулт, үг 2 цуг явж байгаа учраас цаг үеийн холбогдолтой 2 асуудал дээр би нэг онцгой анхаараач гээд. Энэ Хөдөө аж ахуйн яамныхан байхгүй байгаа нь жоохон харамсалтай байна. 1 дүгээрт энэ ноолуурын асуудал. Өнөөдөр Монгол Улсад ноолуур ид бужигнаж байдаг, ялангуяа зүүн бүсэд өнөөдөр Монголын бүх ченжүүд оччихсон ноолуур авч байдаг ийм цаг үе шүү дээ. Гэтэл өнөөдөр авч байгаа хүн тэнд байхгүй байгаад байна. Энэ яг юунаас болоод байна вэ, дэлхийн зах зээлийн үнэ ханш нь ингээд байна уу, хөрш орны татварын бодлогууд нь нөлөөлөөд байна уу, мөнгөтэй хүмүүс нь орж ирж авахгүй байна уу энийг бид нэг ингэж нэгдсэн ойлголт өгөхгүй бол буруу ойлголт явчих вий гэсэн ийм болгоомжлол байгаа. Тийм. Тэгэхээр энэ нөгөө нэлээн анхаарлаа хандуулж ингэж ажиллахгүй болохгүй. Тэгэхээр Хөдөө аж ахуйн яамныхан нөхцөл байдлаа их зөв тодорхойлж, энэ дээр анхаарлаа хандуулаасай. Яагаад гэвэл энэ чинь цаг хугацаатай уралддаг. Өнөөдөр чинь 3 сарын 28, 9 гэдэг чинь бараг аваад самнаад,

аваад хураагаад дуусчихсан байх үе. Өнөөдөр ингээд нэг ч килограмм ноолуур авахгүй байна гэдэг чинь юуны дохио вэ гэж маш сайн бодохгүй бол болохгүй болсон байна шүү. Тэр үйлдвэрүүд яагаад авахгүй байгаа юм гэх мэтчилэн. Цагаан алт хөтөлбөрийн тэр мөнгө нь яг түүхий эдийн эргэлтийн мөнгө нь гарч байна уу, гарахгүй байна уу гээд олон асуултууд асуултын тэмдэгтэй байгаад байна. Би энэ Хөдөө аж ахуйн яамныхан байвал илүү тодруулах ийм зүйл байсан юм.

Өчигдөр чуулганы хуралдаан дээр 1072 хувьцаатай холбоотой асуудлыг ярьсан. Үнэхээр одоо энэ чинь ингээд Гашуунсухайтын энэ Эрдэнэс Тавантолгойн том төсөл хөдлөөд, 16 жил тогтвортой ингээд явахаар боллоо. Тэгэхээр энийг тэр 15, 6 оны үед сайн хувьцаа гэдэг нэрээр заримд нь ойлгуулж хэлсэн юм шиг байгаа юм, заримд нь огт хэлэхгүйгээр авсан шүү гэдэг ийм мессежнүүд маш ихээр ирж байгаа. Тэгэхээр энэ Их Хурлын даргын хэлснээр 300-гаад мянган хүн байгаа юм байна. Тэгэхээр бид өнөөдөр энэ асуудлыг ингээд гаргаж ирж нэг чигтээ олохгүй бол энэ ердөө салахгүй ийм асуудал болох юм билээ. Тийм учраас энэ дээр ЗГ нэлээн анхаарлаа хандуулаад, судлаад, үнэхээр зөвшөөрөөд өгсөн юм уу, зөвшөөрөөгүй байхад нь сая төгрөг дансанд нь хийгээд авчихсан гэж намайг Дорнод аймгийн Баяндунд явж байхад ахмад хэлж байсан. Над руу ирж байгаа мессежнүүд ихэнх нь намайг мэдээгүй байхад миний дансанд мөнгө хийгээд л юмыг маань авчихсан шүү дээ гэдэг ийм гомдлууд байгаад байна. Тэгэхээр энэ нэг ноолуурын асуудал, энэ 1072 гэдэг энэ хувьцааны мэдсэн, мэдээгүй байдлаар хувьцааны эрхээ алдсан энэ хүмүүсийн асуудлыг бид одоо л ярьж авахгүй бол Эрдэнэс Тавантолгой ингээд тогтвортой цаашаа явах гэж байгаа энэ эхлэл дээрээ ийм юмаа шийдчихээд явах нь зүйтэй юм.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Эхлээд энэ Хөдөө аж ахуйн яамнаас, Баасандорж дарга, сайд нь өнөөдөр ажилтай гэж чөлөө ярьж байсан. Тэгээд орлох ТНБД, албаны хүмүүс яагаад ирээгүй юм бэ? Эхлээд Ерөнхий сайд нэг хариулт өгчихье. Тэгээд Нямбаатар дарга Эмээлтийн аж үйлдвэрийн цогцолборын талаар.

Л.Оюун-Эрдэнэ: Хөдөө аж ахуйн яамныхан өнөөдөр Дарханд Атрын 4 дүгээр аян нээхээр ийм арга хэмжээтэй байгаа. Дээрээс нь бид төвлөрлийг сааруулъя гээд ХААЯ-ыг Дархан буюу тариалангийн бүс нутагтаа ингээд байх нь зүйтэй гээд явуулчихсан байгаа. Тийм учраас Их хурлын Тамгын газраас хүсэхэд ХААЯ-ны холбогдох албан тушаалтнуудыг цахимаар оруулдаг байх ийм боломжоор хангачихвал бид чинь цахим улс болох зорилт тавиад явж байгаа юм чинь, тэгвэл илүү чухал болов уу. Гишүүдээ би уриалж байна. Тэнд очоод үзвэл, жишээлбэл ХААЯ гарснаараа тэнд их олон давуу тал үүсэж байгаа юм байна лээ. Тэгэхээр ер нь зүгээр цаашдаа бид нэгэнтээ л энэ 700 га-гаасаа эрх мэдлийнхээ энэ төвлөрлийг задалъя гэдэг зорилт тавьж байгаа юм чинь ХААЯ-ны энэ зоримог шийдлийг нь бид дэмжих талаас нь харах нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Их Хурлын даргатай санал нэг байна. Үнэлгээнийхээ асуудлыг бид энэ 5 сардаа багтаад нэг нэгтгээд ер нь дүгнэчихье. Энийг Одбаяр сайд ч гэсэн Их Хуралтайгаа хамт яриад, яг ямар аргачлал, ямар дата дээр тулгуурлаж, аль индикатораар үнэлэх юм бэ гэдгээ нэг тогтчих нь зүйтэй байх. Бид тэр ордуудын асуудал болон Боловсролын зээлийн сантай холбоотой асуудлыг 4 сардаа багтаагаад Их Хурал руу оруулж ирье. Энийг Учрал сайд нэлээн нарийвчлаад авчих нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Идэрбат гишүүний асуусан асуулт хөдөө аж ахуйтай холбоотой хэд хэдэн зүйлүүдийг ярьж байгаа. Энийг Сангийн сайд тэмдэглээд авчхаарай. Тэр нөгөө малчдын нэхийний үнэ биш ээ, түүхий эдийн хэд хэдэн зүйлийн үнэтэй холбоотой. Энэ жилийн ноос ноолуурын үнэтэй холбоотой, арьс боловсруулах үйлдвэр байхгүй байгаатай холбоотой ийм асуудлууд гарч ирж байгаа гэдэг ийм хэд хэдэн гишүүдээс бичиг ирээд байгаа юм. Тэгэхээр энийг нэг нягтлаад ирэх долоо хоногийн ЗГ-ын хуралдаан дээр мэдээллүүдийг нь аваад, тэгээд хэдүүлээ нэг нягталж үзэх нь зүйтэй байх. Тэрийг Сангийн сайд өөрөө энэ нөгөө экспортын ажлын хэсэгтээ оруулаад нэг аваад үзчих нь зүйтэй болов уу гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд нэмэлт хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Энэ 10 аймгийн станц төслийн талаар та асуулаа. Хэнтий аймгийн Дулааны төвийн дулааны станцыг энэ төслөөр хэрэгжүүлж байгаа. 2021 онд Эрчим хүчний яам дээр зарлагдсан юм байна лээ. Кореа Эксим банк санхүүжүүлж байгаа ийм төсөл. Харамсалтай нь энэ шалгарсан компани маань Солонгос улсдаа дампуурлын байдалтай болсон. Энэ талаар Кореа Эксим банкны удирдлагууд, Элчин сайд, Солонгос улсын Элчин сайдтай бид уулзаж, санал бодол явж байна. Солонгосын дампуурлын хуулиар бас манай энэ Банкны тухай хуультай ижил төстэй ийм дампуурлын процессууд явдаг учраас 2025 оны 5 сарын 15 гэхэд энэ компани цааш нь үргэлжлүүлэх үү эсвэл энэ төслийг дахиад дутууг нь шинээр компанид тендер зарлаж дуусгах уу гэдэг ийм шийдлийг нь аль нэг талыг гаргаж таарна. Энэ компани дампуураагүй байсан бол өнгөрсөн оны төгсгөлөөр бид 2026 оны 5 сарын 31 гэхэд ашиглалтад оруулж дуусах.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нямбаатар дарга Эмээлтийн үйлдвэр, технологийн паркийн талаар, ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Х.Нямбаатар: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Дэлхийн банкны санхүүжилтээр Эмээлтийн эко аж үйлдвэрийн паркийн ТЭЗҮ боловсруулах ажил хийгдсэн. ТЭЗҮ дээр бид тодорхой зүйлүүд дээр нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Дэлхийн банкны төлөөлж байгаа хүмүүстэй бид уулзаж ярилцсан. Өөрөөр хэлбэл тэнд 24мвт-ын дулааны станц барьж байгаа бол нэгмөсөн эргэн төлөлт юмаа бодоод дулааны цахилгаан станц болговол яасан юм бэ гэсэн энэ саналыг нөгөө ногоон санхүүжилт талаасаа бид болгохгүй гэдэг ийм байр сууриа айлын тал илэрхийлсэн. Тэгээд бид нар, нөгөө талдаа хэд хэдэн ийм том зардлууд гарахаар. Энэ цэвэрлэх байгууламж, авто зам, үерийн хамгаалалт, инженерийн шугам сүлжээ, үүнээс гадна сургалтын зардал, нүүлгэн шилжүүлэлтийн зардал гээд ойролцоогоор 170 орчим сая ам.долларын зээлийн гэрээг энэ хаврын чуулганаар оруулъя гэдэг саналыг айлын.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Учрал сайд 1072 хувьцаатай холбоотой асуудлаар хариулт өгөөдөхье. Нямбаатар дарга гүйцээж хариулъя.

Х.Нямбаатар: Бид ер нь энэ 170 сая ам.доллар гэдэг бол нэлээн том зардал гарахаар байна гээд энэ хавар нийслэлийн төсвөөр 2 чухал бүтээн байгуулалтын ажлынх нь нээлттэй тендерийг зарлаж байгаа юм. Нэг нь 24мвт-ын дулааны цахилгаан станц, 2 дахь нь хоногт 6700м³ бохир ус цэвэрлэх цэвэрлэх

байгууламжийн нээлттэй тендер зарлахаар бэлтгэл ажил хангагдаж байна. Бид 4 сарын 15 гэхэд тендерээ зарлана. Ирэх жил бид нөгөө Эмээлт эко аж үйлдвэрийн парк дундуур тавигдах авто зам болон үерийн усны байгууламж, цэвэр ус татах ажлуудыг хийнэ. Үүнтэй зэрэгцээд бид ирэх 2026 оноос эхлээд Эмээлтийн эко аж үйлдвэрийн паркт ажиллах ААН-үүдэд бид газрыг нь хуваарилаад, нүүлгэн шилжүүлэх процессыг зэрэг эхлүүлнэ. Бүтээн байгуулалтын ажил 2027 оны төгсгөл гэхэд цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуурга.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Учрал сайд нэмж хариулт өгье.

Н.Учрал: Энэ Эрдэнэс Тавантолгойн 1072 хувьцааг энгийн хувьцаанд шилжүүлэх шийдвэр гарсан хэдий ч яг бирж дээр бүртгэгдээгүй. Тэгэхээр арилжаалж болдоггүй. Гэтэл энэ Сайн хувьцаа гэдэг энэ хөтөлбөр хэрэгжүүлэх үеэр өөрсдөөс нь зарим нь зөвшөөрөл аваагүй, заримаас нь авсан ч гэдэг юм уу ийм маргаан үүсгээд яваад байдаг. Зөвшөөрөл аваагүй байхад ингээд хувьцаа шилжчихсэн гэдэг ийм юм ярьдаг. Энэ бол өөрөө нийт гомдлууд нь нэгтгэгдэж байгаа юм байна лээ. Тэгэхээр үүнийг бид дотор нь ялгаж, салгаж байгаад нэг шийдвэр гаргах асуудлыг Эрдэнэс Тавантолгой компани дээр шийдэх ёстой. Цаашдаа бид энэ хувьцааны талаарх ойлголтыг, санхүүгийн зах зээлийн талаарх ойлголтыг нийгэм, олон нийтэд төрүүлж байж, нэлээн хөдөлгөөн өрнүүлж байж цаашаа энэ хувьцаа арилжих, арилжихгүй асуудлыг нээх ийм бэлтгэл хангуулахаар ЗГ тогтоол гаргаад бид ажиллаж байгаа.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Хөгжлийн бодлогын бичиг баримтын хэрэгжилтийн талаар ярьж байгаа үед нэг анхаарах нэг асуудал, нэг сайшаалтай нэг асуудал хөндөж ярьж гэж бодож байгаа юм. 1990-ээд оны эхээр Улсын төлөвлөгөөний комиссыг татан буулгасан. 2020 он хүртэл үндсэндээ Монгол Улс энэ төр тодорхой бодлогогүй, бодлого нь тодорхой биш, тогтвортой биш, харилцан уялдаа холбоогүй, ялсан нам, байгуулагдсан ЗГ болгон өөр өөрсдийн дураараа бодлого явуулж ирсэн. Энэ алдааг засах гэж 19 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн.

2020 онд бид Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг Улсын Их Хурлаас санаачилж батлуулж, Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримтын Их хурлаар батлуулсан. Ингээд үндсэндээ бид хөгжлийн бодлого, Монгол төрийн бодлого тодорхой байх, тогтвортой байх, урт, дунд, богино хугацаандаа уялдаатай байх ийм хуультай болсон. Энэ хуулийн хүрээнд бид Алсын хараа 2050 урт хугацааны бодлого баталсан. Одоо бид дунд хугацааны 8 зорилтот хөтөлбөрөө батлаагүй байгаад байгаа. Эдийн засгийн, нийгмийн, хүний хөгжлийн, байгаль орчны гээд 8 зорилтот хөтөлбөр батлах ёстой юм, энэ атлагдаагүй. Энийгээ батлах тал дээр анхаарах ёстой. Энийг Эдийн засгийн хөгжлийн яам анхааралдаа аваасай.

Мөн Улсын Их Хурал дээр энэ бодлого, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасан бодлогын бичиг баримтуудаас өөр хөтөлбөр, бодлого батлах ийм асуудал гараад байгаа. Энийг манай аудит, Эдийн засгийн хөгжлийн яам, бас

бид бүхэн анхааралдаа авах ёстой. Сая Лувсанжамц гишүүн хэлж байна. Хэмжиж чадахгүй бол удирдаж чадахгүй гэж. Энэ бодлогын бичиг баримтуудын хоорондын уялдаа холбоо, 30 жилийнх нь 10 жилийн дунд хугацаатайгаа уялдах ёстой. 10 жилийн дунд хугацааны зорилтот хөтөлбөр нь 5 жилийн үндсэн чиглэлтэйгээ уялдах ёстой. 5 жилийн үндсэн чиглэл нь ЗГ-ын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөртэй уялдах ёстой. 4 жилийн хөтөлбөр нь жилийн төлөвлөгөөтэйгөө уялдах ёстой. Энэ юмнуудыг уялдуулах, төлөвлөлт дээр суурилж төсөвлөлт хийдэг байх энэ зарчмуудыг хуулийг илүү сайн хэрэгжүүлэх талаар бид анхаарах ёстой байгаад байгаа юм.

Урьд нь бид юу гэдэг юм төсөв илүү чухал гээд төсөвтэй холбоотой улсын төсөвт суулга, улсын төсөвт суулга гээд ингээд яваад байдаг. Гол нь төлөвлөгөөндөө суулгаж байж, төлөвлөгөө дээрээ суурилсан төсөв бид баталж байх ёстой. Иймэрхүү асуудлууд дээр анхаарахгүй бол саяын хэлсэн тийм зорилт, хөтөлбөрүүд алга байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн бичиг баримтад, хуульд заагаагүй бодлогуудыг Их Хурал батлаад байна. Эдгээр асуудлыг анхаарах ёстой шүү. Энийг манай Эдийн засгийн хөгжлийн яам анхааралдаа авсан уу. Энэ дээр Лувсанжамц гишүүн маань энэ хөгжлийн бодлого, төлөвлөлт дээр анхаарч ажиллая гэж байгаа болохоор анхааралдаа аваасай гэж хүсэж байна.

Бодлого сайн хэрэгжиж байгаагийн жишээ байгаа. ЗГ-ын мөрийн хөтөлбөрт Амьдралын чанар ба дундаж давхарга зорилтын хүрээнд биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ гэж. Энэ маш сайн хэрэгжиж байгаа. Бид энэ хүрээнд ААНОАТ-ын тухай хуульд өнгөрсөн оны 8 сард нэмэлт, өөрчлөлт оруулсан. Спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэгийг албан татвараас хөнгөлж, чөлөөлнө. Энэ нийт татварын нэг хувиас, татвар ноогдох орлогын нэг хувиас хэтрэхгүй байх ёстой гэж. Энэ маш сайн болсон. Өнөөдөр Монгол Улсад сагсны спорт маш эрчимтэй хөгжиж байна, хүүхэд, залуучууд ихээр сонирхож байна, гаднаас NBA-гийн хүртэл мэргэжлийн тамирчид тоглодог болсон. Манай 2 хүүхэд хүртэл волейбол суурьтай байсан бол өнөөдөр сагс тоглодог, сагс сонирхдог болж байгаа. Иймэрхүү байдлаар үндсэндээ зөв бодлого тодорхойлоод, түүнийгээ зөв төлөвлөөд, зөв хэрэгжүүлж чадвал богино хугацаанд үр дүн гарч байна. Энэ хүүхэд, залуучуудыг спортоор хичээллэх, хүмүүжих энэ тал дээр ийм татварын хөнгөлөлтийн бодлого бол маш үр дүнтэй болж байна. Иймэрхүү л бодлогын бичиг баримтуудыг бид баталдаг баймаар байна. Энэ тал дээр илүү анхаарч ажиллавал илүү үр дүн гарах юм байна шүү гэдгийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бямбацогт сайд үг хэллээ. Ингээд 13 цаг болж байгаа учраас үдээс өмнөх чуулганы хуралдааныг өндөрлүүлье. Үдээс хойших чуулганы хуралдаан 13 цаг 30 минутаас Ерөнхий сайдын мэдээллийн цагаар эхэлнэ. 13 цаг 30 минутаас.

*2025 оны 03 дугаар сарын 28, Баасан гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
13 цаг 32 минут.*

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдааныг эхлүүлье. Гишүүд танхимдаа орж ирье. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Гурав.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар/

Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийн цаг дээр Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын өнөөгийн байдал цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийнэ. Индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Эх дэлхийнхээ насыг уртасгах асуудал хүн төрөлхтний тулгамдсан асуудалд болж, олон улс өнөөдрийг хүртэл нэгдмэл байр сууринд очиж мөн нэгдсэн үр дүнтэй шийдэлд хараахан хүрч чадаагүй байна. Монгол Улсын хувьд уул уурхайд түшиглэсэн эдийн засгийн төрөлжилт, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах асуудал нь мөн бид бүгдийн тулгамдсан асуудал байсаар байна. Дэлхийн цаг уурын өөрчлөлт нь алс хол сонсогддог байсан боловч сүүлийн жилүүдэд өвлийн улирлын хүйтний уламжлалт ойлголт эвдэгдэж нүүдлийн ахуйд тулгуурласан малчдын амьдралд томоохон нөлөө үзүүлж байгааг бид бүхэн мэдэж байгаа. Үерийн асуудал ч дулааны улиралд нэмэгдэж, хот барилгын стандартыг шинэчлэх шаардлагыг мөн дагуулж байна.

Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан дэлхий даяар сорилт бэрхшээл болж буй 3 асуудлыг 1 дүгээрт цаг уурын эрс тэс байдал ба байгалийн гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдэж, далайн шуурга, хар салхи, хүчтэй аадар бороо, хэт халалт, ган гачгийн хор хөнөөл олон бүс нутагт хүмүүсийн амьдрах орчин амьжиргаанд нөлөөлж, ундны усны хомсдол үүсэж байгаа шалтгаан, мөн мөнх цас болон голын хайлалтаас шалтгаалж дэлхийн цэнгэг усны нөөцийн 70 хувь эрсдэлд орж байгааг олон улсын байгууллагууд мөн сануулсаар байна.

2 дугаарт уур амьсгалын өөрчлөлтөөс улбаалж зарим бүс нутаг хүн амыг нүүлгэн шилжүүлэх асуудал олон улсын тулгамдсан асуудал болж байна. Далайн усны түвшин нэмэгдэж арлууд, далайн эргийн хотууд усанд автах аюулд орж, ган гачгаас шалтгаалан хөрсний үржил шим буурснаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэл доголдож, хүнсний хомсдол үүсэж байгаа тул хүмүүсийн аюулгүй, тайван амьдрахын төлөөх энэхүү олон улсын шилжин суурьших үйл явцыг олон нийт анхааралтай ажиглаж мөн дүгнэлт хийж байна.

3 дугаарт биологийн төрөл зүйлийн хомсдол бий болж эко системийн тэнцвэр алдагдаж байна. Ойн түймэр, ган гачиг уур амьсгалын өөрчлөлтөөс болж зэрлэг ан амьтад устах аюулд орж, ургамал амьтны амьдрах орчин өөрчлөгдөж, олон зүйлийн тархац хязгаарлагдмал болж эхэлж байна. Эдгээр асуудал нь зөвхөн байгаль орчинд төдийгүй дэлхийн эдийн засаг, нийгэм, улс төрд хүчтэй нөлөөлж, тогтвортой хөгжлийг сааруулж, олон улсын хамтын ажиллагаа, шинжлэх ухаан, технологийн шийдлүүдийг нэн тэргүүнд хөгжүүлэх шаардлагыг мөн бий болгож байна. Уул уурхайд түшиглэсэн эдийн засагтай манай улсын хувьд эдийн засгийг төрөлжүүлж, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах нь нийгмийн тулгамдсан

асуудлын нэг хэвээр байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй үер ус, ган зудын давтамж нэмэгдэж, цаг агаарын талаар уламжлалт ойлголт эвдэгдэж нүүдлийн МАА-д түшиглэсэн малчдын амьдралд томоохон сорилт бий болж байгаа талаар манай үндэсний байгууллагууд болон холбогдох яамнууд судалгаа хийж нөлөөллийн үнэлгээ гаргаж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр манай орны агаарын жилийн дундаж температур сүүлийн 80 гаруй жилийн хугацаанд 2,4 хэмээр дулаарч, нийт нутаг дэвсгэрийн 76,8 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртөөд байна. Хүлэмжийн хийн нийт ялгарал 1990 оноос хойш 82,1 хувиар нэмэгдсэн нь хүн амын төвлөрөл, үйлдвэрлэлийн хэрэглээ, малын тоо толгойн өсөлттэй холбоотой гэж үзэж байна. Нийт хүлэмжийн хийн 51,1 хувийг ХАА-н салбар, 44,7 хувийг эрчим хүчний салбар, үлдсэн хувийг аж үйлдвэрлэлийн болон барилга, тээвэр, хог хаягдлын салбар ялгаруулж байна. Монгол Улс хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, эрчим хүч, усан хангамжийг сайжруулах чиглэлээр хөгжлийн түнш байгууллагуудтай хамтран ажиллах, тэр дотроосоо хамгийн их цөлжилттэй говийн бүс дэх эрчим хүч болон усны асуудлыг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлнэ хэмээн Засгийн газар төлөвлөж байна.

Тиймээс 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн дараа байгуулагдсан хамтарсан ЗГ НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгуудад багтсан уур амьсгалтын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, дасан зохицох асуудлыг тэргүүлэх чиглэл болгож, Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэн сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх чиглэлд ОУБ, дэлхийн улс орнуудтай үйл ажиллагаагаа уялдуулан түншлэн ажиллах зорилгоор уур амьсгалын асуудлыг бодлогын яамны түвшинд гарган тавьсан билээ. Өчигдөрхөн Улсын Их Хурлын чуулганаар соёрхон баталсан Гашуунсухайт-Ганцмод боомтын хил холболтын хэлэлцээр нь манай улсад сэргээгдэх эрчим хүчний төсөл хэрэгжүүлэх асуудлыг эрх зүйн хувьд нээж өгч байгаа нь давуу талтай байна. ХАА, МАА-н салбарын хөтөлбөрүүд ч уур амьсгалын өөрчлөлт ногоон хөгжилд үүрэгтэй бөгөөд энэ хүрээнд ЗГ-аас Атрын 4 дүгээр аяныг хэрэгжүүлж эхэлж байна.

Монгол Улсын ЗГ Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг 2019 онд баталж, хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 22,7 хувиар 16,8 сая тонн нүүрс төрөгчтэй дүйцэхүйц хэмжээгээр бууруулах зорилт тавин ажиллаж байна. Энэ зорилтын хүрээнд ЗГ 200 орчим га талбайд улсын төсөв болон олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд цөлжилт, газрын доройтлыг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод үндэсний хөдөлгөөн нь цөлжилт, газрын доройтлын бууруулах бодит алхам болж байгаа бөгөөд доройтсон газрыг нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход тодорхой үр дүнд хүрч байна. 2024 оны байдлаар 84 сая мод тарьж, бэлтгэл үе шатын гүйцэтгэл нь 42,4 хувьтай байна гэж дүгнэж байна. Монгол Улсын баруун бүс нутагт уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн мөнх цас, мөсөн гол, мөнх цэвдгийн хайлалт явагдаж буй нөлөөллийг бууруулахын тулд ЗГ-аас нэг нуур нэг сум буюу 333 нуур хөтөлбөрийг АХБ-тай хамтран хэрэгжүүлж эхлээд байна. Мөн ойн сан, намаг бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эхийг хамарсан 35,1 сая талбайг улсын тусгай хамгаалалтад авч, цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах, эрт сэрэмжлүүлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын нутаг дахь нутаг дэвсгэрийг

бүрэн хамарсан цаг уурын радиаторын нэгдсэн системийн сүлжээ байгуулахаар мөн төлөвлөн ажиллаж байна.

Түүнчлэн манай улс бэлчээр нүүдлийн МАА эрхлэгчдийн олон улсын жил болгож 2026 он болгох санаачилгыг НҮБ-ын түвшинд дэвшүүлэн батлуулж талуудын 17 дугаар бага хурлын үйл ажиллагааг уялдуулж, ирээдүйн төлөөх бэлчээрийн олон улсын эвслийг байгуулах санаачилгыг мөн дэвшүүлээд байна. 2024 онд Саудын Арабын хаант улсын Эр-Рияд хотноо зохион байгуулагдсан Цөлжилтийн эсрэг конвенцын талуудын 16 дугаар бага хуралд Монгол Улсын ЗГ-ын төлөөлөл оролцож, Тогтвортой хөгжлийн төлөө тэмүүлэе, Нүүдэлчдийн өв уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээр зэрэг арга хэмжээг зохион байгуулж, улс орныхоо соёл, уламжлал, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлыг бууруулах, ногоон хөгжлийг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлж буй бодлого, олон талт санаачилгыг дэлхий нийтэд танилцуулж, мөн чухал туршлагуудыг манай холбогдох яамдын мэргэжилтнүүд судалсан.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн асуудал улс орон бүрд хүн төрөлхтний өдөр тутмын амьдралын хэв маягт бодитоор сөрөг нөлөө болж байна. Монгол Улс уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг олон улсын тавцанд идэвхтэй үйл ажиллагаагаа явуулж байгаагийн нэг нь Монгол Улс 2026 онд НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг эх орондоо зохион байгуулах хариуцлагыг хүлээсэн явдал юм. Энэхүү талуудын 17 дугаар бага хурлыг эх орондоо зохион байгуулснаар Монгол Улс дэлхийн улс орнуудтай ногоон эрчим хүч, усны аюулгүй байдал, ногоон хөгжлийн зохистой менежментийн чиглэлээр илүү идэвхтэй хамтран ажиллах боломж нэмэгдэх, олон улсын анхаарлыг Монгол Улсын цөлжилт, усны асуудал руу татаж унаган байгалиа онгон дагшнаар нь хадгалан үлдэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, шийдвэр гаргагчид санхүүжилт хөрөнгө оруулалтыг татах боломжийг нээж, ногоон хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Талуудын 17 дугаар бага хурал буюу COP17-г зохион байгуулах асуудлыг цогцоор нь асуудлыг харах боломж бөгөөд манай улсад тус бага хурлыг даргалах эрхийг хүлээн авч НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын бодлогын чиглэлийг тодорхойлоход голлох үүрэгтэйгээр оролцоно гэсэн үг юм. Хүн төрөлхтний ирээдүй болсон газар нутгаа хамгаалахын тулд Монгол Улсад зохион байгуулах талуудын 17 дугаар бага хурал дээр, бага хурлыг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын асуудалтай цогц байдлаар гаргаж авч, нэгдсэн ойлголтод хүрэх, улмаар шийдвэртэй алхмуудыг хийхэд чухал нөлөө үзүүлнэ гэж бодож байна. Энэ ч агуулгаар улс төр хууль тогтоох байгууллагын анхааралд энэхүү олон улсын хурлыг оруулах зорилгоор ЗГ-аас өнөөдрийн мэдээллийг хийж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайдад баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Тогмидын Доржханд Монгол Улсын Шадар сайд, Салдангийн Одонтуяа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Энхбаатарын Бат-Идэр ЗГХЭГ-ын Салбарын бодлого, зохицуулалтын газрын Салбар дундын уялдааг зохицуулах хэлтсийн дарга, Цэцэгмаагийн Уртнасан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч,

Харнүдэнгийн Мөнхзул Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Нанжаагийн Цогзолмаа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Уур амьсгалын өөрчлөлтийн хэлтсийн дарга, Сүхээгийн Баярцэцэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Цөлжилт, газрын доройтол хариуцсан ахлах шинжээч, Цэндээхүүгийн Мөнхбат Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны уур амьсгалын өөрчлөлтийн өөрчлөлтийг сааруулах бодлого зохицуулалтыг хариуцсан шинжээч, Зэнээмядарийн Батбаяр Усны газрын дарга.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь цөөнхийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл, Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл, Агваанлуvsсангийн Ундраа, Батын Батбаатар үг хэлэхээр байгаа. Энэ дээр ер нь энэ манай Дэгийн байнгын хороо Ёс зүй, дэгийн байнгын хороо энэ дээр нэг анхаарч ажиллавал яг эрх барьж байгаа эрх ЗГ-ыг бүрдүүлж байгаа хамтарсан ЗГ-т орсон намууд яг сөрөг хүчнийг төлөөлж яг энэ Ерөнхий сайдын мэдээллийн цаг дээр ялангуяа үг хэлж, асуулт асууж байгаа байдал нь зарчимд нийцэж байгаа эсэх дээр ярилцах нь зүйтэй байх гэж бодоод байгаа юм. Ялангуяа өнөөдөр жишээ нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлаар сөрөг хүчний төлөөллүүд үг хэлнэ. Яг АН-аас төлөөлөл болж орсон сайдын эрхэлж байгаа асуудал байж байдаг. Тэгэхээр энийг бүгдээрээ Ёс зүй, дэгийн байнгын хороон дээр нэг ярилцаж заавал хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүйгээр зохицуулалт хийх боломжууд эрэлхийлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна. Одонгийн Цогтгэрэл даргыг индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцод 1992 онд, Парисын хэлэлцээрт 2016 онд тус тус нэгдэн орж олон улсын хурал зөвлөгөөнд тасралтгүй оролцсоор ирсэн ч уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохоос өөрөөр давж хийсэн ажилгүй 30 жилийг үдсэн мэдээлэл та бид танилцаж байна. 19 дүгээр зууны сүүлээс өнөөг хүртэл хугацаанд дэлхийн агаарын дундаж хэм нэг градусаар нэмэгдсэн байхад манай орны хувьд сүүлийн 80 жилд 2,4 хэмээр дулаарчээ. Түүгээр тогтохгүй 1990 оноос хойш 35 жилд хүлэмжийн хийн нийт ялгарал 82 хувиар нэмэгдэж нийт нутаг дэвсгэрийн 76 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртжээ. Ширгэсэн нуурын тоо, багассан мөсөн голын талбай ч сэтгэл эмзэглэн тэвшинд очсоныг уг мэдээлэлд дурджээ.

Үүнээс үүдэн ус, цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл ган, зудын давтамж ч нэмэгдсээр байна. Ийм учраас олон улсын байгууллагууд бидний уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг өртөмтгий эрсдэлтэй орнуудын тоонд оруулан нэрлэсээр ирсэн. Үүний учир шалтгааныг хариуцсан салбарынхан хүн амын төвлөрөл, үйлдвэрлэлийн тоо хэмжээ, малын тоо толгойн өсөлттэй холбон тайлбарлаж буй нь бодит байдалтай нийцэхгүй байна. Манай орны хувьд өвлийн улирлын оргил ачааллын үе дэх 1600-аас 1800мвт эрчим хүчний ачаалал ирэх жилүүдэд өсөн нэмэгдсээр 2030 он гэхэд 3500мвт давах тооцооллыг салбарын мэргэжилтнүүд гаргадаг. 2017-гоос 24 онуудад улсын хэмжээнд шинээр 12 байршилд нарны станц ашиглалтад оруулж сэргээгдэх эрчим хүчний нийлбэр хүчин чадлыг 16 онтой харьцуулахад 4 дахин нэмэгдүүлсэн хэдий ч энэ нь жилээс жилд өсөн нэмэгдэж

буй эрчим хүчний хэрэгцээ шаардлага, түүний дутагдлыг нөхөх эх үүсвэрийн бүтээн байгуулалтын чадалтай харьцуулахад үлэмж хэмжээний бага байна.

Ерөнхий сайдын уг мэдээлэлд Монгол Улсын хувьд хүлэмжийн хийн ялгаруулалтын үнэмлэхүй хувь хэмжээ бага боловч нэг хүнд ноогдох болон нэгж ДНБ-ий үйлдвэрлэлд ноогдох хувь хэмжээгээр дэлхийн дунджаас 15 дахин их байна гэж дурджээ. Энэ нь бид хүлэмжийн хий ялгаруулж буй салбаруудын үр ашгийг нэмэгдүүлж ДНБ-ийг өсгөх замаар энэ тоон үзүүлэлтийг зохистой болгох шаардлагатай байгааг харуулж байна. Гэвч МАА-н салбараас харахад бид малын тоо толгойн цөлжилт, ган зудын улмаас огцом буурсан идэвхгүй үзүүлэлтийг хүлэмжийн хий бууруулсан үр дүн мэтээр ашиглан өөрсдийгөө тоо баримтын хувьд хуурах нь нэг талаар улс орны эдийн засгийг агшаахад ийм тодорхой хэмжээнд хувь нэмэр оруулж буй ийм өрөөсгөл шийдвэр гэж тоо баримт гэж харагдахаар болчихжээ. МАА-н салбарт 2018 оны байдлаар 71 сая тоо толгойд хүрээд байсан малын тоо өнгөрсөн жил 57 сая хүрч 18 хувиар буурсан. Манай улсаас газар нутгийн хэмжээгээр хэд дахин бага Шинэ Зеланд зэрэг орнууд МАА-н салбараа хөгжүүлж нэмүү үнэ цэнийг дэмжсэн тогтолцоог бий болгох замаар ХАА-н салбараасаа жилд 40 орчим тэрбум ам.долларын экспорт болж байгаагаас харвал бид ХАА-гаасаа илүү үр ашигтай бодлого явуулах ийм хэрэгцээ шаардлага тулгамдсан байгааг бид нарт харуулдаг.

Харин ой, усны нөөцийг хамгаалах, биологийн олон янз байдлын хамгааллыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилт харьцангуй өндөр хувийн биелэлттэй байгаа нь булаг шанд, рашааны ундаргын эхийг хамгаалж, хөв цөөрөм байгуулж, ойн арчилгаа цэвэрлэгээг жил бүр нэмэгдүүлж, ойн нөхөн сэргээлт, ойжуулалтын ажлыг нэмэгдүүлнэ, Тэрбум мод зэрэг тэргүүтэй ажлуудыг хэрэгжүүлж буй нь тодорхой үр дүн байх. Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөд бүтээлчээр дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлын бууруулах асуудалд урт хугацааны тогтвортой бодлоготой байх шаардлагатай ба үүнтэй холбогдуулан ЗГ-аас авч хэрэгжүүлэх үндэсний зорилт, үндэсний арга хэмжээний хүрээнд Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн зүгээс дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Монгол Улс 2035 онд хүртэл эрчим хүчний салбарт сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30 хувьд хүргэх зорилт тавьсан. Тухайн үеийн эрчим хүчний суурилагдсан хүчин чадлыг 3500мвт-д хүргэхээр зорьсны 1000 нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр байгааг эргэн харж, хөрөнгө оруулалтын бодит боломж сэргээгдэх эрчим хүчний тариф болон сэргээгдэх үүсвэрээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний үнийн зөрөөг дэмжих тарифаар нөхөн олгоход эдийн засгийн тооцоолол, төсвийн дарамт зэргийг бид нягтлан үзэх шаардлагатай.

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээний хүрээнд эрчим хүч, дэд бүтэц, ХАА, ойн болон халаалт дулааны зэрэг технологид инновац нэвтрүүлэх, урамшуулах бодлогыг түлхүү баримтлах, цаашлаад хувийн хэвшлийн оролцоог хангахад түлхүү анхаарах шаардлагатай байна. Монгол Улсын статистик 1990 оноос хойш жилд дунджаар 240 мянган га хүртэлх ойг ойн хөнөөлт хортон шавж болон ойн түймэрт.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Намуудад 25 минут оногдож байгаа учраас олон хуудас, нэг минут нэмье Цогтгэрэл даргад.

О.Цогтгэрэл: Манай улсын хувьд жилд орох бороо хурын давтамж хэмжээ багасаж, хур тунадасны хэмжээ илт буурсан нь хөрш зэргэлдээ орнуудын ХАА-н салбар дахь үүлэнд нөлөөлөх технологиос хамаарч буйд судалгаа хийж ажиглалт хийж, илт нөлөөлөх, илт нөлөөлж байх энэ тохиолдолд хөрш орнуудтай бодлогын яриа хэлэлцээр хийх шаардлагууд бид нарт байна. ХАА-н салбарт усалгаатай газар тариаланг хөгжүүлэх, малын тэжээл тариалалтыг усалгаатай технологиор дэмжих, газар тариаланд хөрс хамгаалах арга хэмжээ дорвитой хэрэгжүүлэх, ойн зурвас байгуулах, гол мөрний урсцаас болон үерийн усаар хуримтлуулах нуур цөөрөм хуримтлуулах зэрэг энэ санаачилгуудыг бид идэвхтэйгээр хэрэгжүүлэх шаардлага бид нарт тулгарч байна. НҮБ-ын өмнө хүлээсэн үүрэг, тавьсан амралтын хэрэгжилтийн тайланг цаг хугацааны гаргаж, олон нийтэд байршуулах, ногоон хөгжлийн бодлогын хүрээнд дэлхийн ногоон сангийн санхүүжилтийн боломж, нүүрстөрөгчийн зах зээл, карбон... эдийн засгийн хөшүүргийн механизмыг түлхүү ашиглах, идэвхжүүлэх, ногоон санхүүжилтийг татах чиглэлд үндэсний чадавхыг бэхжүүлэх зэрэг чиглэлд онцгойлон анхаарах шаардлага бид бүгдэд байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн асуудал нь бүх дэлхий, бүс нутаг, улс үндэстний нийтийн асуудал тул хүрээлэн буй орчиндоо хандах иргэний эерэг хандлагаас төрийн тулхтай бодлого хэрэгжилт хүртэлх бүх шатад санаачилга гарган ажиллах шаардлагатай байгааг анхааран сануулъя. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл гишүүн үг хэлнэ. Индэрт урья.

Б.Мөнхсоёл: Сайн байцгаана уу, өдрийн мэнд хүргэе. Эрхэм Улсын Их Хурлын дарга, гишүүд, Ерөнхий сайд аа,

Дэлхийн нийтийн болон манай улсын хувьд өнөөдөр болон ирээдүйд улам бүүр анхаарч буй сэдвийн талаар сая Ерөнхий сайд танилцууллаа. Ерөнхий сайдын илтгэлд 1992 оноос хойших 28 жилийн хугацаанд цөлжилтөд өртсөн газар нутгийн хэмжээ 36 хувиар нэмэгдэж, нийт нутаг дэвсгэрийн 77 хувь нь цөлжилтөд тодорхой хэмжээгээр өртсөн гэлээ. Энэ нь нэг талаас дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, нөгөө талаас бэлчээрийн менежмент, сүргийн бүтэц болон бусад салбараас үүдэлтэй хүний хүчин зүйлсийн нөлөөнөөс хамаарч буй. Бид уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын конвенцод нэгдэн орж, 2030 он гэхэд Монгол Улс хүлэмжийн хийн ялгаруулалтаа 22,7 хувь буюу 16,9 сая тонноор бууруулна гэсэн амлалт өгсөн. Тэгвэл хүлэмжийн хийн нийт ялгаруулалтын 52 хувийг бий болгож буй ХАА-н салбар, 45 хувийг бүрдүүлж буй эрчим хүчний салбарт дорвитой ахиц гаргахуйц ажлууд үгүйлэгдэж байна.

Мөн бидний өгсөн амлалт, хийж буй ажлууд, зөрөлдөх тохиолдлууд ч байсаар байна. Тухайлбал, бэлчээрийн даацыг бууруулж, менежментийг нь сайжруулах үүднээс малын тоо толгойг 52 сая болгох тооноос чанарт шилжих шаардлагатайг эрдэмтэд экспертүүд тооцоод гаргачихсан. Ийм зорилгоор малын тоо толгойн албан татварыг 2020 онд Улсын Их Хурлаас баталсан. Гэвч уг татвар нь малын тоо, тоог толгойг бууруулж, чанарыг сайжруулах эдийн засгийн хөшүүрэг болж хараахан чадахгүй байна. Зүй нь, энэ шууд алгасъя. Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахын тулд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан

Тэрбум мод үндэсний хөдөлгөөн санаачилга гарган хэрэгжиж байна. Гол нь тэрбум модоо 2030 он хүртэл тарьж ургуулах суулгацыг бэлдэж, модыг ургуулах ойн, ойг нөхөн сэргээх арчлах бизнес загвар болохуйц ойн аж ахуйг хөгжүүлэх шаардлага байна. Ойн менежментийг цогцоор нь харж хөгжүүлэхэд мэргэжилтнүүд ойн аж ахуй, хүний нөөцийг бэлдэх, санхүү, татварын зохицуулалтаар урамшуулах, салбаруудын бодлогын зохицуулалтыг сайжруулах хэрэгтэй нь харагдаж байна. Наанадаж ХАА-н сургуулиас гадна мэргэжлийн болон техникийн боловсролын төвүүд ч хүний нөөцийг бэлтгэхэд оролцмоор байна. Хэрэв бид бусад улс шиг ойн аж ахуйг хөгжүүлж, энэхүү ногоон бизнесийн эдийн засгийн, бизнесийг эдийн засгийн нэг салбар болгож чадвал тогтвортой хөгжлийн зорилго 8 болох зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлт, зорилго 13 болох уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, зорилго 15 болох хуурай газрын экосистемийг хамгаалах зэрэг зорилгуудыг биелүүлэхэд хувь нэмэр оруулахаас гадна хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэнээр ядуурлын устгах, өлсгөлөнг зогсоох зорилгуудад ч эерэг нөлөө үзүүлэх юм.

Энэ мэтчилэн бидний аливаа бодлогыг гаргаж хэрэгжүүлэхдээ бусад салбарт үзүүлэх үр нөлөө, салбар хоорондын уялдааг харгалзан нэг сумаар олон туулай буудах бодлого үйл ажиллагааг ХАА, эрчим хүч, хог хаягдлын менежментийн чиглэлээр хэрэгжүүлмээр байна. Ингэж чадвал 2030 он хүртэлх 5 жилийн хугацаанд уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг тодорхой ахиц гаргаж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр болох юм. Улсын Их Хурлын гишүүд бидний хувьд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох зорилгоор бодлого хоорондын уялдааг хангах, ногоон хөгжлийг дэмжих эдийн засаг, санхүүгийн хөшүүрэг, зохицуулалт, нүүрстөрөгчийн зах зээл, ногоон санхүүжилтийг хөгжүүлэх зэрэг олон харилцааг зохицуулах Уур амьсгалын өөрчлөлтийн хуулийн төслийг хэлэлцэн сайжруулж батлах нь 2025 онд хийх гол ажил болох юм.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дэргэдэх Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороог ахалж байгаагийн хувьд энэ жил бид Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт, уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийн талаар болон Ядуурлыг бууруулах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээрх нөхцөл байдал цаашид хийх ажлын талаар холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудаас мэдээлэл тайлбарлах ажлуудыг хийхийн зэрэгцээ Улсын Их Хурлын Тамгын газар ОУБ-ын дэмжлэгтэйгээр Улсын Их Хуралд тайлагнадаг байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрхэн хангаж буйг давхар нягталдаг болоход анхаарч ажиллана. Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг бууруулах зэрэг Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлж, дэлхийн бусад улсын өмнө өгсөн амлалтаа биелүүлэх нь шийдвэр гаргагчид бодлого боловсруулж хэрэгжүүлэгч байгууллага бүрийн үүрэг тул бид бодлого болон салбар хоорондын уялдааг хангаж ажиллах, тогтвортой хөгжлийн зорилгуудыг үйл ажиллагаандаа тусгаж ажиллах нь нэн чухал байна. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Агваанлуvsангийн Ундраа гишүүн үг хэлнэ. Индэрт урьа.

А.Ундраа: Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэлтэй танилцлаа. Бид байгальтайгаа зохицон амьдардаг нүүдэлчин соёл ахуйтай агуу уламжлалт үндэстэн билээ. Нийгэм, эдийн засгийн томоохон салбарууд маань МАА, газар тариалангаас хамаардаг нь манай улс уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг эмзэг хүлээж авах эрсдэлийг нэмэгдүүлдэг. Үүнийг ч олон улсын байгууллагуудаас дүгнэж хэлж байна. Хүний үйл ажиллагаанаас үүдсэн байгаль орчны нөлөөлөл, олон сөрөг үр дүн гарч байгаа нь бидний нүдэнд илхнээ байна. Монгол Улс НҮБ-ын уур амьсгалын өөрчлөлтийн тухай конвенцод 1992 онд нэгдэн орсон Парисын хэлэлцээрт 2016 онд нэгдэн орсон эхний улсуудын нэг бөгөөд тодорхой амлалт өгч олон улсын тавцанд үүрэг хүлээсэн.

Уур амьсгалын өөрчлөлт тэр дундаа цөлжилт, газрын доройтол эрчимтэй явагдаж буй улсын тоонд бид ороод байна. Нийт газар нутгийн 76,9 хувь нь цөлжилтөд өртсөн байгаа нь аюулын дохио гэж үзэж байна. Энэ үзүүлэлт сүүлийн 14 жилийн хугацаанд 4,9 хувиар нэмэгдсэн байгаа нь дэлхийн дулаарал малын тоо толгойн өсөлт, хүний зүй бус үйл ажиллагаатай холбоотой. Манай улс олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр олон судалгаа, төсөл хөтөлбөр авч хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай. Монгол Улсын газар нутгийн тодорхой хувийг тусгай хамгаалалтад авч, тодорхой хэлбэл 30 хувь хүртэл хэмжээг тусгай хамгаалалтад авч, цаашдын хөрсний доройтол, цөлжилтөөс хамгаалахаар зорьж байгаа нь зайлшгүй хийгдэх сайшаалтай арга хэмжээ. Гэсэн хэдий боловч олон улсын байгууллагуудад найдаад суулгүйгээр төсвийн төлөвлөлтийг илүү оновчтой хийх шаардлагатай гэдэг нь харагдаж байна. Монгол Улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авах арга хэмжээний төлөвлөгөөг илүү боловсронгуй болгож, асуудалд илүү шинжлэх ухаанчаар хандах шаардлагатай гэдэг нь саяын мэдээллээс харагдлаа.

Бид тунхаг бичиг цаасан дээрх олон эрх зүйн баримт гэхээсээ илүү иргэддээ уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөл байдлыг зөв таниулж, хувь нэмэр оруулахыг уриалан манлайлж ажиллах шаардлага байгааг саяны тоо баримтууд харуулж байна. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг байдлыг бууруулах, дасан зохицох, угтаж хөгжихөд хүн болгоны хүчин чармайлт хэрэгтэй. Түүнчлэн бид үнэт өв соёл болох нүүдэлчин соёлыг хамгаалан түүний зэрэгцээгээр бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүйгээр бүсчлэн бүс нутаг бүрээр тоо толгойн хэм хэмжээг зохистой тогтоож, тооноос илүү чанарт анхаарал хандуулсан бодлого боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна. Малчид олон малаас ашиг шим хүртэнэ. Мянгат малчин гэж шагнахаасаа илүү нэг малаас гарах ашиг шимийг нэмэгдүүлэх, бэлчээрийн даацтай уялдуулах, амьжиргааг дэмжих бодлогыг бүсчлэн хөгжүүлэх шаардлагатай байна. Тодорхой жишээнүүд дурдвал өнгөрсөн жилд гэхэд л Хөвсгөл аймагт ган гачиг тохиолдож, энэ өвлийн байдлаар цас хур тунадас бага унасан байгаа нь хангайн бүсэд ховор тохиолддог. Гэтэл говийн бүс нутгуудаар үер усны аюул нүүрлэсэн нь Монгол орны цаг агаар, эрс тэс уур амьсгал аль хэзээний аюулын түвшинд хүрснийг харуулж байна.

Хөвсгөл нуурын цөнгийн түрэлт жил бүр 6 сарын 22-ны орчим байдаг бол нар буцах өдөр болдог байсан бол өнгөрсөн жил 5 дугаар сарын 29-нд цөн түрсэн нь, мөн түүнчлэн тус бүс нутгийн мөнх цастай уулын цас мөс эрчимтэй хайлж байгаа нь усны нөөц урт хугацаандаа хойд бүс нутгуудаар ч дутагдаж болзошгүйг харуулж байна. Иймд нийт газар нутгийн 80 орчим хувь нь цөлжилтөд тулгамдаад байгаа энэ цаг үед төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангаж ажиллах

тухайлбал Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн үр ашгийг нэмэгдүүлэх, үүний тулд бүс нутагт хойд бүс нутагт төдийгүй бусад газар нутагт мод ихээр тарих цаг уурын өөрчлөлтийн эсрэг авах арга хэмжээ мод тарих дээрээ нэмээд ургуулах арга хэмжээг уялдуулах, 2 дугаарт аймаг, сум бүрд хиймэл нуур цөөрөм олноор байгуулах санал санаачилгыг энэ ажилтай уялдуулах, 3 дугаарт Тогтвортой ноолуурын хөтөлбөр зэрэг малчдын амьжиргааг дэмжсэн ажлуудыг уялдаа холбоог хангаж ажиллах шаардлагатайг харуулж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн үг хэлнэ. Индэрт урьж байна.

Б.Батбаатар: Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүд ээ, Ноёд, хатагтай аа,

Уур амьсгалын өөрчлөлт газрын доройтлын өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний асуудалд Улсын Их Хурлын 118 гишүүнийг бүрдүүлсэн МАН, АН8 ХҮН намын эрх баригчдаас томилогдсон Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн мэдээлэлд Иргэний Зориг Ногоон Намын байр суурийг төлөөлөн илэрхийлье. Байгаль орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлт нь аж үйлдвэржилт, түүхий эд, байгалийн баялгийн зохисгүй ашиглалт, үлэмж нэмэгдсэн хэрэглээ, технологи зэрэг хүний буруутай үйл ажиллагааны улмаас үүсэж байгаа. Тодруулбал хүний буруутай үйл ажиллагааны улмаас хүлэмжийн хий буюу нүүрсхүчлийн хийн ялгаруулалт нэмэгдсэнээр температурын өсөлт 2030 он гэхэд 07-гоос 1,4 хэмээр, 2080 он гэхэд 1,2-оос 6,5 хэмээр нэмэгдэх тооцоо гарчээ. Температур 1 градусаар нэмэгдэхэд ДНБ 0,48 хувиар саардаг болохыг судлаачид, эдийн засагчид тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл нэг градусаар нэмэгдсэнээр өнөөдрийн нөхцөлд Монгол Улсад 456 тэрбумын алдагдал хүлээхээр байна гэсэн үг.

Байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар хөгжиж буй орнуудын хүн ам тэр дундаа нийгмийн ядуу давхаргад илүү нөлөөлдөг. Дэлхийн банкны тооцооллоор 2030 он гэхэд 100 сая хүн нэмж туйлын ядууралд орох магадлалтай төдийгүй манай улсын хүн амын 1/3 шууд нөлөөлөхөөр байна. 2/3-т нь дам нөлөөллөө үзүүлэх хандлага байгааг бид бодолцох ёстой. Монголбанкнаас хийсэн уур амьсгалын өөрчлөлтийн эдийн засаг дахь нөлөөллийн судалгаанд Монгол орны агаарын жилийн дундаж температур 80 жилийн хугацаанд 2,25 градусаар дулаарсан нь дэлхийн дунджаас 2 дахин өндөр, байгалийн гамшигт үзэгдлийн тоо 2010 оноос хойш 1,8 дахин нэмэгдсэн байна. Монгол орны хувьд байгалийн гамшигт үзэгдлийн тоо эрс нэмэгдэж, температур хурдацтай нэмэгдэж байгаа нь ургацын гарцыг бууруулж, бэлчээрийн доройтол цөлжилтийг нэмэгдүүлснээр ХАА-н гарцыг бууруулах эрсдэл өндөр байна.

ХАА-н гаралтай бүтээгдэхүүний хэрэглээ өндөр, МАА-гаас хамааралтай манай улсын хувьд уур амьсгалын өөрчлөлт нь эдийн засагт сөргөөр нөлөөлөхөөс гадна иргэдийн амьжиргаа, амьдралын хэв маяг, хүн амын нягтрал буюу хот, төв суурин газрыг чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэх зэрэг нийгмийн олон асуудлыг дагуулна. Түүнчлэн иргэдийн эрүүл мэнд, эрүүл аюулгүй орчинд амьдрах боломж, амьдралын чанарт ч сөргөөр нөлөөлөхөөс гадна мод, ургамлын төрөл зүйл, ургалт, насжилт, бичил биетнээс эхлээд зэрлэг амьтдын тоо толгой, төрөл зүйл, бэлчээрлэлт гээд биологийн олон янз байдалд ч үлэмж өөрчлөлтийг авч

ирнэ. Иргэний Зориг ногоон намын үзэл санаа, үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг бол байгаль экологийн тэнцвэртэй байдал, экологийн чиг баримжаатай, нийгмийн даацтай эдийн засгийн хүртээмжтэй ногоон хөгжлийг тууштай дэмжиж түүчээлэн манлайлах явдал билээ.

Уур амьсгалын өөрчлөлт бол дэлхий нийт бүс нутгийг хамарсан олон улсын глобал асуудал боловч бид уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бүхий л боломжийг хувь хүнээс эхлээд хувийн хэвшлийн ААНБ, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага, бодлого боловсруулагчид, төрийн байгууллага, ОУБ төдийгүй бүс нутгийн болон бусад улс орнуудын хамтын оролцоог дэмжин ажиллах зарчмаар шийдэх нь зүйтэй. Нэг талаас байгаль орчны доройтол уур амьсгалын өөрчлөлтөд хүргэж буй хүний буруутай үйл ажиллагааг бууруулах, таслан зогсоож нөгөө талаас уур амьсгалын өөрчлөлт, байгаль экологийн доройтол, байгалийн гамшгийн эрсдэлд өртөж болзошгүй субъектүүдийн хамгаалах, үүсэж болзошгүй хохирлыг бууруулах шаардлагатай байна.

Иймээс Иргэний Зориг Ногоон нам ЗГ-ыг дараах чиглэлд ажиллахыг сануулж шаардаж байна. Үүнд, 1-д байгалийн нөөцийг хэтрүүлэн ашиглах, зүй бусаар ашиглах явдлыг тогтоох, хянах, таслан зогсох. 2-т хувь хүмүүсийн хүрээлэн буй орчныг бохирдуулах, доройтуулах явдлыг бууруулах. Иргэдийн экологийн боловсролыг тэдний нас, сэтгэл зүйн онцлогт тохируулан дээшлүүлэх сургалт нөлөөллийн ажлыг бүх арга замаар зохион байгуулах зохион байгуулалтыг дэмжих. Мөн байгаль, экологи, уур амьсгалд эерэг нөлөөтэй авч хэрэгжүүлсэн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа боломжийг тодорхойлон дэмжих шаардлагатай. 3-д хуванцрын хэрэглээг бууруулах. Ингэхдээ нэг удаагийн хуванцрын импортын татварыг нэмэгдүүлэх, зарим хэрэглээг хязгаарлах, хуванцрыг орлуулах хувилбар, цаасан хэрэглээг дэмжих зэргээр нэг удаагийн хуванцрын хэрэглээг бууруулах хуулийн төслийг санаачлан батлуулах шаардлагатай. 4-д олон жилийн дунджаар байгалийн гамшиг тохиолддог бүс нутгуудын хийгээд гамшигт өртөх магадлал бүхий айл өрх, иргэд, мал, эд хөрөнгийн зэргийн нарийвчилсан судалгааг гаргах. Тэдгээр эрсдэл болон учирч болох хохирлыг бууруулах үйл ажиллагааг орон нутгийн засаг захиргааны байгууллага, Онцгой байдал, цагдаагийн албатай хамтран хэрэгжүүлэх, түүнийг дэмжих.

Мөн тухайн эрсдэл бүхий бүс нутагт амьдарч буй иргэд, ААН-үүдэд гамшгийн эрсдэлийн бэлэн байдлын талаар болон гамшгийн эрсдэлээс хамгаалуулах, хохирол багатай даван туулах боломжит хувилбарыг хэрэгжүүлэхийг дэмжих. 5-д тогтвортой ногоон хөгжлийг хөгжүүлэх болон инновацын кластеруудыг бий болгоход дэмжлэг үзүүлж, судлаачид, бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдыг нэгтгэн байгальд ээлтэй шийдлүүдийн талаар хамтран ажиллах. 6-д нар, салхи, усан цахилгаан эрчим хүч зэрэг ногоон эрчим хүчний эх үүсвэрт шилжих үйл явцыг түргэтгэх бодлого, сэргээгдэх эрчим хүчний найдвартай байдлыг нэмэгдүүлэхийн тулд эрчим хүч хадгалах технологийн судалгааг дэмжих. 7-д ногоон тээвэр, эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж, байгальд ээлтэй хот төлөвлөлт зэрэг тогтвортой байдлыг нэн тэргүүнд тавьсан дэд бүтцийн төслүүдэд хөрөнгө оруулах. 8-д газар тариалан, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зэргээр тогтвортой ХАА-н практикт инновацыг дэмжин орон нутгийн хүнсний тогтолцоог сайжруулах, газар тариаланд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Б.Батбаатар: Газар тариалан, түгээлт, хүнсний технологийн чиглэлээр ажлын байр бий болгох санаачилгыг дэмжих зэрэг шийдлүүдийг санаачлан ажиллахыг ЗГ-т уриалж байна.

Цаашид ЗГ өөрөө өөртөө сөрөг хүчний хэлбэр хийцээр олон нийтийг төөрөгдүүлсэн Их Хурлын индэр дээрээс төөрүүлэх энэ зүйлийгээ болимоор байна. МАН, АН, ХҮН намын хамтарсан эрх барьж байгаа 118 гишүүнтэй бүлэг энд Засаг дээрээ сөрөг хүчний үүргийг гүйцэтгэхийг Их Хурлын индэр ашиглахгүй байхыг дахин сануулж зөвлөж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Мэдээлэл хийж дууслаа. Мэдээлэлтэй холбогдуулан Ерөнхий сайд болон ажлын хэсэг, Ерөнхий сайд болон салбарын сайд, ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, үг хэлэх цөөнхийн төлөөлөл Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Алга байна, байгаа юм уу? Одонгийн Цогтгэрэл гишүүн, Батын Батбаатар гишүүн 2-оор тасаллаа Батын Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Би Ардын намын бүлгийн дарга, АН-ын бүлгийн дарга, тэгээд энд сууж байгаа ХҮН намын дарга энэ 3 хүнээс асуумаар байгаа юм. Цөөнх гэж юуг үзэж байгаа юм бэ гэдгийг хариулж өгөөч л гэж хүсэлт тавьж байна.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Энэ уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой Ерөнхий сайдын мэдээлэл орж ирж байна. Уур амьсгалын өөрчлөлт гэдэг асуудлыг хүний хүчин зүйлтэй холбоотой, холбоогүй гээд л янз бүрээр л байр сууриуд байдаг. Тэгэхдээ яалт ч үгүй нөгөө тоогоор илэрхийлэгддэг эдийн засагтай холбоотой олон зүйлүүд дэлхий нийтэд энэ асуудлын цаана явж байдаг. Тэр тусмаа хүлэмжийн хий, CO₂-ын ялгаруулалт, нүүрстөрөгчийн давхар исэлттэй холбоотой эдийн засгийн харилцаа. Энэ харилцааны цаана карбон кредит гээд ингээд том бүхэл бүтэн том зах зээл үүсчихсэн ингээд явж байна л даа. Тэгэхээр бид бүгдийн хувьд Монгол Улсын хувьд бид бүгд чинь нэг энэ уур амьсгалын өөрчлөлтөд оруулж байгаа нөлөө гэдэг зүйл бид нарын хувьд маш бага, маш бага гэж үзэж таарах байх. Тэгэхээр бид нарын хувьд ер нь энэ дэлхий нийтэд яг энэ уур амьсгалын өөрчлөлтөд их хэмжээний нөлөө оруулж байгаа улс орнууд үндсэндээ агаар бохирдуулж байгаа улс орнуудын тэр төлөх төлж байгаа тэр үндсэндээ тэр карбон кредитийн мөнгө багц тэр fund-н мөнгө яг өнөөгийн байдлаар хэчнээн ямар хэмжээтэй дүн байна вэ? Эндээс Монгол Улсын хувьд авч байгаа авч болох эдийн засгийн бид нэг өгөөж сэргээгдэх эрчим хүчээр, тэр ногоон барилга болоод лид сертификат олон, олон зүйлүүд, ХАА талаасаа олон, олон зүйлүүд дээр бид нарт ямар боломж бололцоонууд байдаг вэ? Энэ ногоон санхүүжилтийн хүрээнд.

Яг өнөөдөр Монгол Улсад олгогдсон нийт зээлийн нэг орчим хувь нь ногоон санхүүжилтийн хүрээнд ашиглагддаг. Энийг 10 орчим хувь хүргэж нэмэгдүүлэх боломжтой гэдэг тоонуудыг уншиж байсан. Мөн энэ ногоон карбон кредитийг нь үндсэндээ тэр мөнгөн дүн нь fund-н зах зээл нь өөрөө жилд 20 орчим хувиар нэмэгдэж байгаа гээд янз бүрийн нэг албан бус тоонууд явж байдаг. Тэгэхээр Монгол Улс өнөөдөр энэ эдийн засгийн боломж бололцоонуудыг хэрхэн, яаж

ашиглаж энэ ашигладаг вэ? Ямар боломжууд бид нарт байдаг вэ, ААН, иргэд энэнд хэрхэн яаж оролцох боломжууд байдаг вэ гэдэг талаар тодорхой тоон тодорхой мэдээллүүдийг өгөөч гэж хүсье.

Д.Амарбаясгалан: Салдангийн Одонтуяа сайд хариулт өгье.

С.Одонтуяа: Маш чухал асуулт асуулаа. Дэлхий ертөнц энэ уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчноо хамгаалахад гарах зардлыг улсын төсвөөр ямар ч орон хийж чадахгүй гэдгийг бүгд хүлээн зөвшөөрсөн. Өмнө нь нэг ийм сангууд байгуулагдаад энэ сангийн зардлаар хийж байсан бол одоо бол энэ ямар ч хангалтгүй. Тийм учраас энэ дээр заавал оролцогч талуудын сонирхлыг багтаасан ийм хөрөнгө оруулалт байх ёстой юм гэдэг дээр санал нэгдсэн. Энэний нэг нь яах аргагүй энэ карбоны арилжаа байгаа. Тэгэхээр манай улсад гадаадын олон байгууллагууд гаднын ЗГ-ынхан ирээд энэ карбоны талаар маш олон санал тавьдаг. Манайд яг энэ хууль, эрх зүйн орчин нь байдаггүй. Тийм учраас Эдийн засаг, хөгжлийн яам Гантөмөр сайдаар ахлуулаад манай яамтай хамтраад бид сая өнгөрсөн сарын хугацаанд маш богино хугацаанд энэ уур амьсгалын өөрчлөлтийн хуулийг боловсруулаад ерөнхийдөө дуусах шатдаа явж байна. Энэ уур амьсгалын өөрчлөлтийн хуульд саяын таны хэлсэн бүх зүйлүүдийг зохицуулах ийм боломжуудыг нээх гэж байгаа юм.

Энд бол нэг бүлэг нь яг энэ карбоны арилжаатай холбоотой ийм бүлэг байгаа. Тэгээд бид энэ карбоныхаа тооллогыг яаж зохион байгуулах юм, яаж энэ эрсдэлийн үнэлгээг нь хийх юм, яаж тайлагнах юм, үндэснийхээ карбон кредит бүртгэлийг яаж хийх юм гээд бүх зүйлийг ингээд тусгаж байгаа. Тэгэхээр бид ямар ч байсан нэг ийм эрх зүйн бичиг баримттай больё гэж байгаа. Бусад орнуудын хувьд энэ маш том Засгийн газруудын том арилжааны хэлбэрт орсон. Жишээлэхэд Сингапур улс хамгийн идэвхтэй ажиллаж байгаа. Эндээ 1 тэрбум доллар зарна гээд, нийтдээ 22 улстай энэ карбоны хэлэлцээр хийчихсэн байна. Япон 29 улстай, Швейцар 17 улстай гээд ингээд дэлхийн улс орнууд энэ том арилжааныхаа зах зээл рүү ороод эхэлсэн. Яагаад гэхээр тухайн улс орон дотор нь энэ хүлэмжийн хий ялгаруулж байгаа газруудад нь татвар нь өндөр болсон учраас бусад орноос энэ карбоныхаа юуг байгаль орчинд нь зарцуулж мөнгө олох ийм хэлбэр лүү орсон байгаа.

Манайд энэ гэр хорооллыг сэргээгдэх эрчим хүчинд холбох нэг айл бүрд 3 мянган долларын нарны зай батарейтайгаа энэ төслийг UNDP хэрэгжүүлж байгаа. Энэ төсөл яг айлаас нь энэ мөнгө нь гарахгүйгээр айлд нөгөө яндангүй бүс болгоод, тэгээд энэ мөнгөө карбон кредитээс жилийн юу хэд билээ 900 доллар ч билүү аваад ингээд явж байгаа ийм арилжаанууд байгаа. Дээр үед манайд энэ утаагүй зуух тавьсан банкнууд, банк бусууд энэ карбон кредитэд энийг хийгээд ингээд явж байсан. Тэгэхээр энийг эрчимжүүлэх хэрэгтэй. Нэг шинэ хэлбэр та сая зөв оллоо. Орчин үед ямар хэлбэр юм бэ гэхээр улс орнууд энэ өрөө наймаалдаг болсон. Жишээлэхэд сая манай Сангийн яам, ЭМЯ хамтраад debt for health гэж маш чухал энэ хөтөлбөрийг эхлүүлсэн. Энэ бол эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалт хийгээд хамтраад энэ өрнөөс хасагдах. Тэгэхээр манайх яам бол debt for nature гэдэг энэ өрийн харилцан юу гэдэг юм нөгөө тооцох ийм зүйлүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Өөрөөр хэлбэл би дахиад хэлэхэд зөвхөн төсөв төслөөр явахаа байсан. Том банкнууд, санхүүгийн байгууллагууд энд өөрсдөө идэвхтэй оролцож байж л энэ зах зээл амжилттай хөгжинө гэдгийг дэлхийн улс орнууд тодорхойлоод ирсэн учраас сүүлийн энэ COP-ын хурлуудад дандаа хөрөнгө оруулагчид, банкнууд ийм зах зээлд яг энийг мөнгө болгоё, арилжаа болгоё гэсэн ийм чиглэлээр ажиллаад байгаа юм. Манай улс энэ joint credit Механизм гээд энэ механизмд нэгдээд олон жил болсон ч гэсэн энэ харьцангуй их бага хэмжээнд явж байгаа. Ер нь манай улсын нийт эдийн засгийн 10 хувь нь л нэг ногоон эдийн засаг гэж үзэж байгаа бол 90 хувь нь хүрэн эдийн засаг гэхээр арай л энэ тоог багасгах шаардлагатай байгаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.9-д заасны дагуу намын бүлэг тус бүрээс нэг гишүүн төлөөлж Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудсанд байршуулсан Ерөнхий сайдын мэдээллийн сэдэвтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн асуултуудыг асууна. Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Мөнхбат асуулт асууна. Мөнхбат гишүүн асуултаа асууж эхэлье.

Ц.Мөнхбат: Монгол Улсын Ерөнхий сайд уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлын өнөөгийн байдал цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийхтэй холбогдуулан d.parliament цахим системд ирүүлсэн иргэдийн асуултыг уламжилж байна. Иргэн Батбаатарын зүгээс байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэдэн хувийг цөлжилт, газрын доройтлыг бууруулахад ашиглаж байна вэ гэдэг асуулт байна. 2 дугаарт сүүлийн жилүүдэд орон даяар шороон шуурга шуурах давтамж нэмэгдэж байгаа нь цөлжилтийн аюул бодит болсныг харуулж байна. 3 жилийн өмнө цөлжилт, газрын доройтол, хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд мэдээлэл хийж байсан. Түүнээс хойш цөлжилттэй тэмцэх талаар ямар ахиц гарав? Энэ хугацаанд цөлжилт хэдэн хувиар нэмэгдсэн бэ гэсэн ийм асуулт байна.

3 дугаарт сүүлийн үед энэ цөлжилтийн асуудал нэлээд яригдах боллоо, одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ талаар мэдээлэл өгнө үү гэсэн байна. 4 дүгээрт Монгол Улсад 2026 онд зохион байгуулагдах талуудын 17 дугаар бага хурлын ач холбогдол, бэлтгэл ажлын талаар юу хийж байгаа вэ гэдэг асуулт байна. 5 дугаарт одоогийн мал сүргийн тоо толгой Монгол орны бэлчээрийн даацаас үлэмж хэтэрч байгаа бөгөөд улам өссөөр байна. Үүний улмаас бэлчээрийн газар нутгийн 2/3 нь доройтсонд тооцогдож, 10 хувь эргэлт буцалтгүй доройтолд оржээ. Түүнчлэн Монгол Улсын МАА-н салбар олон улсад нүүрстөрөгч ялгаруулалтын эрчмээр хамгийн өндөрт тооцогдож байна. Манай ЗГ үүн дээр ямар байр суурьтай байна вэ гэсэн асуулт байна. 6 дугаарт Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилт болон уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ хоорондын уялдаа холбоог ЗГ хэрхэн харж уялдуулан ажиллаж байна вэ гэж байна. 7 дугаарт ногоон эдийн засагт шилжих шилжилтэд асар их хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдах тул төрийн санхүүжилтээр нэмэлтээр хувийн хэвшлийн санхүүжилт тэр дундаа гадаад эх үүсвэрийн хөрөнгө оруулалт хэрэгтэй байна. Энэ зохицуулалтын хууль, эрх зүйн орчныг хэзээ боловсронгуй болгох вэ гэсэн асуултууд байна?

Д.Амарбаясгалан: Мөнхбат гишүүн тодруулаад шууд яваад байж болно шүү цаг тухайд нь, 20 минутын хугацаанд асуулт, хариулт явуулах боломжтой. Одонтуяа сайд хариулт өгье. 2 микрофон хоёулаа нээлттэй байхад болно.

С.Одонтуяа: Тэгэхээр иргэний асуултад хариулъя. Манай улс ер нь би энэ бүх асуултуудын эхэнд нэг зүйлийг хэлэхэд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам яг 12 хуулийн төслийг бэлдсэн байгаа. Энэ хуулийн төслүүд саяын асуултад бүгд нэлээд том хариулт болно. Жишээлэхэд цөлжилттэй хэрхэн тэмцэж байна вэ гэдэг дээр Хөрс хамгаалах, цөлжилтөөс урьдчилан сэргийлэх тухай хууль гэж боловсруулсан байсан. Гэтэл Монгол Улсын Ерөнхийлөгч одоо бол урьдчилан сэргийлэх гэдэг асуудал байхгүй, 76 хувь нь цөлжсөн учраас шууд Цөлжилттэй тэмцэх тухай хууль болгоод оруулах нь зүйтэй гэж байгаа. Мөн сая асуусан, би түрүүн Цогтгэрэл гишүүний асуултад хариулахдаа хэлсэн. Энэ ус, цаг уурын, Ус, цаг уур орчны шинжилгээний тухай хууль, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль, түрүүн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль гээд нийт 12 хуулийн төслийг оруулж ирэх юм. Тийм учраас манай Улсын Их Хурлын гишүүд манай салбарын энэ реформ болох энэ 12 хуулийн төслийг орж ирэхэд сайн дэмжиж ажиллаж өгөөрэй гэж хүсэх гэсэн юм.

Сая 1 тодорхой асуулт асуусан. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэдэн хувийг нь энэ цөлжилт, газрын доройтлын бууруулахад ашиглаж байна вэ гээд. Тэгэхээр энэ хуулийн дагуу бид Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар газар, ус, ой, ан амьтан, ургамлын нөөц ашигласны төлбөр жишээлэхэд 24 онд нийт 283 тэрбум төгрөг болсон байдаг. Энэ 283 тэрбум төгрөг 100 хувь орон нутгийн төсөвт төвлөрч байгаа, 100 хувь орон нутгийн төсөвт. Тэгэхээр хуулиараа энэхүү орлогын дийлэнх хувийг 100 биш гэхэд 85 хувийг нь ядаж энэ байгаль хамгаалах нөхөн сэргээх, энэ буцаан байгалиа нөхөн сэргээхэд зарцуулах ёстой гэсэн ийм хуулийн зохицуулалттай байдаг хэдий ч орон нутаг энийгээ зарцуулдаггүй, 100 хувь зарцуулдаггүй. Манайх сая энэ нөөцөө хэр ашиглаж байна вэ гээд аймаг, сумдуудад нарийвчилсан аудит хийж үзсэн. Сүүлийн 3 жил үнэхээр сайжирч байгаа. Анх 20 хэдэн хувьтай байсан бол одоо энэ жилийн аудитаар 65 хувьтай овоо чамлахааргүй. Энэ нь нэмэгдээд байгаа гэсэн үг.

Тийм учраас бид энэ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг бэлдэж оруулж ирж байгаа. Ингэснээрээ яг энэ мөнгийг юунд зарцуулах юм бэ, яаж энэ газрын доройтлоос сэргийлэх юм бэ гэдгийг хийж байгаа. Ер нь улс орнууд ДНБ-ийхээ 1 хувийг ядаж энэ уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчиндоо зарцуулах ёстой байдаг. Манайх одоогоор 0,3 хувьтай байгаа. Тэгэхээр энэ дээр энэ шинэчилсэн найруулгаар бид нэлээд ахиц дэвшил гарна гэж үзэж байна. Бид аймаг, сумдууд дээр аудит хийсэн энэ нөөц ашигласны төлбөрөө зориулалтын дагуу ашиглаагүй сумдуудыг бид энэ дараа дараагийн дэмжлэгээс хасна гэсэн ийм бодолтой байгаа. Тэгэхээр заавал хамтарч ажиллаж байж, энэ олсон орлогыг нь орон нутагт эрх мэдлийг нь өгсөөр байтал эндээ зарцуулах нь зүйтэй гэж үздэг юм.

Шороон шуурганы талаар асууж байна судалгаа ямар вэ гэж. Тэгэхээр энэ цөлжилтийн төлөв байдлын үнэлгээг 5 жил тутамд хийдэг. Тэгэхээр анх 92 онд хийсэн судалгаагаар 41,3 хувь нь Монгол Улсад цөлжилт илэрсэн байна гэж үзэж байсан бол сая сүүлийн 20 оны тооллогоор бүүр 76,9 хувь нь цөлжилтөд

нэрвэгдсэн байна гэсэн ийм судалгаа байгаа. Тийм учраас энэ манай улсын хамгийн онцгой анхаарах сэдвийн нэг яах аргагүй мөн. Энэнийхээ 23 хувь нь бүүр хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлд хамрагдаж байна гэж үздэг. Энэ дээр бид олон арга хэмжээ авч байгаа нэг нь яах аргагүй Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод хөтөлбөр байгаа. Энэ Тэрбум мод хөтөлбөр энэ хүлэмжийн хийг бууруулах, шингээх дээр их чухал ач холбогдолтой ийм төсөл. Энэ нэг талаасаа ингээд мод тариад хамгаалахаасаа гадна нийт Монголчууд, ард иргэдийн дунд ер нь бид энэ байгалиа байнга нөхөн сэргээж байх ёстой юм, бүгдээрээ нэг мод тарьдаг болох ёстой юм, энэ чинь байгаль орчинд чухал ийм үйл явдал юм гэдгийг харуулахаас гадна, дэлхийн улс орнуудтай хэлэлцээр хийхэд энэ хөрөнгө мөнгө босгох ийм чухал хөшүүрэг болдог. Манай яам энэ жил 2025 оныг нэг сум нэг хөв цөөрөм гэсэн ийм санаачилгыг өрнүүлж байгаа. Тэгэхээр би Их Хурлын гишүүдийг өөрсдийнхөө 126 сум, дүүрэгт энэ хөв цөөрмийг санаачилж манлайлж хэрэгжүүлээсэй хүсэж байгаа. Яагаад гэхээр улсын төсвийн хөрөнгөөр бид хангалттай энэ зүйлийг хийж чадахгүй гэдгийг би түрүүн дурдсан.

Энэ цөлжилттэй ямар чухал ажлууд хийж байна вэ гэж. Энэ дээр нэг чухал зүйл нь юу вэ гэхээр би саяын хуулиудаас гадна Монгол Хятадын хамтарсан цөлжилттэй тэмцэх том ийм төвийг байгуулахаар газрын асуудал, бүх зургийн асуудлууд ингээд шийдэгдээд амжилттай явж байгаа. Тэгэхээр Хятадын ЗГ-аас Монгол Улсад үзүүлж байгаа буцалтгүй тусламжийн нэг том хэлбэр болж энэ дээр маш олон судалгааны ажлууд хийгдэнэ, маш олон мониторингууд энэ төвийн хүрээнд хийгдэх юм. Тийм учраас бид цөлжилтөө хэмждэг, цөлжилттэйгөө яаж тэмцэж байгаа туршлагыг тэнд таниулдаг ийм зүйлүүд болно. COP17 хурлын талаар асуулаа COP гээд тэгэхээр манайхан зарим нь ойлгохгүй байж магадгүй. Энэ дэлхийн улс орнуудад бүгдэд нь ижлээр нь нэршээд conference of the parties буюу товчлоод ерөөсөө улс орнууд COP гээд яриад явчихдаг. Сая Азербайжан, Саудын Арабд COP-ын хурлууд болсон.

Тэгэхээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс ер нь Монгол Улсад 26 оны 8 дугаар сард энэ хурлыг хийх нь зүйтэй юм. Монгол Улс энэ дэлхийн улс орнуудын чиг хандлагад орох ёстой. Цөлжилттэй тэмцэхэд Монгол Улс дангаараа хүчрэхгүй учраас дэлхийн энэ улс орнуудтай хамтрах хэрэгтэй, том, том санаачилгыг өрнүүлэх хэрэгтэй, энэ дээр хөрөнгө мөнгө босгох хэрэгтэй гэдэг үүднээс энэ хурлыг зохион байгуулахаар болсон байгаа. Энэ хурлын хүрээнд хамгийн гол сэдэв ерөөсөө энэ газар, усны нөөцийг хамгаалах, тэгээд Цөлжилттэй тэмцэх, газар гангийн асуудал, бэлчээрийн асуудлыг онцгойлон авч үзэх юм. Тийм учраас энэ COP17 хурлын хүрээнд бид олон чухал ажлыг амжуулахаар бэлтгэл ажилдаа ороод ингээд явж байгаа. Илүү юу гэлээ?

Ц.Мөнхбат: Энэ Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилт болон уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ хоорондын уялдаа холбоог ЗГ хэрхэн харж байна вэ гэсэн ийм асуудал байгаа.

С.Одонтуяа: ЗГ дээр ер нь ЗГ-ын хурлын бараг эхний хэдэн хурал дээр шийдсэн гол асуудал энэ ногоон санхүүжилтийн корпорацын асуудал сүүлийн олон жил гагцхисан, ингээд хөрөнгө оруулагч нь бид бараг мөнгөө буцааж татлаа, Монголын ЗГ энэ амлалтаа биелүүлэхгүй байна гэдэг ийм асуудал яригдсан. Энэ ЗГ-ын хурал дээр энэ шийдэгдээд одоо энэ ногоон санхүүжилтийн корпорац энэ ногоон санхүүжилт орж ирэх ийм бүх нөхцөл бүрдсэн байгаа. 2 дахь нь ЗГ-аас

өгсөн үүрэг бол Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтарч Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг би сая хэллээ ойрын үед оруулж ирнэ гэсэн байгаа. Тэгэхээр гол энэ уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр хийгдэж байгаа нэг ажил бол та бүхэн мэдэж байгаа. Энэ нэг нь яах аргагүй бид нараас хамаарахгүй хүчин зүйлүүд байдаг. Энэ дээр дасан зохицох бодлогыг ЗГ гаргасан байгаа. 2 дахь нь хүний хүчин зүйлээс хамаараад энэ уур амьсгалын өөрчлөлтийг өөрснөө бий болгоод байгаа дээр ЗГ маш олон төлөвлөгөөг гаргасан. Энэний нэг нь энэ бэлчээрийн даацтай холбоотой, малын тоо толгойтой холбоотой эрчимжүүлсэн МАА-г хөгжүүлэх, шинэ техник технологи хөгжүүлэх гэсэн ийм олон асуудлууд байгаа.

3 дахь асуудал энэ ерөөсөө ногоон эдийн засагт шилжих, уур амьсгал, энэ хүлэмжийн хий ялгарлыг нэмэгдүүлдэг энэ бүх зүйлүүдээс татгалзах гэсэн ийм зүйлүүд явж байгаа. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороон дээр энэ хүлэмжийн хий ялгарлыг бууруулах, энэ агаарын бохирдлыг бууруулах дээр маш том төлөвлөгөө гаргаад бид ажиллаж байгаа. Манай үндэсний хорооны энэ сүүлийн 3 сар ажиллаж байгаа хамгийн чухал зүйл энэ 173 том уурын зуух буюу 2262 ААН энэ түүхий нүүрс түлдэг энийг бид зогсоохоор энэ шинэчлэлийг хийхээр ингээд ажиллаж байгаа. Тэгэхээр энэ өөрөө их өргөн сэдэв. Тэгээд хамгийн гол нь бид өөрсдийн хүчинд найдахад энэ бол шийдэх боломжгүй учраас аль болохоор гадаадын зээл, тусламжийг татах, гадаадад болж байгаа энэ хурлуудад явж өөрсдийнхөө энэ төсөл хөтөлбөрийг танилцуулах гээд маш олон чухал зүйлүүдийг хийж байгаа. Тэгээд хамгийн гол нь хэлсэн энэ Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулиар нэлээд олон зүйлүүдийг хийж хэрэгжүүлэхээр болж байгаа. Ингээд салбар хоорондын уялдааг хангахгүй бол манайд маш олон байгууллага, үндэсний хороо, хөтөлбөрүүд байдаг. Энийг бол уялдаа холбоог хангах чиглэлээр гол ажиллаж байна.

Ц.Мөнхбат: Сайд энэ 20-иод асуулт байгаа. Товчхон хариулж өгөхийг бодоорой. Иргэн Батмөнхөөс Монгол орон газар зүйн байршил, эх газрын эрс тэс уур амьсгал зэргээс хамааран дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөд эрчимтэй өртөөд байгаа 10 орны нэг гэж үзэж байна. Энэ дээр судалгаа хийгдсэн юм байна уу гэж асуусан байна. 2 дугаарт Монгол Улсын хэмжээнд хэдэн аймаг нэн хүчтэй цөлжилт газрын доройтолд орж байгаа вэ? Үүнээс урьдчилан сэргийлж үр дүнгээ өгсөн ажил байна уу гэж байна. 3, энэ 2.

С.Одонтуяа: Би товчхон хариулчих уу? Дараагийнхыг нь мартахгүй. Хамгийн их энэ дулааралд нэрвэгдэж байгаа газруудыг Улаанбаатар хот, Хөвсгөл аймгийн Мөрөн сум, Сэлэнгэ аймгийн Баруунхараа сум, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумдыг жилийн бүр 3,3-аас 3,5 цельс хүртэл дундаж дулаарал нь нэмэгдэж байна гэж үзэж байгаа. Бусад газруудад 2-оос 3 цельсийн дулаан байгаа. Тэгэхээр бид олон улсын өмнө хүлээсэн үүргээр 1,5-аас хэтрүүлэхгүй байх ийм үүргийг хүлээж байгаа. Түрүүний түрүүн би та нөгөө зарим асуултад нь хариулчихсан байгаа. Нөгөө судалгааны талаар би хэлчихсэн, 5 жил тутам хийдэг гээд. Одоо бол 76,9 хувьтай. Тэгээд 30 орчим сая га талбай нь ийм цөлжилтийн хүчтэй, нэн хүчтэй юунд хамрагдсан байна гээд хариулсан.

Ц.Мөнхбат: Энэ Монгол орны нийт нутгийн 76 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртсөн байна гэж ингэж үзэж байгаа юм байна. Тэгээд үүнээс энэ хүний хүчин зүйл ер нь хэдэн хувийг эзэлдэг юм бэ гэж ингэж асуужээ. Сүүлийн 4 жил

ямар арга хэмжээ авч энэ цөлжилтийн үзүүлэлтүүдийг бууруулах тал дээр ажил хийгдсэн бэ гэж ингэж асуусан бэ?

С.Одонтуяа: Энэ манайд нэг adapt гээд төсөл их олон судалгаа хийсэн байдаг. Энэ adapt төсөл энэ Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд энэ дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох гээд энэ төслөөр судалгаа хийсэн. Энэ судалгаагаар юу гэж дүгнэсэн бэ гэхээр товчхондоо хэлэхэд Монгол Улсын энэ МAA-д учирдаг нийт эрсдэлийн хохирлын 90 гаруй хувь нь ган, зуд хосолсон ийм нөлөөлөл байна гэж үздэг. Тэгэхээр бид энэ малыг олноор хорогдуулдаг энэ гамшигт үзэгдлийг урьдчилан бэлтгэх, аль болохоор энэ байгалийн гамшигт үзэгдлээс бэлтгэлтэй байх, урьдчилан сэргийлэх гэсэн ийм зүйлүүд дээр нэлээд анхаардаг. Тийм учраас энэ ган, зудын хосолмол нөлөөлөл нь хамгийн их нөлөө үзүүлж байна гэж үздэг.

Тэгээд нэг тоо хэлье. Энэ хонин толгойд шилжүүлснээр Монгол Улс энийг 110 сая орчим толгой малтай байна гэж үздэг. Энэний 35 саяар тоо толгой энэ бэлчээрийн даацаасаа хэтэрсэн байна гэж судалгаагаар гарсан байгаа. Тийм учраас энэ бид бэлчээрийн асуудал энийгээ тодорхой хэсгийг нь эрчимжсэнд шилжүүлэх, хослуулах тэгээд энэ аль болохоор энэ техник технологийн дэвшлийг хослуулах зэрэг ийм зүйлд орохгүй бол яг одоо байгаа уламжлалт МAA-гаар энэ манай цөлжилтийн асуудал улам нэмэгдэнэ, хуурайшилт улам нэмэгдэнэ гэсэн ийм судалгаанууд байна.

Ц.Мөнхбат: Говийн бүсээс сонгогдсон гишүүний хувьд нэг асуулт асуучихъя. Энэ усны төслийн нэгжийг байгуулах ажил ямар хэмжээнд явж байгаа вэ? Энэ ажлыг эрчимжүүлэх талаар манай Байгаль орчин, уур амжилтын өөрчлөлтийн яам маань ямар санаачилга гаргаад ажиллаж байна вэ гэдэг энэ асуулт. Монгол Улсын ЗГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Хэрлэн-Тоонот, Орхон-Онги гээд усны төслүүд байгаа. Энэ төслүүд маань ямар шатанд явна вэ гэдэг асуултыг асууя.

С.Одонтуяа: Минут нь байна уу?

Ц.Мөнхбат: 5 минут байна.

С.Одонтуяа: ЗГ-ын хамгийн гол зорилтуудын нэг тэргүүлэх чиглэл яах аргагүй говийн бүсийн усан хангамжийн асуудал байгаа. Тэгэхээр энэ жил 25 оны төсөвт нэлээд төсөв, бага хэмжээний төсөв батлагдсаны дийлэнхийг нь говийн бүсийн усан хангамжийг сайжруулахад бид зарцуулж байгаа. Нэг жишээ хэлэхэд говийн бүсийн хот суурин газрын усны чанарт үнэлгээ хийх ажил нийт 44 сумд хийгдэхээр энэ төсөв батлагдсан байна. Мөн энэ говийн бүсийн гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг өргөжүүлж усны нөөцийн тархалтыг тогтооход тодорхой мөнгө хөрөнгө тавиад ингээд явж байгаа. Тэгэхээр хамгийн гол нь бид говьд усгүй гэдэг. Гэтэл нийт Монгол Улсын газар нутгийн 17 хувь нь л энэ усны хайгуул хийгдсэн байдаг учраас энэ усны хайгуул дээр онцгой анхаарах шаардлагатай. Хэрлэн-Тоонот төслийн хувьд ТЭЗҮ нь хийгдэх шатдаа ороод Мон гидро геологи билүү компани шалгараад энэ ТЭЗҮ нь энэ 25 оны төгсгөлд дуусна гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа. Тийм учраас энэ ТЭЗҮ батлагдангуут бид энэ Хэрлэн-Тоонот асуудлыг хэрхэн яаж хийх вэ гэдэг ийм зүйлийг ярьж байна.

Орхон-Онги төслийг бид их олон жил ярьсан. Энэ дээр Орхон-Онги дээр Орхон голын асуудал бол Хархорум том хот байгуулахтай холбогдуулж бид Орхон голын асуудлыг түр хугацаагаар хүлээгдэж байгаа гэж хэлж болно. Тэгэхээр өнгөрсөн 7 хоногт Гантөмөр сайдаар ахлуулаад манай ажлын хэсэг ер нь энэ Онги голоос бид ус татаж Улаан нуураа сэргээх ямар ч байсан экологийн төслөө.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 20 минутад асуулт, хариулт явагдаж дууслаа. Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг асуулт асууна.

М.Ганхүлэг: Баярлалаа. Нийт хугацаа нь ямар байх билээ, тийм үү? Цахим өргөдөл хүсэлтээр 5 иргэний 19 асуулт ирсэн байгаа сайд. Тэгэхээр хоёулаа нэлээн товчхон, товчхон хариулаад явах нь зөв байна. Иргэн Будсүрэнгийн асуултаас эхэлье. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам шинээр байгуулагдсан цагаас хойш уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар олон нийтэд мэдлэг ойлголт өгөх чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байна вэ гээд нэлээн тодорхой асуултыг асуусан байна. Цаг агаарын гамшигт болон аюултай үзэгдлийг урьдчилан илрүүлэх, эрт сэрэмжлүүлэх талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байна вэ гэж байна. Урьдчилан сэргийлэх чиглэл дээр. Цөлжилт, газрын доройтлын бодлого, эрх зүйн орчныг сайжруулах талаар хийгдэж байгаа ажлууд байна уу гэдэг дээр ерөнхий багц хууль орж ирж байгаа юм байна. Энэ дотроо Бэлчээрийн тухай хууль бусад энэ гол хуулиуд нь ямар байгаа вэ гээд нэг жоохон дэлгэрүүлээд хариулаад өгөөч. Уур амьсгалын өөрчлөлт биологийн олон янз байдалд хэрхэн нөлөөлж байгаа вэ гэсэн 4 асуултыг иргэн Будсүрэн асуусан байна.

Д.Амарбаясгалан: Одонтуяа сайдын микрофоныг өгье.

С.Одонтуяа: Би хариулъя, манай яамныхан зарим хуулийн дэлгэрэнгүй мэдээллийг өгөөрэй. Энэ цаг агаарын гамшигт үзэгдлийг урьдчилан сэрэмжлүүлэх талаар ямар ажил хийж байна вэ гэж. Энд бид нэг хэд хэдэн радар энэ станц суурилуулах ажлыг уг нь 25 оны төсөвт суулгасан байсан юм. Харамсалтай нь энэ нөгөө төсвийн нөгөө юугаар тандалтаар хасагдчихсан байж байгаа. Тэгэхээр бид энэ 23 онд л нэг Чингэлтэйн ууланд улсын төсвийн хөрөнгөөр нэг радарын станц суурилуулаад ингээд ашиглаж ажиллаж байсан. Одоо бол нийт улсын нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан ийм доплерын эффект бүхий цаг уурын радарын станцын сүлжээ байгуулах нь чухал юм гэдгийг ойлгож байгаа. Ингээд энийг хэрвээ бид ингээд улсын төсвөөр шийдээд тавьчихвал энэ өөрөө маш чухал баримтууд мэдээллийг бид нарт өгөх юм. Нийт 150-аас 400км-ийн радиус дотор бүх энэ үүлний байршил, шилжилт хөдөлгөөн гээд л энэ бүх зүйлийг хийх боломжтой болох юм.

Нэг зүйлийг хэлчихье. Өнгөрсөн 7 хоногт та мэдэж байгаа байх энэ Улаанбаатар хотод муухай үнэр гараад байна гэсэн ийм зүйлүүд яригдсан. Манайд яг энэ агаарт юунаас болоод, ямар бодисоос болоод энэ үнэр гараад байна гэдгийг тодорхойлдог багаж байдаггүй юм байна лээ. Ингээд өнгөрсөн ЗГ-ын хурал дээр хүсэлт гаргаад энэ багажийг Улаанбаатар хотод авъя, ингэж байж бид юунаас болоод байгаа гэдэг асуудлаа та яах юм байна тодорхойлох юм байна гээд Ерөнхий сайд дэмжээд энэ асуудал шийдэгдэхээр болж байгаа.

Олон нийтийн мэдлэг гэхээр энэ жил Наранбаяр сайдын яамтай хамтраад бид 9 дүгээр сарын 1-нээс энэ хүүхэд, залуучуудад энэ мэдлэг олгох энэ ажлыг эхэлсэн. Энэ дээр хэд хэдэн төрийн бус байгууллагууд байдаг эд нартай хамтраад улс орон даяар энэ мэдлэг мэдээллийг өгч байгаа. Одоогийн байдлаар нийт 400 сургуулийн 900-гаад мянган хүүхдэд энэ мэдлэг мэдээллийг олгосон. Энийгээ цахим платформыг бид байгуулаад хүүхдүүд энэ дээр цахим платформ дээр ороод асуулт асуудаг, хариулдаг ийм зүйлүүд байгаа. Үлдсэнийг нь юу яам нэмээд хариулчих уу? Ажлын хэсгээс.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 10 дугаар микрофон өгье.

Ц.Уртнасан: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Шинэ ЗГ зохион байгуулагдаад Байгаль орчин, уур амьсгалын яамыг шинээр зохион байгуулсан. Яамны эрхэм зорилгыг энэ уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах ийм чадамжтай улс үндэстэн болно гэдэг ийм эрхэм зорилгын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох энэ хөтөлбөр, арга хэмжээнүүдээ хэрэгжүүлээд ажиллаж байгаа. Ер нь та бүхний ярьж байгаа энэ уур амьсгалын өөрчлөлтөд хүний үйл ажиллагаанаас хамаарч байгаа энэ үйл ажиллагааг зохистой байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох ийм арга хэлбэрт шилжүүлэхийн тулд олон нийтийн хандлага, соёлыг өөрчлөх энэ чиглэл дээр яам нэлээн анхаарч ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд ерөнхий боловсролын бүх шатны сургуулиуд, техник мэргэжлийн сургуулиудын сургалтын хөтөлбөрт уур амьсгалын өөрчлөлтийн сургалтын хөтөлбөрийг оруулахаар боловсролын байгууллагуудтай хамтраад энэ ажил хийгдээд явж байна.

Мөн бүх шатын сургалтын байгууллагын хичээлийн байранд Уур амьсгалын өөрчлөлт ба Монгол гэдэг ийм сургалтын танхимыг байгуулах хэлбэрээр бүх шатын боловсролын байгууллагуудад энэ уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох ийм чадамжийг нэмэгдүүлэх ийм хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилт тавьж байна. Улсын Их Хурлын эрхэм гишүүд, улс төрчдийн хувьд энэ манай яамтай хамтарч ажиллаад энэ олон нийтэд ийм уур амьсгалын өөрчлөлтийг нөлөөлөхүйц ийм арга хэмжээнүүдийг манлайлал үзүүлээд оролцоход бид яамны зүгээс мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж хамтарч ажиллачихад бэлэн байна. Баярлалаа.

М.Ганхүлэг: Хуулийн төслүүд дээр нөгөө гол 16 гэдэг дээр гол хуулиуд нь ямар хуулиуд байна вэ? Бэлчээрийн хамгааллын тухай хууль орж байна уу?

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Ц.Уртнасан: Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар бид Парисын хэлэлцээрт нэгдээд нийгэм, эдийн засгийн олон салбарууд дээр энэ үндэсний хувь нэмрийг тодорхойлоод, салбар бүр дээр энэ уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө нарийвчилсан зорилтуудаа тодорхойлсон байгаа. Тийм учраас энэ салбар хоорондын бодлого, зохицуулалтыг уялдуулах замаар энэ уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг сааруулах, дасан зохицох энэ чадамжийг сайжруулах чиглэлээр энэ

эрх зүйн зохицуулалт, хуулийг бий болгох, олон улсын нийтлэг стандартуудыг бий болгож мөрдөх энэ зохицуулалтуудыг бэлтгэл ажил хийгдээд явж байна.

Д.Амарбаясгалан: Одонтуяа сайдын микрофоныг өгье.

С.Одонтуяа: Нийт 12 хууль байгаа. Энэ дээр Бэлчээрийн тухай хууль гэж тусдаа хууль байхгүй. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас энэ хуулиудад өөрчлөлт оруулах байх. Манай энэ Хөрс хамгаалах, цөлжилтийг бууруулах тухай хууль дээр яах аргагүй л яг саяын таны хэлдэг энэ бэлчээрийн асуудал яах аргагүй яригдана. Тэгэхээр бид нөгөө олон жил явсан уламжлалт нүүдлийн МАА энэ бэлчээрийн даац хэтэрсэн энэ дээр яах аргагүй энэ хууль дээр ингээд нэг тулж л таарцгаах байх. Тэгэхээр энэ дээр бид энэ яг уур амьсгалын өөрчлөлт манай улсад ямар байгаа билээ, цөлжилт ямар байгаа гэдгээ сайн мэдрээд энэ хууль дээр энэ бэлчээрийн асуудал дээр бид их онцгой анхаарч ажиллах байх ёстой байх Улсын Их Хурлын гишүүд гэж үзэж байгаа. Нийт 12 хуулийн хамгийн чухал хууль бол түрүүн би хэлсэн энэ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль энэ бүүр шинэчилсэн найруулга орно, Усны тухай хууль орно, Амьтны тухай хууль, Ойн тухай хууль бүүр шинэчилсэн найруулга, Байгалийн ургамлын тухай хууль гээд, сая та асуусан энэ Биологийн олон янз байдлаа хэрхэн яаж зохицуулах юм бэ гээд энэ бүх хуулиудаар зохицуулна.

Тэгээд манай орны хувьд ер нь энэ нэг улаан дансны зэрэглэлд орсон 2000 орчим зүйл ургамлыг үнэлэхэд 60 нь устаж байгаа нь 60, устаж болшгүй 192, эмзэг 364, ховордож болзошгүй 206 зүйл ургамал байна гэж үздэг. Тийм учраас бид энэ аюул учраад байгаа энэ зүйлдээ их бодолцож энэ байгаль орчноо хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтдөө анхаарахгүй бол сүүлдээ эргээд зөвхөн юу гэдэг юм эдийн засаг, эдийн засаг гээд явж байтал бид энэ байгаль орчинд маш том сорилт тулгарах ийм асуудал ирнэ. 2050 он гэхэд Монгол Улсад бүх энэ мөстлөг мөсөн уул хайлна гэсэн ийм судалгаа байдаг. Тэгэхээр бид асар их усны хомсдолд орох ийм зүйлүүд байгаа. Тэгэхээр бид энэ Байгалийн нөөц ашигласны төлбөр, Усны тухай хуулиудаа шинэчилж оруулж ирэх гэж байгаа.

М.Ганхүлэг: Иргэн Оюунтуяагийн асуултыг би танилцуулъя. Цөлжилтөд нөлөөлж буй гол хүчин зүйл болох бэлчээр, малын тоо толгойн талаар ямар бодлого барьж байна вэ гэсэн байна. Цөлжилт нэмэгдэж байгаа бодит судалгаа ер нь яг ямар судалгаа дээр үндэслэж байна, манай газар нутаг уур амьсгалын онцлог нөлөөлөл нь ямар байна вэ? Илүү нарийвчлаад бэлчээрийн газрын чанарын хянан магадалгааг бид 5 жил тутам хийх ёстой ийм тодорхой хуулиар зохицуулсан байх ёстой. Авсан мэдээллээр 2010 онд бид бүхэн хамгийн сүүлийн судалгааг хийгээд түүнээс хойш ерөөсөө энэ чанарын хянан магадалгааг огт хийгээгүй байгаа ийм мэдээлэл байна. Тэгэхээр энэ чиглэлийн судалгаа мэдээллүүдийг яаж хийж байна вэ? Энэ хянан магадалгааг хэзээ хийх вэ гэдэг асуулт.

С.Одонтуяа: Би түрүүн нэг дурдаад өнгөрсөн. Энэ манай улс энэ 24 оны тайлангаас үзэхээр хонин толгойд шилжүүлснээр 110 сая толгой мал байна гэж үздэг. Энэнээс 36,4 саяар хэтэрсэн байна гэсэн ийм судалгаа байгаа. Тийм учраас бид энэ нөгөө байгалийн ургамлыг нөхөн төлөх боломжийг хязгаарлаж энэ

бэлчээр талхлагдах үндсэн нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзэж байгаа. Тийм учраас бид энэ МАА-н түүхий эдээ бүрэн ашиглах, ашиг шим өндөр ийм технологид шилжүүлэх, даацтай нийцсэн мал сүргийг бий болгох нь зайлшгүй чухал юм гэж үздэг. Түрүүн би нөгөө судалгааг нэг хэд хэдэн удаа хэлсэн. Энэ бол цөлжилт, газрын доройтлын судалгааг 5 жил тутамд хийдэг. Ингээд сая хамгийн сүүлд 20 онд хийсэн судалгаагаар 76,9 хувь гээд ингээд гарсан байгаа.

М.Ганхүлэг: Иргэн Сарантуяагийн асуулт. Уур амьсгалын өөрчлөлтөөс МАА, газар тариалангийн салбарт үзүүлж байгаа нөлөөллийг судалж үзсэн үү гээд ерөнхий агуулга нь давхардаж байна. Дээр нь газар тариалангийн энэ асуулт нэмэгдэж байна. Тэгэхээр та газар тариалантай холбоод, уур амьсгалын өөрчлөлтөөс болж хамгийн их дулааралт болж байгаа газар хаана, хаана байна вэ гэж асуучихсан байна.

С.Одонтуяа: Яам хариулах уу? Даргаа ажлын хэсгийн микрофоныг өгье.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон өгье.

Х.Мөнхзул: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Мөнхзул. Монгол, энэ цөлжилтөд нөлөөлж буй гол хүчин зүйл бол бэлчээр малын тоо толгойн талаар болохоор чинь манай улсын нутаг дэвсгэрийн 70,7 хувийг бэлчээрийн талбай эзэлж байгаа. Энэний 69 хувь нь доройтолд өртсөн тухай судалгааны дүн байгаа. Бэлчээрийн нийт талбайн хэмжээ сүүлийн 50 гаруй жилд 20 орчим хувиар буурч байгаа. Эсрэгээр малын тоо толгой 30 жилд 3 дахин өссөн. Монгол орон 80 сая гаруй хонин толгой бэлчээрийн даацтай. Гэтэл энэ тоо өнөөдөр 110 саяд хүрч байгаа. Малын сүргийн 40 хувийг ямаа эзэлж байгаа гэсэн ийм тооцоолол гарч байгаа. Яг энэ цөлжилтөд нөлөөлж байгаа гол хүчин зүйл дээр бид онцгой анхаараад эхний ээлжид энэ малын тоо толгойгоо бэлчээрийн даацтай нийцүүлж зохистой түвшинд барих ёстой барих ёстой юм байна гэсэн. Ийм 2-т нь сүргийн бүтцийг оновчтой болгох шаардлагатай гээд, тэгээд Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хууль дээр энэ талын нэг хязгаарлалттай зохицуулалтыг бид хэд боловсруулж явж байгаа. Удахгүй өргөн барина.

М.Ганхүлэг: Газар тариалантай холбогдолтой, тариалангийн салбарт яаж нөлөөлж байна вэ?

С.Одонтуяа: Энэ түрүүн хэд хэдэн иргэд асуусан байсан. Энэ шороон шуурганы нэлээд шороон шуурганы асуудал нэлээд ноцтой болж байгаа. Тэгэхээр бид энэ СОР-ыг угтаж энэ шороон шуургатай тэмцэх талаар энэ олон улсын эвсэл санаачилгыг байгуулаад ажиллахаар бэлтгэл ажлаа хийж байгаа. Тэгэхээр өнгөрсөн жил Энхбаяр сайдын яамтай манай яамны хамтарч хийсэн нэг ажил энэ газар тариалангийн бүс нутгийг тойруулаад бид мод тарих ажлыг нэлээд сайн хийсэн ойжуулалтыг. Тэгэхээр бол энэ нэг сумаар олон туулай буудаж байна гэсэн үг. 1 дүгээрт модоо тарьж байгаа, 2 дугаарт энэ мод маань усалгаатай байна, эзэнтэй байна, хашааг тухайн газар тариалангийн компаниуд бариад ингээд ийм хосолмол ийм зүйлийг хийж байгаа. Энэ төсөл амжилттай явсан. Энэ жил бид энэ газар тариалангийн бүсийг тойруулж ойжуулах ажилд нийт 702 сая төгрөгийг төсөвлөсөн байгаа. Тэгэхээр энэ яг энэ хөрсийг хамгаалах энэ шороон шуурганаас сэргийлэхэд их чухал үүрэгтэй болж байгаа.

М.Ганхүлэг: МАА-н салбар энэ уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, газрын доройтлоос хамгийн их хохирч байгаа бүлэг бол малчдын бүлэг байгаа. Энэ чиглэл дээр би ганц нэгэн асуултыг нэмээд асууя. Малчдыг яг мэдлэгжүүлэх нь энэ уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээ авах хамгийн зохистой ажлуудын нэг болов уу гэж ингэж харж байгаа. Зөвхөн малчид болон иргэдийг. Ялангуяа иргэд энэ Тэрбум мод хөдөлгөөнд нэгдэх, малчид бэлчээрээ хамгаалах энэ чиглэл дээр мэдлэгжүүлж оролцоог нь дэмжих энэ чиглэлийн ажлуудыг бид бүхэн цаашдаа нэлээн голчилж анхаарах учиртай. Тэгэхээр энэ үндсэндээ хөрс хамгаалал, бэлчээр хамгааллын асуудал, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал зөвхөн төрийн гэхээсээ илүүтэй олон талт энэ хамтын ажиллагааны ийм үр дүнд үр дүнгээ өгнө гэж ингэж харж байгаа. Тэгэхээр энэ чиглэл дээр илүү нарийвчлаад яг энэ хариу арга хэмжээ авч ажиллаж байгаа мод тарьж байгаа, мөн бэлчээрээ хамгаалж байгаа иргэд, малчдыг дэмжих чиглэлээр хэдүүлээ ямар ажлуудыг хийсэн бэ, хийж болох вэ гэдэг дээр илүү нарийвчлаад асууя.

Д.Амарбаясгалан: Ажлын ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Ц.Уранчимэг: Гишүүний асуултад хариулъя. Яг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас маш олон төслүүд Хөдөө аж ахуйн яамтай хамтран хэрэгжүүлж байгаа. Энэ төслийн хүрээнд яг бэлчээрийн нөхөн сэргээлтийг байгалийн ургамлын аргаар нөхөн сэргээх, ялангуяа малчдын ногоон тэжээл бэлтгэх ажлыг төслийн хүрээнд яг төслийн хэрэгжиж байгаа аймгууд баруун буюу зүүн бүсэд тодорхой үйл ажиллагааг зохион байгуулж байгаа. Мөн говийн аймгуудад загийн ойг нөхөн сэргээх ажлыг малчдын нөхөрлөл, малчдын бүлгэмээр дамжуулж хамтарч зохион байгуулж байгаа. Мөн хөв цөөрөм байгуулах ажлуудыг хийж байна. Тэгэхээр яг энэ 2020 онд баталсан Бэлчээрийн хууль дээр нэг тодорхой заалт орсон байдаг. Малын тоо толгойн албан татварын тухай хуулиар малын тоо толгойд төлбөр ноогдуулж эхэлсэн. Тодорхой хэмжээгээр яг энэ ойлголтыг нэмэгдүүлэх хөшүүргийг бий болгох ажлыг хийсэн. Тэгэхээр малчид маань чанартай малыг бий болгож хурганы малыг борлуулж зарах махыг нь бүтээгдэхүүн болгож гаргах ажлыг Иншур төслийн хүрээнд маш амжилттай хийгээд мөн нэн ховор, ховор ургамлыг тарималжуулах ажлыг энэ төслүүдийн хүрээнд маш амжилттай зохион байгуулж энэ малчны нөхөрлөл, амьжиргааг дээшлүүлэх ажил дээр тодорхой ажлуудыг хийгээд явж байгаа.

Цаашид яг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, бэлчээрийн уламжлалт МАА тоо толгойн зөв зохистой үйл ажиллагааг зохион байгуулах тал дээр сургалт сургалтуудыг Хөдөө аж ахуйн яамтай хамтарсан төслийн хүрээндээ бол зохион байгуулаад сургагч багшийг малчдын бүлгээс нь бэлтгэж байгаа ийм ажлуудыг зохион байгуулж байгаа.

М.Ганхүлэг: Энэ дээр нэмэлтээр би саналаа хэлчихье гэж бодож байна. ХХАА-н салбарт 7 төрлийн урамшууллыг олгож байгаа. Газар тариалангийн үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдэд үндсэндээ бордооны урамшуулал гэж 30 хувийг үндсэндээ бордоо, хөрс, бордоо худалдаж авсан тохиолдолд 30 хувийг нь үндсэндээ буцаан олгож байгаа. Малчдад зориулаад үндсэндээ ноосны урамшуулал, арьс ширний урамшуулал, сүүний урамшуулал гээд нэлээн хэд хэдэн урамшууллуудыг олгож байгаа. Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгч нарт зориулаад тонн тутамд 100 мянган төгрөгийн урамшууллыг өгч байгаа. Тэгээд гол

санаа нь цаашдаа энэхүү урамшууллын тодорхой дэмжлэгүүдийг бэлэн мөнгөөр бус яг энэ хөрс хамгаалал, бэлчээр хамгааллын энэ чиглэл рүү үндсэндээ зориулах чиглэлээр манай Их Хурлын гишүүд, ЗГ-ын сайдууд маань анхаарал хандуулах нь зөв болов уу гэсэн энэ саналыг би протоколд тэмдэглүүлээд, та бүхэн маань цаашдаа илүү ажил хэрэг болгоосой гэж ингэж бодож байна.

Саяын сайдын хэлж байгаа санал дээр экспортын үйл ажиллагааг тасалдуулахгүй гэдэг зорилго аль, аль яам, ЗГ-ын мөрийн хөтөлбөрт байгаа. Гэсэн хэдий боловч бодит байдал дээр бид бүхэн энэ зорилтоосоо ухарсан алхмуудыг нэлээн хийгээд байгаа юм. Тэгээд экспортыг тодорхой тоонд хязгаарлах, квот олгохтой холбогдолтой асуудлуудыг нэлээн дэвшүүлээд байгаа. Тэр утгаараа энэ чиглэл дээр яг тогтвортой, нэгдсэн байр суурьтай байж, цаад агуулгаараа энэ чинь эдийн засгаас гадна уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг томоохон хариу арга хэмжээ болж байгаа учраас ЗГ нэгдсэн байр суурьтай байгаасай. Малчдын амьдрал ахуйг үндсэндээ гол бүрдүүлж байгаа махны экспорт, түүхий эдийн экспортыг ахиулах нэмэгдүүлэх тал руугаа л бид бүхэн явах ёстой юм гэсэн энэ саналыг хэлмээр байгаа юм.

3 дахь нь малын хөлийн татвар. Малжуулах хөтөлбөрийг малын индексжих үндсэндээ бэлчээрийн даацтай уялдуулж хийх тал дээр ямар байдалтай ажиллаж байгаа вэ? Тэгээд энэ чиглэлийг цаашдаа нэлээн шинжлэх ухааны үндэслэлтэй явуулах талаар анхаарах нь зөв юм гэсэн ийм саналуудыг нэмэлтээр та бүхэн маань анхаарч ажиллаарай гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авлаа. Ингээд үдээс хойших нэгдсэн хуралдаан дээр Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо.

14.59 цаг

*Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,
Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны
хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын
хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан /үргэлжлэв/*

Дараагийн асуудалд орёе. Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 24 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Монгол Улсын хөгжлийн 24 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан аудитын тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд үргэлжлүүлэн асуулт асууж, үг хэлнэ. Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл асуулт асууж, үг хэлнэ.

Б.Мөнхсоёл: Сайд нар нь хаачив гэнэ Батчимэг гишүүн? Сайд нар ба Мөнхсоёл гээд сууж байгаа юм биш үү гэдэг шиг. Сайн байцгаана уу, дахиад сайн байцгаана уу гээд. Энэ асуудлыг яах вэ Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтраад хэлэлцсэн. Тэгээд тухайн Байнгын хорооны хурал дээр нэлээн асуусан, үг хэлсэн байгаа. Тэгээд энэ чуулган дээр хэлэх гэсэн санаа ерөнхийдөө бид бүх гишүүд энэ юун дээр гол асуудал тулгамдаад байгаа, цаашид юу анхаарахыг ер мэдсэн гэж бодож байгаа. Зүгээр

миний хэлэх гэсэн санаа зарим тохиолдолд аливаа хурлуудыг илүү чанаржуулах шаардлага байна уу даа гэж харж байна. Өөрөөр хэлбэл тухайн хурлыг хэн удирдаж байгаагаас хамаараад байгаа ч юм шиг илүү чанар асуултын хариултыг чанартай авах хэрэгцээ шаардлага зарим тохиолдолд байна. Чуулган дээр ажиглаж байхад Их Хурлын дарга нэлээн хариултыг шаардаж хэлүүлж байгаад талархаж байна.

Нэгэнтээ бид ард иргэдээ төлөөлөөд сонгогдоод гараад ирчихсэн юм чинь энэ үнэлгээний асуудал дээр гишүүд бид хариуцлагатай хандах ёстой буюу үүрэгтэй оролцох ёстой юм гэдэг дээр энэ Үндэсний аудитын газрын ялангуяа гаргасан энэ гүйцэтгэлийн тайлан дээр хийсэн зөвлөмжийг шууд гол агуулгыг хэлчихье гэж бодож байна. 1 дүгээрт нь бид өөрсдөө улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон тухайн жилийн төсвийн тухай хуулийг батлахдаа тэдгээрийн хоорондын уялдаа нийцлийг анхаарах ёстой байна. Өөрөөр хэлбэл гишүүд бид зөвхөн ЗГ-аас нэхээд суух биш, өөрсдөө тухайн жилийн төлөвлөгөө, тухайн жилийн төсвийн тухай хуулийг батлахдаа уялдуулах, ач холбогдол агуулгыг нь анхаарах ёстой юм байна. Энийгээ сайн мэдэж ажиллах ёстой байна бид өөрсдөө.

Дараагийн нэг асуудал анхаарах ёстой бидний хариуцах ёстой ажил бол хөгжлийн бодлогын баримт бичигт төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд үндэслээгүй эсвэл аливаа судалгаа тооцоолол хийгээгүй тийм арга хэмжээг Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатад нэмж, Төсвийн тухай хуульд нэмж оруулж баталдгийг болиулах хэрэгтэй. Бас нэг анхаарах ёстой зүйл юу вэ гэхээр Монгол Улсыг хөгжүүлэх энэ 5 жилийн үндсэн чиглэлд туссан арга хэмжээг хугацаанд нь биелүүлээгүй хэрэгжүүлэгч байгууллагын удирдлага буюу төсвийн ерөнхийлөн захирагчид тооцох хууль, эрх зүйн зохицуулалт, шалгуурыг тодорхой болгож, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцдог болох. Энэ 3 дээр гишүүд бид өөрсдөө маш их анхаарал хандуулж, өөрсдөө хариуцлагатай ажиллах ёстой юм байна гэдгийг зориулаад хэлчих гэсэн юм.

2 дугаарт нь би зүгээр санаа зовж байгаа юм бол гишүүд бид шүүмжлэхийн төлөө шүүмжлэх биш, яаж энэ ЗГ-тай харилцан хамтын зөв ажиллагаатай байж, энэ улс эх орноо хөгжүүлэх вэ гэдэгт санаа бодлоо чилээх ёстой юм болов уу? Энэ Аудитын газрын гаргасан 2 тайлангаас л харахад жишээлбэл Засгийн газраас өөрсдийнхөө хийсэн ажлыг зөв сайн харуулж чадахгүй байгаа ийм асуудал байна. Яагаад вэ гэхээр үнэлгээнийхээ аргачлалаас аргачлалд орсон тэр чанарын асуудлуудаас болоод байна гэж ойлгож байна. Тэгэхээр энэ дээрээ ЗГ өөрөө ажиллах, мөн бусад Үндэсний аудитын газар гэж байна, Хэрэг эрхлэх газраас гадна, Улсын Их Хурлын Тамгын газар гээд энэ яг аудит хийж байгаа, хяналт үнэлгээг хийж байгаа газруудтайгаа координаттай уялдаа холбоотой ажиллах ёстой юм байна гэдгийг зориуд хэлмээр байгаа юм.

Тэгээд 3 дугаарт нэг хэлэх юм юу вэ гэхээр хэлэлцэх хугацаа богино байна гэж харж байна. Энэ чинь нэг газрын гаргасан тайлан гэхэд л жишээлбэл 2 тайлан нийлээд 100-гаад хуудас 80 гаруй хуудас. Энийг уншаад энэ дотор чинь асар их мэдээлэл байгаа байхгүй юу. Тэгэхээр саар ч юм байна, шүүмжлэлтэй ч юм байна.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баатаржавын Мөнхсоёл гишүүн санал хэллээ. Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

П.Батчимэг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдрийн энэ чуулганы хуралдаанаар 3 чухал асуудлуудыг хэлэлцэж хэрэгжилтийн явц, үндсэн чиглэл, мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны хөтөлбөр энэ асуудлуудын хэрэгжилтийн явц ямар байгаа, ер нь үр дүн тайлан энэ бүгдийг сонсож гишүүд нэлээн олон асуулт асууж, санал хэлж байх шиг байна. Ер нь өчигдөр Их Хурлын дарга хэлсэн тийм ээ, ер нь асуудал танилцуулж байгаа энэ сайд нар чиг үүргийн сайд нар энэ дээр сууж асуултад хариулж байгаарай гэсэн. Өнөөдрийн байдлаар үдээс хойш болоод хурал нэг жоохон задгайрч ингэж гишүүд ч цөөхөн байна, тэгээд сайд ч цөөн тал руугаа л ороод ирлээ дээ.

Тайлан, 3 янзын тайлан үнэлэлт дүгнэлт орж ирсэн. Эдийн засгийн байнгын хороо болон Төрийн байгуулалтын байнгын хороогоор хамтарсан хуралдаанаар нэлээн олон асуудлуудыг ярьсан. Өнөөдөр би 2 асуулт асууя гэж бодож байгаа. Сангийн яам сайд маань байна уу, үгүй юү? Энэ бизнес хөрөнгө оруулалтын орчин, татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх зорилтын энэ 3.2.1.4 дээр бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах бодлого баримтална гэсэн байгаа юм. Энэ зорилтын хэрэгжилт нь өнөөдөр 70 хувьтай харьцангуй ингээд хэрэгжилтийн явцыг харахаар 70 гэдэг өндөр тоо. Тэгэхээр миний сонирхол татаад байгаа асуудал энэ ХХОАТ-ын хуульд өөрчлөлт орсон юм уу? Өөрөөр хэлбэл хуульд заасан татварын хэмжээ буурч чадсан юм уу? Эсвэл одоо хэрэгжиж байгаа энэ ХХОАТ-ын 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасны дагуу жилийн 36 сая төгрөг хүртэлх цалингийн орлоготой иргэдэд нь жилд 240 мянган төгрөгийн энэ хөнгөлөлт үзүүлээд байгаа энэ нь татварыг иргэдийн татварын ачааллыг бууруулаад байгаа юм уу? Татварын хөнгөлөлт үзүүлээд байгаа гэж энэ 240 мянган төгрөгөө Сангийн яам ер нь үзэж байгаа юм болов уу?

Тэгээд ингээд тооцоолоод би сонирхлын үүднээс тэгээс нэг хэдэн шатлал гаргачихсан байгаа юм. Энэ нь болохоор албан татвар нөгөө хувь хүний орлогын албан татварын 2020 оноос хойш хэрэгжиж байгаа энэ хуульд нэг ийм шатлал гаргачихсан байгаа юм 6. 0-6 6 сая хүртэлх цалинтай иргэд гэж байгаа. Энийг ингээд бодоод үзэхээр сард 500 мянган төгрөгийн цалинтай иргэд. Энд 240 мянган төгрөгийн энэ татварын хөнгөлөлт гэдэг юм нь хамаарч байгаа юм. Тэгээд өнөөдөр яг Монголын нийгэмд 500 мянган төгрөгийн цалинтай иргэд, ер нь ААН хувийн байгууллагад байдаг юм болов уу? Яг хэд байдаг юм бол? Энэ хөнгөлөлтийг эдэлж чадаж байгаа 500 мянган төгрөгийн цалинтай иргэд. 6-аас 12 сая төгрөгийнх энэ нь сая төгрөгийн орлоготой иргэд 216 мянга, 12 саяас 18 сая хүртэл 192 мянга сая 500 мянган төгрөгийн хэрвээ орлоготой байх юм бол, хамгийн сүүлд 30 саяас 36 сая хүртэл гээд сарын 3 сая төгрөгийн орлоготой иргэн хүн жилдээ 120 мянган төгрөгийн хөнгөлөлт авна л гэсэн үг. Тэгэхээр тэрийг сард хуваахаар сард ерөөсөө 10 мянган төгрөг шүү дээ. Өнөөдөр 3 сая төгрөгийн жилдээ орлоготой иргэн ерөөсөө л 120 мянган төгрөгийн хөнгөлөлт эдлээд л сард аравхан мянган төгрөгийн хөнгөлөлт авч байгаа.

Өнөөдөр 10 мянган төгрөг гэдэг чинь юу билээ. Зүгээр л энэ Ордны өдрийн хоол чинь 14900 шүү дээ. Тэгээд ийм харьцангуй юм явж 500 мянган төгрөгийн орлоготой иргэд нь 240 мянган төгрөгийн хөнгөлөлт авчхаад л сард 20 мянган төгрөгийн хөнгөлөлт авч байна. Энийг Сангийн яам нэг тодорхой хариулаад өгөөч. Энийгээ татварын хөнгөлөлт гээд байгаа юм уу? Иргэдэд учирч байгаа энэ татварын хөнгөлөлт ачааллыг бууруулаад байгаа гэж үзэж байгаа юм уу? 500

мянган төгрөгийн цалинтай иргэдийнхээ тоог нэг статистик тоог нэг гаргаад хэлээдхээч. 2 дугаарт нь болохоор энэ бизнесийн юу татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийнэ. Энэний 3.2.1.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батчимэг гишүүний 1 минут сунгая. Сангийн сайдыг дуудаарай.

П.Батчимэг: Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх зорилтын 3.2.1.6. Энд ямар зорилт байна вэ гэхээр ажил гүйцэтгэх хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон хөдөлмөрийн хөлсөнд НДШ ноогдуулахдаа уян хатан хөнгөлөлттэй байна тийм нөхцөлийг бүрдүүлнэ гэхихсэн. Тэгтэл өнөөдөр энэний хэрэгжилт нь 30 хувьтай. Энэ заалтыг хувийн хэвшил, компани, компаниуд асар их хүсдэг. Ганц энэ заалтыг. Яагаад гэвэл нөгөө ажил гүйцэтгэх хөлсөөр ажиллах тэдгээртэй адилтгах гэрээний дагуу гээд НДШ тооцож авч байгаа ажил олгогчид дарамт болсон ганцхан заалт энэ байгаа байхгүй юу. Энийгээ засаад зохицуулаад ороод ирж болдоггүй юм болов уу? Баахан юм тайлагначихсан байгаа байхгүй юу. Нийгмийн даатгалын багц хууль, Хувийн нэмэлт тэтгэврийн даатгалын хууль, энэ даатгалын хуулийг боловсруулж байгаа гээд ийм нэг олон тийм дарамттай зүйл тайлагнаад ороод ирсэн байна. Тэрнийхээ оронд энийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хэн хариулт өгөх вэ? Энэ Сангийн сайд хаачсан юм бэ? Сангийн яамны ТНБД Ганбат дарга хариулт өгье.

Ж.Ганбат: Батчимэг гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны ЗГ-аас мөн Улсын Их Хурал Ганхуяг гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг энэ он гараад нэг сараас эхлээд татварын шинэчлэлийн асуудлаар орон даяар хэлэлцүүлэг хийж байгаа. Нийтдээ татварын шинэчлэлийн хэлэлцүүлгийн үеэр 11 мянга гаруй иргэн, ААН оролцож энэ 170 мянга гаруй ингээд санал өгөөд энэ дээр бол яг таны хэлж байгаагаар яг одоогийн хэрэгжиж байгаа Татварын хууль дээр бид ямархуу байр суурь барих вэ, бизнес болон хувийн иргэд дээр ямар дэмжлэг үзүүлэх вэ гэдэг ийм байдлаар ажиллаж байна. Нийт энэ ирсэн 170 мянга гаруй санал дээр зүгээр дотор нь ангилаад үзвэл татварын хувь хэмжээг бууруулъя гэдэг дээр 56 хувь нь нийтдээ 170 мянган саналаас 56 хувь нь татварын хувь хэмжээг бууруулах гэдэг санал өгсөн байна. 17 хувь нь хөнгөлөлт чөлөөлөлтийн нэмэгдүүлэх. 15 хувь нь татвар, гаалийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, 12 хувь нь татварын хууль тогтоомжийг ойлгомжтой болгох гэдэг ийм байдлаар үзэж байна.

Хувь хэмжээ бууруулах дотор нь ХХОАТ-ын хувь хэмжээг бууруулж өгөөч гэдэг ийм санал 12 хувь нь ирчхээд байна. Гол хувь хэмжээн дээр яах вэ НӨАТ-тай холбоотой саналууд дийлэнх нь ирсэн. Мөн тэр хөнгөлөлт чөлөөлөлтийн нэмэгдүүлж өгөөч гэдэг санал дээр Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг нэмэгдүүлж өгөөч гэдэг нь 29 хувь ийм санал өгсөн. Тэгээд энэ дээр ЗГ дээр хэлэлцүүлэг хийгээд, саналаа боловсруулаад Ганхуяг гишүүнээр ахалсан ажлын хэсэгтэй хамтраад ингээд ажиллаж байна. Энэ асуудлыг Улсын Их Хуралд өргөх хэмжээнд энэ хуулийн татварын шинэчлэлийн асуудлыг өргөн барих хэмжээнд ингээд ажиллаж байна. Мөн татварын ХХОАТ-ын тухай одоо яг үйлчилж байгаа хуулийн 23.1-д заасан хөнгөлөлт нь бага, дунд орлоготой иргэдийг дэмжих зорилгоор хэрэгждэг, цалингийн орлоготой иргэдийн татварын ачааллыг 5 хүртэл хувиар бууруулж хөнгөлдөг байгаа. Энэ хөнгөлөлтөд 2023 оны жилийн эцсийн

байдлаар нийтдээ 700 гаруй мянган иргэд хамрагдаж, 115 тэрбум төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн ийм тоон мэдээллийг танд танилцуулж байна.

Д.Амарбаясгалан: Пүрэвийн Батчимэг гишүүн тодруулж асууя.

П.Батчимэг: Миний яг Ганбат дарга миний яг асуултад тодорхой хариулт өгсөнгүй л дээ. Би тэр нөгөө нэг та шатлалаа мэдэж байгаа байх. ХХОАТ-ын хууль 2020 оноос хойш хэрэгжээд яг одоо энэ хөнгөлөлт 240 мянган төгрөгийн хөнгөлөлт. Гэхдээ энэ чинь нөгөө жилийн 3 сая төгрөгийн орлоготой иргэдэд гээд байгаа шүү дээ. Тэгээд 3 сая төгрөгийн орлоготой иргэд гэдэг маань сарын 500 мянга. 500 мянган төгрөгийн орлоготой иргэд Монголын нийгэмд өнөөдөр яг хэд байгаа юм бэ гээд байгаа юм. Хэдэн хувийг эзлээд байна вэ, энэ ажилтай байгаа орлоготой хүмүүсийн хэдэн хувийг эзэлж байгаа юм бэ? Гол нь энэ юу 4 сая төгрөгийн орлоготой, дээшээгээ 5, 6 сая төгрөгийн орлоготой иргэд энэ хөнгөлөлт чинь орохгүй байгаа шүү дээ, хамаарахгүй байгаа юм. Тэгэхээр энийг дахиад энэ татварын шинэчилсэн татварын багц хуульд өөрчлөлт оруулахад энэ дээр яг тодорхой хөнгөлөлтийг нэмэх үү?

Д.Амарбаясгалан: Ганбат дарга хариулт өгье.

Ж.Ганбат: Би танд яах вэ одоо сарын орлого нь 500 мянган төгрөг хүртэл хамрагдаж байгаа иргэд нь хамрагдалт нь 193 мянган хүн байна, 800 мянга, сарын 800 мянган төгрөгийн орлоготой иргэд 303 мянга байна, 1 сая төгрөгийн орлоготой иргэд 52 мянга байна, 1,5 саяыг орлоготой нь 123 мянга байна, 2 сая төгрөгийн орлоготой нь 105 мянга байна, 2,5 сая нь 99 мянга байна, 3 сая төгрөгийн орлоготой иргэд 76 мянга гэдэг ийм яах вэ статистик тоо байна. Тэгээд хувь хүмүүсийн 800 мянга хүртэл төгрөгийн орлогыг татвараас 100 хувь хөнгөлөхөөр одоо яг татварын хууль дээрээ боловсрогдоод ажиллаж байна. Яах вэ энэ яг хуулийн төсөл дээр ажиллаж байгаа ажлын хэсгийн түвшинд энэ асуудал яригдаж байгаа. Тэгээд энэ хөнгөлөлт хувь хүмүүсийн 800 мянга хүртэлх орлогыг татвараас 100 хувь хөнгөлөх төслөө боловсруулаад энд бол бүх хүн хамрагдахаар байгаа. Нийт цалингийн орлоготой иргэдийн 90 орчим хувь нь 3 сая.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Ж.Ганбат: Нийт цалингийн орлоготой иргэдийн 90 орчим хувь нь 3 сая төгрөг хүртэлх цалингийн орлоготой байдаг ийм байна. Дээрээс таны хэлээд байгаа энэ асуудлыг саяын тэр хувь хүмүүсийн 800 мянга хүртэл орлогыг татвараас 100 хувь хөнгөлөхөөр төсөлдөө тусгачхаад байгаа. Гэхдээ яах вэ энэ бол эцсийн байдлаар ЗГ дээр хэлэлцэгдээд, ЗГ-т танилцуулсны дараа Улсын Их Хуралд өргөн барих ийм байдалтай ажиллаж байгаа. Би зөвхөн танд энэ нөгөө хэлэлцүүлгийн явцад Ажлын хэсгийн түвшинд ажиллаж байгаа ийм мэдээллийг энд өгч байгаа. Эцсийн шийдвэр ЗГ-ын хуралдаан дээр хэлэлцэж өргөн барихдаа гаргана.

Д.Амарбаясгалан: Хариулт хангалтгүй гэж үзээд дахин тодруулъя гэж байна. Пүрэвийн Батчимэг гишүүнд тодруулга 1 минут өгье.

П.Батчимэг: Ганбат даргаа ер нь жилийн 3 сая төгрөгийн орлоготой иргэдээ танай яам Сангийн яам бага орлоготой тооцоод байна уу эсвэл дунд орлоготой

иргэд гэж тооцогдож үзэж байгаа юм уу? 3 сая төгрөгийн орлоготой жилийн 3 сая төгрөгийн орлоготой иргэд чинь сардаа ерөөсөө 20 мянган төгрөгийн л юу авчхаж байгаа юм. Дээшээ дахиад орлого, иргэдийн орлого 4 сая төгрөг сардаа 4 сая төгрөгийн цалинтай, 5 сая төгрөгийн цалинтай, 6 сая төгрөгийн цалинтай хувийн хэвшил компаниудад ажилчид нь маш их байгаа шүү дээ. Энэ хүмүүс яагаад тэгвэл дахиад энэ хөнгөлөлтөд хамаарч чадахгүй байгаа вэ?

Д.Амарбаясгалан: Хариулт өгье.

Ж.Ганбат: Бид сая би танд ингээд хэлсэн. Энэ ингээд сарын 3 сая төгрөгийн орлоготой иргэд нийт энэ татвар төлж байгаа хувь хүний яг тоонд нь 76 мянга байгаа. Одоо тэгэхээр бид энэ 3 сая төгрөгөөс дээш цалинтай иргэд гэнэ. Нөгөө талдаа бид орлогын тэгш бус байдлыг арилгах, манай эдийн засаг чинь өөрөө уул уурхай дээр түшиглэхсэн. Тэгэхээр бид яах вэ прогрессив буюу шаталсан татвартай байна гэдэг дээр бид гол үндсэн концепцоо гаргаж байгаа юм. Тэгэхээр мэдээж яах вэ энэ орлого 3 сая төгрөгөөс дээш гэдэг төрийн албаны гол юу 3 саяас дээш төгрөгийн цалинтай иргэд дээр бид бага, дунд гэж ангилж хөнгөлөлт чөлөөлөлт бол үзүүлэхгүйгээр нийтэд нь бид танд уг нь танд би уг нь ингээд хэлээд байгаа нь бүх нийт иргэддээ 800 мянган төгрөгийн сарын энийг бол хөнгөлөлтөө бол бүгдийг нь эдлүүлэхээр ингэж ажлын хэсэг дээрээ ярилцаад байгаа. Тэгэхээр бол одоогийн яг хийж байгаа шинэчлэлээр бүх иргэдэд орлогын дүнгээс үл хамаараад.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: ЗГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилт, биелэлтийн тухай яригдаж байна. Хэрэгжилтийг ЗГ үнэлээд, Их Хурлын Тамгын газраас аудитын дүгнэлтүүд гээд ингээд тоо процентыг нь харахаар хоорондоо их зөрөөтэй ийм дүгнэлтүүд. Зүгээр эндээс тэр өөр өөрсдийн үнэлгээний зөрөө тэрүүгээр яривал баахан юм ярьж болох байх. Зүгээр бодит байдлыг илэрхийлсэн нэг хэдэн үзүүлэлтүүдтэй, тоо баримтуудтай зүйлийг заавал асуух, яг иргэд дээр асуудал өнгөрсөн хугацаанд юу болоод байна вэ гэдэг. Тэгэхээр эдгээр тодорхой нэг ийм тоо баримт бүхий асуултууд асуух гээд байгаа энэнд нэг тодорхой хариулж өгөхийг хүсье. Яг иргэдийн бодит худалдан авах чадвар өнгөрсөн хугацаанд яаж өөрчлөгдөх вэ? Худалдан авах чадвар, дээрээс нь бодит худалдан авах чадвар, орлого нэмэгдчихсэн, дахиад дээрээс нь татвар, инфляц, цахилгаан, дулааны өсөлт гээд энэ бүгдийг чинь ингээд тооцоод ирэхээр бодит худалдан, иргэдийн бодит худалдан авах чадварын үзүүлэлт дээр тодорхой ямар үр дүнд хүрсэн бэ гэдэг тоо бүхий хариултууд өгөөч.

2 дугаарт нь ер нь Монгол Улсад өнгөрсөн хугацаанд орлогын ялгаа гэдэг зүйл ямар түвшинд байна вэ? Орлогын ялгаа гэдэг зүйл. Энийг тооцдог жини коэффициент гээд байдаг 0-1 процентын хооронд, 1 пунктын хооронд үздэг, ямар байхаар сайн, муу гээд. Тэгэхээр энэ дээр яг Монгол Улсад орлогын ялгаа, тэгш бус байдлын ялгаа жини коэффициент өнөөдөр хэдтэй байгаа вэ? Энэ дээр ямар дүгнэлттэй байгаа вэ? Энэ ЗГ-ын хууль хэрэгжүүлж байгаа, хуулийн биелэлтийг хариуцаж байгаа газрын нэлээн том ажлын шалгуур үзүүлэлтүүдийн нэг, анхаарч явах ёстой үзүүлэлтүүдийн нэг байх гэж. Тэгээд эндээс улбаалаад энэ 9 гол шалгуур үзүүлэлт дотор ч ингээд харагдана лээ. Ер нь Монгол Улсын ЗГ төрийн бодлогын нэг бараг тэргүүлэх чиглэл Монгол Улсад дундаж анги гэдэг зүйл бий

болж байна уу? Ер нь дундаж ангийг манайх яаж тодорхойлдог юм бэ? Монгол Улсын иргэдийг дундаж анги гэдгийн шалгуур үзүүлэлтээ гаргасан юм уу? Би энэ баримт бичгүүдийг тойруулж хараад ганц ч тийм юм үзсэнгүй л дээ. Би дутуу үзчихэв үү? Дундаж ангийг ямар аргачлалаар яаж тодорхойлж байгаа юм бэ? Өнөөдөр дундаж анги энэ 3 сая 500 мянган иргэний сая гаруй орчим өрх айлын хэчнээн нь дундаж ангид хамаарч байгаа юм бэ? Энэ дээр нэг ийм тоотой, баримттай аргачлалтай, үзүүлэлттэй буюу би нэг энэ зузаан хуудастай ЗГ-ын үнэлгээ өөрийгөө үнэлсэн, өрөөлөөр үнэлүүлсэн нэг ийм тоо баримт, коэффициент, хувь хэмжээнээс илүүтэйгээр яг эцсийн амьдралын жирийн иргэний нөгөө нэг хөрсөн дээрх гэдгээр амьдралын тухай л ингээд ярих гээд байна л даа.

Төгсгөлд нь ядуурлын үзүүлэлт гэдэг үзүүлэлт байдаг. Дэлхийн банктай хамтарч гаргадаг. Энэ тоо баримт өнгөрсөн хугацаанд хэд байсан, хэд болж өөрчлөгдөж байгаа вэ? Энэ өөрчлөлтөд ямар хүчин зүйлүүд сайнаар, муугаар нөлөөлж байгаа вэ буюу яг энэ үзүүлэлтүүд өөрөө бид нарт өөрөө өөрсдийгөө үнэлсэн хувь процентын үзүүлэлтээс гадна энэ бол яг ЗГ-ын үйл ажиллагааны нэлээн чухал баримталж явах ёстой чиг зүг чиг барьж явах ёстой үзүүлэлтүүд байх гэж бодож байна. Эдгээр асуултуудад тодорхой хариулт өгөөч. Уг нь ингээд харахаар Их Хурлын даргаа ингээд харахаар саяын миний асуултууд нэлээн ингээд ажил хариуцсан салбарын сайдаас л уг нь хариулт авмаар байдаг. Яг энийг саяын миний асуултуудад хариулт өгөх сайд нараас нэг ч хүн энд алга. Та микрофон өгөөд ажлын хэсэг гээд нэг газар, хэлтсийн дарга, Төрийн нарийн нь хариулсан болоод ингээд л өнгөрөх. Уг нь би хариултаа авмаар байх. Тэгээд яах ёстой юм байгаа юм.

Д.Амарбаясгалан: Яах вэ, Учрал сайд юу гэж бодож байна вэ? Харин тийм. Цогтгэрэл сайд гишүүний асууж байгаа асуулт маш чухал асуулт л асуугаад байдаг. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

И.Батхүү: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Та яг тайлангаас гэхээсээ илүү эдийн засгийн гол ойлголтын талаар асуусан учраас энэтэй холбогдох мэдээллийг 24 оны 4 дүгээр улирлын байдлаар танд танилцуулъя. Өрхийн бодит орлогын хувьд орлогын өсөлт нь 5,9 хувь болсон байна 24 оны 4 дүгээр улирлын байдлаар. Бодит орлогын өсөлтөд иргэдийн цалингийн орлого мөн өмнөх оны мөн үеэс 233 мянган төгрөгөөр, тэтгэвэр тэтгэмжийн орлого 76 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байгаа. Бодит орлогын бүтэцтэй дотроо цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, МАА-н орлого гэсэн бүтэцтэй байгаа. Цалин хөлсний орлого нь 57,2 хувь, тэтгэвэр тэтгэмж 23,1 хувь эзэлж байна.

Таны асуусан ядуурлын коэффициенттой холбоотой тоог хэлье. Энэ үзүүлэлт нь 2018 онд 32,7 хувь байсан бол 22 онд 31,4 хувь болж буурсан байгаа. 25 онд бидний тооцоолж байгаагаар ойролцоогоор 0,32 болох төлөвтэй байгаа.

Д.Амарбаясгалан: Болсон уу? Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Би уг нь нэлээн олон л зүйлүүд асуусан л даа. Жишээ нь саяынх дээр тэр бодит орлого гэдэг зүйл чинь цалин, тэтгэвэр тэтгэмжийн тэр нэг нэрлэсэн нэмэгдлээсээ гадна энэ инфляц чинь, энэ татварын өөрчлөлтүүд, энэ цахилгаан дулааны үнийн өсөлтүүд гэх зэрэг зүйлүүд чинь яг бодит нэрлэсэн өсөлтөөсөө гадна бодит орлого гэдгийг нэлээн өөр тоонууд энэ дээр харагддаг

байх. Хувь процентоос гадна мөнгөн дүнгээр хэд байсан бодит орлогыг хэдэн онтой харьцуулахад хэдэн оныг суурь гэж авахад хэд болгосон гэдэг тоонууд энэ дээр яригдах ёстой байх.

Тэгээд нэлээн чухал зүйлүүд тэр дундаж анги гэдгийг яаж Монгол Улсад өнөөдөр яаж тодорхойлж, ямар шалгуур байгаа юм бэ? Яг ингээд харахаар Монгол Улсын иргэдийг орлогынх нь бүтцээр харахаар нэг ийм элсэн цаг шиг юм болж хувираад байгаа нөхцөл байдал, дундаж ангиа бид бүхий л бодлого дундаж ангиа шахаад, үндсэндээ дээрээ нэг жижигхэн толгойтой, доороо том, голдоо байхгүй элсэн цаг руу яваад байгаа юм уу гээд. Тэгэхээр энийг хэн нэгэн хүний сэтгэгдлээс.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

И.Батхүү: Яг таны асуусан асуулттай дундаж цалин голч цалингийн өөрчлөлт дээр энэ мэдээллийг өгч болох байх гэж бодож байгаа. Дундаж цалингийн хэмжээ 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 19,5 хувиар өсөж 2 сая 672 мянган төгрөгт хүрсэн ийм тоон баримт байна. Голч цалингийн хувьд 24 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 25 хувиар өсөж 2 сая 229 мянган төгрөг болсон. Салбараар нь авч үзвэл уул уурхайн салбарын дундаж цалин бусад салбараар тэргүүлж улсын дунджаас 2 дахин өндөр байгаа. Энэ бодит гэдэг тоон мэдээлэл цаанаа инфляцын нөлөөлөл, үнийн өсөлтийн нөлөөллийг.../үг тасрав/

Д.Амарбаясгалан: Батхүү даргаа дундаж цалин асуугаагүй шүү дээ. Дундаж анги гэж яаж тодорхойлж байна вэ гэдэг асуудлаар тодорхойлоод байна шүү дээ.

И.Батхүү: Эдийн засаг, хөгжлийн яамны гаргаж байгаа тоон үзүүлэлтийн дотор дундаж анги гэсэн үзүүлэлт байхгүй байгаа.

Д.Амарбаясгалан: Харин тийм. Түрүүн Ганбат дарга Батчимэг гишүүний асуултад хариулж байсан. Энэ татварын хөнгөлөлтийн хувь хэмжээг орлогоос нь хамаараад үзүүлж байгаа хэлбэр яваад байдаг. Түүн дээр нэг нэгдсэн ойлголтоор энэ татварын хөнгөлөлтийн бодлого чинь ер нь дундаж давхаргаа дэмжих үндсэн зорилгыг агуулж, татварын хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлнэ гэж ЗГ зорьсон байна гэдгийг гишүүд ойлгож, тэрнээс асуулт асуугаад байна л гэж ойлгогдож байна шүү дээ? Тийм. Тэгэхээр энэ дээрээ одоо яах вэ Гантөмөр дарга гадаадад ажлын айлчлалтай учраас явчихсан. Эдийн засаг, хөгжлийн яамнаас ТНБД төлөөлөөд сууж байна. Сая Жавхлан сайд сууж байгаад Дарханд ажилтай гээд гараад явчихсан байна. Надад хэлж чөлөө аваагүй. Дэгийн тухай хуулиараа Улсын Их Хурлаас түр болон бүр гарах гэж байгаа тохиолдолд Их Хурлын хурал даргалагчаас зөвшөөрөл авч гардаг байх Дэгийн хуультай.

Тэгээд энэ хэлэлцэж байгаа асуудал өөрөө 4 сарын 1-ний дотор Улсын Их Хурлаар хэлэлцэж батлагдсан байх хуулийн заалттай. Тэгээд ингээд гишүүд тодорхой асуулт асуухаар тодорхой хариулт өгч чадахгүй, яг төлөөлж байгаа албан тушаалтан байхгүй гэдэг ийм учир шалтгаан болоод яваад байгаа нь ажлын чанарт сөрөг нөлөөлж байна. Түрүүн Ерөнхий сайд тодорхой хэлсэн. Төлөвлөлтийг, үр ашгийн тооцоог энэ бодлогын асуудлыг ер нь бодитой ярьдаг

болно. Цаашдаа илүү бодитой ярьдаг байх нь чухал гэдэг агуулгууд хөндөгдөөд байдаг. Тэгээд та хэд маань нэг хариулаад байдаг, энд хэдэн гишүүд асуугаад байгаа нэртэй, тэгээд бодитой үр дүн гарахгүй юман дээр л явж байна л даа.

Тийм учраас л өчигдрөөс хойш Улсын Их Хурлын өмнө ажлаа хариуцаж байгаа албан тушаалтнууд үүргээ гүйцэтгэж, хариуцлагаа ухамсарлаж оролцох ёстой гэдэг зүйлийг яриад байгаа байхгүй юу. Тэгээд л эдийн засгийн чухал ач холбогдолтой асуудал хөндөгдөхөөр энд ингээд тодорхойгүй хариулттай сууж байна гэдэг бол байж болохгүй л дээ. Учрал сайд.

Н.Учрал: Гишүүдийн тавьж байгаа шаардлагыг ойлгож байгаа. Тэгээд өнөөдөр салбарын сайд болоод ТНБД асуултад хариулж байна. Тэгээд өнөөдөр Атрын 4 дүгээр аян эхэлж байгаатай холбогдуулаад өдөр Ерөнхий сайд мэдээлэл хийхээд Сангийн сайд, холбогдох албан тушаалтнууд тэнд ажиллаад байх шиг байна. Ер нь Эдийн засгийн яам, Сангийн яам ТНБД нар бол асуултад хариулна. Тэгээд би гишүүдэд нэг мэдээллийг өгөхөд 2020 онд энэ Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын хууль батлагдсан. Тэгээд яг энэ хууль батлагдсаны дараа бид 4 жилийн хөтөлбөртэй болсон. 2021 онд яг энэ хуулийн дагуу 1500 тэр эрдэмтэн судлаачид оролцоод Их Хурлаар урт хугацааны бодлого батлагдсан. Ингээд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын хууль Их Хурлаар батлагдсан Алсын хараа гэсэн урт хугацааны бодлогыг түшиглээд бид дунд хугацааны тэр хөтөлбөрийг ЗГ гаргадаг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Н.Учрал: ЗГ гаргадаг. Ингээд хамтарсан ЗГ байгуулагдсаны дараа үйл ажиллагааны хөтөлбөрөө батлуулсан. Үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсаны дараа хуулийн дагуу бид хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг ЗГ-аар баталдаг. Үүнийг Эдийн засгийн яам боловсруулдаг яг хуулийн дагуу. Ингээд жилийнхээ төлөвлөгөөг салбарын яамнууд болоод төрийн захиргааны байгууллагууд дүгнээд, Хяналт шинжилгээний газар дээр ирж үнэлгээгээ нэгтгээд ингээд Их Хуралд энэ улсын аудитын байгууллагадаа оруулж ирж байгаа нийцлийн аудит дээр ингээд хяналтуудаа тавиад явж байгаа гэсэн үг. Тэгэхээр ЗГ шинэ хуулийн дагуу анх удаа бид төсөвлөлт, төлөвлөлт, хяналт гэдгийг нэг тогтолцоогоор явуулдаг болсон.

Тэгэхээр одоо бол бид үнэлэхдээ бол жишээ нь ЗГ-ын хөтөлбөр 6 бодлого, 259 зорилт, 1087 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх юм. Тэгэхээр энийг хянахдаа тэр DIE гээд байгаа тэр design monitor evolution гэдэг нөгөө тогтолцоо өөрөө анх удаа нэг болсон гэсэн үг. Тэгэхээр бид өнөөдөр нийцлийн аудитыг хэлэлцэхдээ сонгууль.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Одоо 32 гишүүн асуулт асуух байгаад байгаа. Бүх асуудалд нь хариулаад яахгүй бол баахан сайд л нэхэх байх даа. ЗГ-ынхан энэ хоорондоо ярьцгаагаарай. Мэндбаярын Мандухай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Би л ялгаа байхгүй Хөдөө аж ахуйн сайдаас л асуумаар байлаа. Тэгээд нэгэнт байхгүй учраас яах вэ ер нь энэ ганц нэг салбарын асуудал биш ер нь бусад салбарууд дээр ч гэсэн энэ төлөвлөгөө гүйцэтгэлтэй холбоотой үнэлгээний асуудал ер нь зарчмын хувьд адилхан байх шиг байна. Энэ Үндэсний аудитын газраас гаргасан 24 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний

хэрэгжилт 52,1 хувьтай гэж гарчээ. Тэгээд энэ нөгөө нэг төлөвлөгөө болгон цаад талдаа гүйцэтгэлээсээ хамаараад тодорхой хэмжээний төсөв зарцуулагдаад явж байгаа. Тэгээд энэ 52,1 хувийн гүйцэтгэлтэй, тэр хэмжээгээр мөнгө зарим тохиолдолд төсвөөсөө илүү давсан ийм үзүүлэлтүүд байгааг би зөвхөн ХАА-н салбар дээрээ түшиглээд яримаар санагдлаа.

1 дүгээр асуудал болохоор энэ хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулна гээд. 2022 оноос хойш хүнсний аюулгүй байдлыг, хангамж, аюулгүй байдлыг хангах энэ том бодлого хэрэгжээд хүнсний хувьсгал гэдэг хөдөлгөөн нийтдээ 1,7 их наяд төгрөгөөс 1,2 орчим их наяд төгрөг зарцуулагдаад гараад явж байгаа. Тэгээд энэ өөрөө хөдөлгөөн маань үндсэндээ тодорхой хэмжээний хугацаатай, төлөвлөгөөтэй. Энэ хөдөлгөөнийг өрнүүлэхтэй холбоотойгоор ЗГ өөрөө юу хийх ёстой байсан бэ гэхээр энэ хүнсний хангамж, аюулгүй байдал үнэхээр хангагдаж байгаа юм уу, энэ хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх гэж байгаа гол энэ чиглэл чинь хэрэгжих үү гэдэг дээр анхаарах ёстой байсан. Тэгтэл энэ Үндэсний аудитын газрын үнэлгээгээр хүнсний аюулгүй байдлын индекс тооцох аргачлал байхгүйн улмаас үндсэндээ энэ тавьсан энэ тэргүүлэх чиглэлүүдийн шалгуур үзүүлэлтийг үнэлэх боломжгүй гэж байгаа юм.

Тэгтэл энэ тэргүүлэх 5 чиглэлийг харвал үндсэндээ хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр 5 энэ төсөвт тусгасан ажлууд харагдаж байгаа. Жишээлбэл 1 ажил гэхэд хүнсний бүтээгдэхүүний чанар баталгаажуулалтын лабораторийн чадавхыг нэмэгдүүлнэ. ЗГ өөрсдөө үнэлэхдээ 90 хувьтай үнэлчихсэн байгаа. Тэгсэн мөртөө төсөвт батлагдсан санхүүжилт нь 500 тэрбум төгрөг, 500 сая төгрөг гэсэн мөртөө нийт зарцуулсан гүйцэтгэл нь 2,7 тэрбум төгрөг буюу төсөвлөгдсөн энэ батлагдсан санхүүжилтээсээ 551 хувиар илүү мөнгө ингээд зарцуулчихсан. Тэгээд тэрийгээ болохоор гадаад зээл, тусламжаар санхүүжүүлээд ингээд явж байх жишээтэй. Тэгэхээр төсвөө дураараа ингээд батлагдсан санхүүжилтээсээ илүү зарцуулчихсан. Тэгсэн мөртөө ингээд үнэлэх үнэлгээ нь байхгүй. Тэгэхээр бид энд яг өнөөдөр юуг хянаж, юун дээр шаардлага тавьж суух гэдгийгээ яг хэлж сайн мэдэхгүй л байна л даа.

2 дугаар асуудал юу гэхээр түрүүн Эмээлтийн паркийн асуудлыг ярьж байсан. Энэ 2 том чухал асуудал явж байгаа юм. Жишээлбэл энэ Хүнсний хангамж, Цагаан алт, Шинэ хоршоо гээд хөдөлгөөнүүд өрнөөд, санхүүжилтүүд гараад ингээд үр дүн эхнээсээ эхлээд хэмжигдэхээр ажиллаад явж байгаа. Гэтэл энийг нь дэмжих ёстой хамгийн чухал энэ Эмээлт болон Дарханы үйлдвэр технологийн паркууд нь 0-ээс 29 хувийн гүйцэтгэлтэй байгаад байгаа юм. Түрүүн хэлсэн. Үгүй ээ дэд бүтэц байхгүй юм чинь өөрсдийгөө 90 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлж байгаа нь би сайн ойлгохгүй байна л даа. Тэгэхээр энэ арга хэмжээнүүд хангалтгүй хэрэгжээд байгаа ер нь шалтгаан нь яг юу юм бэ? Жишээлбэл энэ Эмээлтийн эко паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх төсөл, арга хэмжээнүүд нь 49,1 тэрбум төгрөг төлөвлөсөн. Одоогоор 3,1 тэрбум төгрөг зарцуулаад санхүүжилт нь 6,3 хувьтай байгаа. Тэгээд хэрэв үнэхээр тухайн жилдээ хэрэгжүүлж чадахгүй байсан юм бол яах гэж төлөвлөгөөнд тавьдаг юм бэ? Тэрийг нь бид тодорхой хэмжээний үнэлгээ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мандхай гишүүнд 1 минут нэмж өгье.

М.Мандхай: Тэгэхээр энэ үнэлгээгээ өөрсдөө 90 хувийн гүйцэтгэлтэй гээд тавьчихсан. Гэтэл 6,3 хувийн ийм бодит гүйцэтгэлтэй явж байгаа. Бид яаж, энийгээ яаж тайлбарлах юм бэ гэдгийг асуумаар байна. Тэгээд энэ нийт ер нь энэ гадаад зээл, тусламжийн асуудал дээр харвал 96-аас 2024 оны байдлаар зөвхөн ХАА-н чиглэлийн 21 төсөл дээр гэхэд л 1,8 их наяд төгрөг, байгаль орчин энэ уур амьсгалтай холбоотой 23 төсөл дээр 453,7 тэрбум төгрөгийг ингээд санхүүжилт хэлэлцээр хийгдсэн байгаа. Тэгсэн мөртөө зээлийн ашиглагдаагүй дүн нь 37,2 хувь хөдөө аж ахуй дээр, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт дээр 25,5 хувь нь зээлээ ашиглагдаагүй ингээд 96 оноос хойш ийм санхүүжилтүүд байгаад байна. Тэгээд энэ нь өөрөө юу хэлж байна гэхээр бид мөнгөө зарцуулаагүй нь сайн гэдэг ойлголттой байж болохгүй. Яагаад гэхээр энэ тусламжийн чинь цаана хүү төлөгдөөд явж байгаа.

Д.Амарбаясгалан: ЗГХЭГ-ын дарга Ням-Осорын Учрал сайд хариулт өгье.

Н.Учрал: Энэ ЗГ-ын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр дээр яг 4 жилийн дараа хүрэх үр дүн гэдэг бол бид нарын 4 жилийн дараах яг хүрэх үзүүлэлт. Жишээ нь засаглалын үзүүлэлтийн дунджийг 10 байр, инфляцыг 5 хувьд барина, эдийн засгийн өсөлтийг 6 хувьд хадгална, хүний хөгжлийн үзүүлэлтийг 10 байраар ахиулна, эдийн засгийн эрх чөлөөний байдлын үзүүлэлтийг 10 байр ахиулна гээд. Энэ бол 4 жилийн дараах үр дүн гэж байгаа. Үүнийг хэрэгжүүлэхэд ЗГ арга хэмжээний төлөвлөгөөгөө гаргаад, өнөөдөр энэ аудит бол тайлагнахдаа өнгөрсөн жилийн хяналт шинжилгээ, үнэлгээг танилцуулж байгаа гэсэн үг. Тэгэхээр бид анх удаа төсөвлөлт, төлөвлөлт, хяналт 3-ыг анх удаа Их Хурлаар ингэж оруулж ирж байна.

Яагаад гэхээр хяналт хэрэгжүүлэх ажил бол ЗГ-аас нөгөө үнэлгээний аргачлал гаргачихсан. Тэгээд үнэлгээний аргачлал тэр журмын дагуу энэ ажлууд үнэлэгддэг. Тэгээд Хяналт хэрэгжүүлэх хууль гарснаар тухайн үед эрх зүйн орчин шинэчлэгдсэн. Шинэ эрх зүйн орчноор бид үнэлэгдэж байгаа гэсэн үг. Тэгээд өнөөдрийн энэ сая таны тэр яагаад түүнд хүрэхгүй байгаа юм бэ гэдэг бол яг энэ өнгөрсөн жилээс яг өнөөдрийн цаг хугацаа хүртэлх бүтэн жилийг үнэлж байна. Тэгэхээр энэ бол яг хамтарсан ЗГ-ын бүх үйл ажиллагаа ч биш. Өнгөрсөн 6 сарын үзүүлэлтээр ийм гарч байгаа юм.

Тэр Ерөнхийлөгчийн зарлигаар санаачлагдсан энэ хүнсний хувьсгал дээр 2022 оны Их Хурлын 36 дугаар тогтоол байдаг. Үүн дээр 114 заалт бүхий төлөвлөгөөг бид баталсан. Энэ дээр ЗГ, Ерөнхийлөгчийн Тамгын газар хамтраад ажлын хэсэг байгуулаад ажиллаж байгаа. Хамгийн сүүлийн үнэлгээгээр энэ хүнсний хувьсгал дээр 49 заалтын хэрэгжилт 61 хувьтай, 2023 онд 50 заалтын хэрэгжилт 66 хувьтай гэдэг гүйцэтгэлүүд гарсан. Тэгэхээр бид ер нь сая Эмээлтийн эко парк ч байна, тэр үйлдвэр технологийн паркууд мөн л тэр шинэ эрх зүйн орчныхоо дагуу жишээ нь Эмээлтийн эко парк бол нийслэл дээр хэрэгжинэ. Гэхдээ Үйлдвэр, технологийн паркийн хуулиа бариад явах гэхээр Паркийн хуулийн гол концепт бол төр өөрөө дэд бүтэц дээр нь оролцох хэдий ч, хувийн хэвшлийн оролцоог л нэмэгдүүлэхэд чиглэдэг. Түүн дээр нь татварын ба татварын бус дэмжлэг үзүүлдэг. Тэгээд үүн дээрээ гол анхаарлаа хандуулж байгаа гэсэн үг.

Тэгэхээр Мандхай гишүүний саяын асууж байгаа асуултууд буюу одоо бол 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг

журмаар өмнө нь үнэлэгдэж байсан. Одоо бол бид төсөвлөлт, төлөвлөлт, хяналт 3-ыг нэгтгэж байна гэсэн үг. Тэгэхээр ирэх жил яг энэ нийцлийн аудитын тайланг хэлэлцэхэд бид яг төсөвлөлт, төлөвлөлт, хяналтыг нэг тогтолцоогоор анх удаа үнэлж эхэлнэ. Түүний дараа мэдээж энэ яг зөв голдирол руугаа орно гэж хэлж болно. Тэгэхээр энэ шинэ эрх зүйн орчноор тайлагнаж байгааг ойлгох.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мэндбаярын Мандхай гишүүн тодруулж асууя.

М.Мандхай: Ер нь төлөвлөгөө гаргахдаа төлөвлөгөө чинь өөрөө ямар үр дүнд хүрэх гэж байгаа юм бэ гээд үндсэндээ өөрсдийнхөө үр дүнг үнэлэх тэр төлөвлөгөөтэйгөө уялдаж гарах ёстой. Тэгэхээр яах вэ таны хэлээд байгаа яг үндсэндээ та үнэлгээнийхээ хувийг ч гэсэн сайн мэдэхгүй л байна л даа. Эмээлтийн эко аж үйлдвэрийн парк 2024 онд бид 90 хувьтай гүйцэтгэлтэй байна гээд гарчихсан байгаа. Гэтэл өнөөдөр хамгийн чухал гол асуудал бол тэр хувийн хэвшил очиж нүүхэд улс өөрөө дэд бүтцийг нь хангаж өгөөгүй юман дээр ямар ч хувийн хэвшил очиж тэнд дэд бүтцийг өөрсдөө барьж байгуулна гэж байхгүй. Тэгэхээр энэ дээр Тамгын газрын үнэлгээ, Улсын Их Хурлын Тамгын газар үнэлэхдээ 50 хувийн гүйцэтгэлтэй гээд гарчихсан байгаа. Дархан арьс, ширний цогцолбор тэр чигээрээ тэг хувьтай жишээлбэл явж байх жишээтэй. Тэгэхээр би энэ үнэлгээгээ ийм үнэлгээтэй юмыг яаж бид энд хянах гээд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Эмээлтийн тэр үйлдвэр, технологийн парк тэр эко парк бол ЗГ шийдвэр гаргаад тэрийг хэрэгжилтийг нийслэл дээр шилжүүлээд, тэгээд нийслэл түүнийг хариуцаад л явж байгаа. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд тэр 90 хувь ч гэнэ үү, хэд ч гэж гэнэ үү ингээд үнэлэгдсэн байдал үнэхээр эргээд харахад наадах чинь дэд бүтцийг нь шийдээгүй ийм тохиолдолд цаашаа хувийн хэвшил оролцох бололцоогүй шүү дээ. Тийм учраас нийслэл дээр шилжүүлээд, илүү хэрэгжилт рүү нь явж байгаа. Тэгээд өмнө нь дандаа л нэг өөрийгөө үнэлээд, бие биеэ хянадаг, үнэлдэг, тэр гүйцэтгэлийг үнэлдэг нэг хувийн хэвшлийн хийдэг 360 градус гээд л энэ чинь гүйцэтгэлийн үнэлгээ ахисан түвшинд оччихсон байхад төр өөрөө өөрийгөө үнэлээд л, тэгээд л нэг хэдэн хүнд харуулах маягтай яваад байсныг бид сая ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр дээр төлөвлөлт, төсөвлөлт, хяналтыг нэгтгэнэ, нэг тогтолцоо руу шилжүүлнэ гэсэн. Тэгэхээр шинэ энэ зорилтынхоо дагуу үнэлэх тогтолцоо хэрэгжинэ гэдгийг л хэлье.

Д.Амарбаясгалан: Дахиж тодруулж асууна гэж байна. Мэндбаярын Мандхай гишүүнд микрофон өгье.

М.Мандхай: Би ингэж хэлэх гээд байгаа юм л даа. Үнэлгээгээ тодорхой болгоогүй учраас ер нь энэ төсөл өөрөө энэ жил хэрэгжих ёстой 100 хувийн гүйцэтгэлтэй төслүүд нь хэрэгжихгүй, хэрэгжээгүй эсвэл хангалтгүй байгаа эрсдэлийг дараа нь яах вэ гэдэг асуудлыг л ер нь хөндөх гээд байгаа юм. Тэр нь тэрнээс биш энд 90 хувь байна уу, 50 хувь гэдэг чинь өөрөө утга учиргүй байхгүй юу. Явсаар байгаад 4 жилийн дараа энэ 100 хувь хэрэгжиж дуусах ёстой төсөл маань өөрөө энэ үнэлгээ нь тодорхойгүй, бид үнэлж хянаж чадахгүй ийм байхад энэний цаана өчнөөн олон тэрбум, их наяд төгрөгийн зарцуулалт гараад явж байгаа учраас яах вэ гэдэг эрсдэлийг бид ярьж эхлэх шаардлагатай байгаа.

Тэгэхээр энэ дээр та энэ дээр хэрэв одоо энэ үнэлгээг бид харчихлаа. Ирэх жилийн үнэлгээг дахиад харна. Ингээд энэ эрсдэлүүдийг яах юм бэ? Хангалтгүй явсан эрсдэлүүдээ тэгвэл яаж бид энэ төсөв, өчнөөн олон төсөв.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Учрал сайд гүйцээж хариулъя.

Н.Учрал: Тийм, энэ Мандхай гишүүн зөв яриад байгаа юм л даа. Тийм бид бүгдээрээ л хувийн хэвшилд ажиллаж байсан. Зүгээр ер нь нэг ААН байгууллагууд гүйцэтгэлийг яаж үнэлдэг вэ, үр дүнгээ яаж хэмждэг вэ дэндүү мэднэ. Төрийн албанд хоорондоо ийм нөгөө эрх зүйн орчны хийдэл, давхардал байсан, түүнийг цэгцэлсэн. Эмээлтийн хувьд зүгээр мэдээлэл авахад дэд бүтэц нь дээр нь тодорхой санхүүжилт тавихгүй яваад ирчихсэн юм байна лээ. Дэд бүтэц дээр. Тэгээд санхүүжилт байхгүй ажил урагшлуулахгүй. 2024 онд дулааны цахилгаан станц, цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ-г нь уг нь боловсруулсан юм байна лээ. Тэгэхээр санхүүжилтийнх нь моделийг нь боловсруулаад, нэгэнт батлагдсан ТЭЗҮ байгаа бол үргэлжлүүлээд энэ ажлыг явуулъя гэдэг зорилтоор энийг нийслэл дээр Эмээлтийн эко паркийг нэгж болоод ингээд байгуулагдаад төслийг хариуцаад явж байгаа.

Д.Амарбаясгалан: Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Надад Эдийн засгийн хөгжлийн яам болон Боловсролын яамтай холбоотой 2, 3 асуулт байна. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан төсөл, арга хэмжээнд өнгөрсөн хугацаанд 20,5 их наяд төгрөгийг зарцуулсан байгаа. Энд хийгдсэн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцох боломжгүй байгаа юм уу? Яагаад тооцоогүй юм бэ? Өнгөрсөн төсөв дээр би төсөв баталж байх цаг хугацаанд хэлж байсан. Бид энэ төсөвт тусгаж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудыг эрэмбэлэх хэрэгтэй байна. Эрэмбэлж ангилахдаа үр өгөөжийг тооцож, үр ашгаас нь хамгийн их өгөөжтэйгөөс нь эхэлж хэрэгжүүлдэг болмоор байна гэж. Тэгэхээр гүйцэтгэлийг гаргахдаа ч гэсэн энэ үр өгөөж ямар байгаа юм бэ гэдэг дээр яагаад эрэмбэлэлд, ангилалт хийгдэхгүй байгаа юм бэ? Энэ дээр нэг тодорхой тайлбар өгөөч гэж.

2 дугаарт 5 жилийн үндсэн чиглэлд тусгасан арга хэмжээний 65,4 хувь нь бүрэн хэрэгжээгүй гэж байгаа юм. Үүнд нөлөөлсөн шалтгаан хүчин зүйлүүдийг аваад үзэхээр үндсэндээ масс нь дийлэнх нь дандаа яамдын ажлын хариуцлагатай холбоотой байна. Ажлын уялдаа холбоо хангагдаагүй байна, баримт бичиг бүрдүүлбэр дутуу байна, шалгуур үзүүлэлтээ тодорхой болгоогүй байна гэсэн ийм зүйлүүд. Эргээд нөгөө хөрөнгө санхүүгээс болж шалтгаалж хойшилж байгаа ажлууд харьцангуй бага хувийг эзлээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энд хариуцлагын механизм гэж ер нь байна уу, ямар хариуцлага тооцдог юм бэ? Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 6.5-д зааснаар 10 жилийн хугацаанд хэрэгжих төсөл, юу хөтөлбөрүүдийг бид боловсруулах ёстой 8 хөтөлбөр. Энэ хөтөлбөрүүд ер нь хэзээ эцэслэн боловсруулагдаж батлагдах вэ? Нэгдсэн бодлого, төлөвлөлт 10 жилийн хугацааны энэ хөтөлбөрүүд хэзээ гарах вэ гэдгийг тодруулъя.

Боловсролын яамнаас энэ ЗГ-ын 2 тогтоолтой холбоотой нэг асуулт байгаа юм. 2021 оны 321 дүгээр тогтоол, ЗГ-ын тогтоол. Энэ тогтоолоор хөдөө орон нутагт их, дээд сургуулиудыг байгуулах нь зүйтэй гэж ЗГ-аас үзээд Дарханд, Эрдэнэтэд,

Өмнөговьд сургуулиудын салбаруудыг өргөжүүлэх, шинээр байгуулах асуудлыг зохицуулсан. Энэ зохицуулалт дотор орон нутагт ажиллаж одоо ажиллаж байгаа төрийн өмчийн энэ их, дээд сургуульд суралцаж байгаа оюутнуудын сургалтын төлбөрийн 50 хувийг хөнгөлөх төр даах тухай зохицуулалт орсон байгаа. Энэ асуудлыг тухайн жил тутамд нь улсын төсөвт суулгаж явахыг Боловсролын сайдад үүрэг болгосон байдаг. Энэ хэрэгжээд явж байсан, 24 оны 102 дугаар тогтоол 24 оны 4 сард байх 102 дугаар тогтоол гарсан. Энэ тогтоол болохоороо Боловсролын зээлийн сантай холбоотой асуудлыг зохицуулахдаа нөгөө 50 хувиар хөнгөлөгдөх ёстой асуудлыг маань амьжиргааны баталгаажих түвшин хүрээгүй бол гэдэг байдлаар ингээд давхардсан 2 өөр хувилбартай ийм заалт орчихсон.

Өөрөөр хэлбэл хүчин төгөлдөр байгаа өнөөдөр хүчин төгөлдөр байгаа ЗГ-ын 2 тогтоол 2 өөр зохицуулалттай. Орон нутагт байгаа их, дээд сургуулиуд Боловсролын яамнаас энэ 50 хувийн хөнгөлөлтийн санхүүжилтээ авъя гэнгүүт сүүлийн буюу 24 онд батлагдсан энэ журмаа барина гээд явуулчихдаг. Өмнө нь нөгөө 3 их, дээд сургууль орон нутагт байгуулахаар шийдвэр гаргасан 321 дүгээр тогтоолыг яах ёстой юм бэ? Яг энэнээс болоод 50 хувийн хөнгөлөлтийг бодоод ялангуяа энэ төвлөрлийг сааруулъя, Улаанбаатар хотод байгаа энэ төвлөрлийг орон нутаг руу сааруулъя, их, дээд сургуулиудыг орон нутаг руу шилжүүлэе гэдэг энэ бодлого маань өөрөө хэрэгжих боломжгүй болж, одоо нөгөө 50 хувийн хөнгөлөлтөд болоод орчихсон, хөдөө орон нутгийн сургуульд орчихсон оюутнууд өнөөдөр 100 хувиар төлбөрөө төлөх болчихоод, яагаад төр засаг ийм тогтворгүй шийдвэр гаргаад байгаа юм бэ гэдэг дээрээ хүртэл тулж байна. Тэгэхээр энэ тал дээр тодорхой хариулт өгөөч?

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Эдийн засаг, хөгжлийн яам ТНБД Батхүү, ажлын хэсгийн 5 дугаар микрофон.

И.Батхүү: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. 8 хөгжлийн зорилт хөтөлбөрүүдийг өмнө нь төслүүдийг нь боловсруулаад Улсын Их Хуралд өргөн барьсан байсан. Тэгээд Улсын Их Хурлаас буцаагдсан, сайжруулалт хийгдэж байгаа шалтгаан бол Улсын Их Хурлын сонгуультай холбоотой, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр шинээр боловсруулагдсан. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шинээр боловсруулсан гээд олон бодлогын баримт бичгүүд давхар явж байсан учраас нийцүүлэх шаардлагатай гэж үзээд буцаасан байгаа. Үүн дээр нэмэгдээд Шинжлэх ухааны тухай хуульд заасан зорилтот хөтөлбөрийг нэмж боловсруулж байгаа.

Энэ улсын хөгжлийн зорилт, хөтөлбөр боловсруулахдаа улсын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахтай холбоотой хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг эрэмбэлдэг. 1 дүгээрт хуульд заасан арга хэмжээнүүд нийцсэн эсэх хуулийн шалгуураар авч үзнэ. Жишээ нь 2024 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах явцад 1500 орчим төсөл, арга хэмжээний санал 80 их наяд төгрөгийн санал ирсэн. Эдгээр төслүүдийг бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдаатай байдал, хуулийн шаардлага хангасан байдал, бэлэн байдал гээд олон шалгуур үзүүлэлтийг харгалзаж эрэмбэлээд оруулсан байгаа. Яг одоо хэлэлцэгдээд явж байгаа баримт бичиг дотроо төсөл, арга хэмжээний бичигдсэн дараалал бол эрэмбийг харуулахгүй байгаа нөөц бололцоо, эх үүсвэртээ нийцсэн байдлаар эрэмбэлсэн төслүүдэд бүгдийг нь оруулсан байгаа.

Д.Амарбаясгалан: Бусад асуултынхаа хариултыг авна шүү дээ. Боловсролын яам Наранбаяр сайд хаачсан бэ, ТНБД байна уу, хүлээж байх уу? Хяналт хариуцлагатай холбоотой асуудлаар Учрал сайд, дараа нь Одбаяр сайд.

Н.Учрал: Боловсролын яамны энэ зүгээс Засгийн газрын 21 оны 10 дугаар сарын 20-ны тогтоол байдаг. Нөгөө Их, дээд сургуулийг сургалт, эрдэм шинжилгээний цогцолбор болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай гээд. Тэгэхээр сая хамтарсан ЗГ байгуулагдахдаа энэ орон нутагт их, дээд сургуулиудыг байгуулах асуудлыг дэмжинэ гэж зорилтыг дэвшүүлсний дагуу бид энэ хавар хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг зарлаад, түүнд нийцсэн нийлүүлэлтийг хийх санхүүжилтийг Боловсролын зээлийн сан дээр хийе гэж ингэж бодлого боловсруулж байгаа юм. Нэг ёсондоо эрэлттэй мэргэжлүүдээр болоод хөдөө орон нутаг дахь тодорхой мэргэшсэн мэргэжлүүдээр элсэлт авахад зээлийн сангаас тэтгэлгээр 100 хувь санхүүжүүлэх бодлого хэрэгжүүлэхээр Боловсролын сангийн зээлийн сангийн өөрчлөлтийг хийгээд явж байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Үүрийнтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Үүрийнтуяа: Энэ 2 ЗГ-ын тогтоол өнөөдөр хоёулаа хүчин төгөлдөр байгаад байгаа юм Учрал сайдаа. Тэгэхээр сая Боловсролын зээлийн сангийн асуудлыг манай Их Хурлын гишүүд ажлын хэсэг байгуулаад нэлээдгүй ажиллалаа. Тэгэхээр энэ ажиллаж байгаа энэ өөрчилж байгаа асуудал дээрээ үүнийг анхаарч үзээч. Таны авч хэрэгжүүлээд байгаа энэ давхардаж байгаа, ялангуяа хоорондоо уялдахгүй байгаа олон дүрэм журмыг цэгцэлж байгаа энэ ажлын чинь хүрээнд хийгдэх нэг ажил бол энэ болчхоод байгаа юм. Өнөөдөр орон нутагт их, дээд сургуульд элсээд, төлбөрөө төлөөд 50 хувийнхаа хөнгөлөлтийг авна гэж эдийн засгаа тооцоод орчихсон маш олон хүүхдүүд энэ дээр хохирогч болж үлдээд байна. Гэтэл энэ журам нь өөрөө өнөөдөр хүчин төгөлдөр хэвээрээ байгаад байна. 321 дүгээр журмаар тогтоолоор баталсан журмын 50 хувийг хөнгөлөх заалт нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр хэвээрээ байгаад байна. Тэгэнгүүт 24 онд гаргасан журмаа барина гээд яам нь бичиг өгчхөөд, тэр бичгээр л санхүүжилтийг зогсоочхоод байна. Энэ асуудлыг нэг тусгайлан авч үзээч гэж хүсмээр байна нэг.

Д.Амарбаясгалан: Санал хэлчихлээ. Юу яадаг юм уу даа, одоо ингээд 30 гишүүн асуулт асуухаар байгаа. Тэгээд зарим сайдууд гадаадад томилолттой, зарим сайдууд нь орон нутагт ажил зохион байгуулж байгаа гээд, зарим нь хэлж ярихгүй ирээгүй энэ тэр байгаа шалтгаанууд их байгаад байна. Ер нь тэгээд Засгийн газар Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудал долоо хоногийн өмнө Даргын дэргэдэх зөвлөлөөр тов дараалал тогтчихдогийг хараад, өөрийнхөө ажлыг төлөвлөдөг байх нэг дэх зарчим дээр хатуу барьж ажилладаг байх нэг дэх шаардлагыг Улсын Их Хурлаас тавьж ажиллах нь зүйтэй. 2 дугаарт тухайн асуудал эрхэлж байгаа сайд хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж зайлшгүй байлцаж байх энэ зарчмыг Улсын Их Хурал баримталж ажиллана. Тэгэхгүй урьдын адил нэг нь асуусан болдог, нөгөөдөх нь хариулсан болдог, бодитой үр дүн гардаггүй. Дараа жил орж ирээд л яг өдийд ахиад л энэ асуудлыг, ийм сэдвийг хөндөөд сууж байдаг энэ байдал засрахгүй гэдэг нь ойлгомжтой харагдаж байгаа учраас өнөөдөр хариулт, асуултын аль алиных нь чанар, үр дүнг бодолцон үзээд өнөөдрийн чуулганыг ингэж өндөрлүүлээд, нэг дэх өдөр өглөө 10 цагаас чуулганы хуралдаан үргэлжилнэ.

15.51 цаг

Дахиад хэлэхэд долоо хоногийн өмнө Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлын тов дараалал тогтдог. Үүнтэй холбогдуулж салбарын яам, Засгийн газар ажлаа төлөвлөж байх ёстой. Өнөөдөр Ерөнхий сайд хүртэл өглөө хөдөө явах ёстой байсан ажлаа хойшлуулаад орж ирээд, өөрийнхөө гүйцэтгэх ёстой үүргээ гүйцэтгээд, дараачийнхаа ажлыг зохицуулаад явж болж байна. Тэгээд үүнтэй холбоотой өнөөдөр Эдийн засгийн хөгжлийн сайд байхгүйгээр, Сангийн сайд байхгүйгээр бид энэ улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын асуудлыг асууж, хариулт авч сууна гэдэг утгагүй асуудал гэж бодож байна. Тэгэхээр Улсын Их Хурал цаашдаа ийм зарчмыг хатуу баримтална. Улсын Их Хурлын Тамгын газар ч гэсэн энэ хурал зохион байгуулахдаа холбогдох албан тушаалтныг зайлшгүй байлцуулах тал дээр анхаарна. Хэрвээ албан тушаалтан байхгүй тохиолдолд уг асуудлыг хэлэлцэхгүйгээр хойшлуулж байна гэдгийг хариуцлагатай хэлье.

Өнөөдрийн чуулган өндөрлөлөө.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА